



“МОНГОЛ УЛСАД ТАЙВАН ЗАМААР ЖАГСАХ, ЦУГЛАХ ЭРХИЙГ
ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ КЭЙС СУДАЛГАА

IRIM судалгааны хүрээлэн нь Монгол Улсад мэргэжлийн, хараат бус судалгааг институтийн түвшинд, тогтвортой хэрэгжүүлж буй анхны байгууллагуудын нэг юм. Бид сүүлийн жилүүдэд ардчилал болон иргэний орон зай, иргэний эрхийн чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд энэ удаа Ашгийн Төлөө Бус Хуулийн Олон Улсын Төв (ICNL)-ийн санхүүжилтээр Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Монгол Улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг бэхжүүлэх нь” төслийн судалгаа, мэдээлэл бүрдүүлэлтийн ажлыг хариуцан гүйцэтгэлээ.

Бидэнтэй холбогдох

Цахим шуудан: contact@irim.mn

Фейсбүүк/ Твиттер хуудас: @IRIMongolia

Вэбсайт: www.irim.mn

Тайланг эш татах

IRIM (2024), “Монгол Улсад зохион байгуулагдсан жагсаал цуглааны кэйс судалгаа” Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн

Тайлан бичсэн:

Лхагваноровын Дашзэвэг, Зоригтбаатарын Энхбаяр, Найдансүрэнгийн Нандинцэцэг
Ганбаатарын Даваа

Хянасан:

Дэмбэрэлийн Оросоо

Эх бэлтгэл, дизайн

Ганбаатарын Даваа

Нүүр зургийн эх сурвалж

Noise media art

Мэдэгдэл

Энэхүү тайлангийн агуулга нь судалгааны багийн гаргасан дүн шинжилгээний үр дүн ба IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно

АГУУЛГА

Удиртгал	3
Судалгааны арга зүй.....	3
Сонгосон жагсаал, цуглаан.....	4
Мэдээлэл цуглуулсан арга	5
НЭГ. ДОЛООН САРЫН НЭГНИЙ ТҮЙВЭЭН.....	6
ХОЁР. #NO ТОДОТГОЛТОЙ ЦУВРАЛ ЖАГСААЛ	16
ГУРАВ. ЕРӨНХИЙ САЙД ОГЦОРСОН ЖАГСААЛ	24
ДӨРӨВ. "МОНГОЛОО АВАРЪЯ" НЭРТЭЙ ЖАГСААЛ.....	34
ТАВ. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДЫН СУУЛТ, ЖАГСААЛ	40
ЗУРГАА. "МОНГОЛДОО САЙХАН АМЬДАРЪЯ" ЖАГСААЛ.....	47
ДОЛОО. "ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ -ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХЭЭ ЭДЭЛЬЕ" ЖАГСААЛ.....	57
НАЙМ. ШОГУКАН ХЭВЛЭЛИЙН КОМПАНИЙН ГАДНАХ ЖАГСААЛ	64
ЕС. ОРОН НУТАГТ БОЛСОН ЖАГСААЛ	71
АРАВ. ГАЛ ҮНДЭСТЭН ХОЛБООНЫ ЖАГСААЛ	78

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль 1994 онд анх батлагдсанаас хойш таван удаа шинэчлэгдсэн ч жагсаал, цуглааны үеэр хүний эрх зөрчигдөх, гэмт хэрэг, зөрчлүүд гарсаар байна¹.

Монгол улсад 2020-2022 оны хооронд 710 жагсаал, цуглаан зохион байгуулагдсан ба ХЭҮК-ийн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан томоохон жагсаал, цуглаанд хийсэн ажиглалтад үндэслэн "Монгол Улсад хүний тайван жагсах, хуран чуулах эрх чөлөөгөө эдлэх баталгаа хэврэг, энэ орон зай хумигдах эрсдэлтэй байна². Тиймээс Монгол улсад тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд ХЭҮК, Хууль зүйн үндэсний хүрээлэн, судлаачид дүгнэлт хийжээ. Тухайлбал, (Мөнхсайхан, 2017) цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ноцтой зөрчсөн гурван тохиолдлыг онцлон тэмдэглэжээ: (i) аяндаа үүссэн цуглааныг хүлээн зөвшөөрдөггүй; (ii) жагсаал цуглаан жагсаал цуглаан хийх мэдэгдлийг бүртгүүлэх гэсэн нэртэй боловч эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авах тогтолцоог хуульчилсан;

Дүрс 1. Төслийн бүрэлдэхүүн хэсэг

Бүрэлдэхүүн 1: Тайван замаар цуглах эрхийн хүрээнд иргэдийг чадавхжуулах

Бүрэлдэхүүн 2: Тайван замаар цуглах эрхийг хамгаалах хуульчдыг чадавхжуулах

Энэхүү баримт бичиг нь Бүрэлдэхүүн 1: Тайван замаар жагсаал, цуглаан хийхэд иргэдийг чадавхжуулах ажлын хүрээнд

(iii) бүртгэлгүй цуглааныг албадан тараахдаа хуульчилсан журмыг цагдаа нар дагаж мөрдөхгүй байх.

Иймд иргэдийг жагсаал, цуглаанд оролцох бэлтгэлийн талаар нарийн мэдээлэлтэй болгох нь нэн чухал. Үүнд ийм үйл явдлын үеэр болон дараа нь тэдний эрх чөлөө, аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, асуудал тулгарвал шийдвэрлэх зэрэг орно. Энэ нь иргэдийн тайван замаар цуглах эрхийг хангахад амин чухал юм.

Иргэд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас болж жагсаал, цуглаан хийх эрх зөрчигдөж байна. Иймд иргэдийн жагсаал, цуглаан хийх эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор энэхүү ажлыг эхлүүлсэн билээ. Үүний зэрэгцээ тайван жагсаал цуглаан хийх эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулж, эдгээр эрхийг хамгаалахад хуульчдын чадавхыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Үүний хүрээнд IRIM судалгааны хүрээлэнгээс Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ICNL сангийн дэмжлэгтэйгээр "Монгол улсад тайван замаар жагсах, цуглах эрхийг бэхжүүлэх нь" төслийг хэрэгжүүлж байна. Төсөл нь дараах хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

ашиглагдах кэйс судалгааг хэрхэн гүйцэтгэсэн талаарх арга зүйн мэдээллийг товч танилцуулсан.

¹ 1 Хууль зүйн үндэсний хүрээлэн, "Жагсаал цуглаан хийх журмын тухай" хуулийн харьцуулсан судалгаа, 2022, УБ

² Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2022

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго: Өмнө болсон жагсаал, цуглаануудын туршлага, сургамжийг судалж, түүний үр дүнд үндэслэн цаашид анхаарах зөвлөмж бүхий гарын авлага боловсруулан олон нийтэд түгээж, иргэдийн жагсаал, цуглааны талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэхэд

хувь нэмэр оруулах зорилготой. Мөн судалгааны багийнхан эдгээр чуулганы үеэр тохиолдож болох хүний эрхийн зөрчил, эмх замбараагүй байдал, эрсдэлийг сайтар судалж, ойлголтыг сайжруулах үүднээс нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 1. Кэйс судалгааны агуулгын хүрээ

№	Агуулгын хүрээ
1. Жагсаалын өмнөх бэлтгэл үе шаттай холбоотой мэдээлэл:	
1.1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан
1.2	Жагсаал цуглаан зохион байгуулахтай холбоотой мэдээллийг түгээсэн, олон нийтийг уриалж, татан оролцуулсан байдал
1.3	Жагсаал цуглааны мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлэх, зөвшөөрөл авсан байдал
2. Жагсаалын үеэрх зохион байгуулалттай холбоотой мэдээлэл:	
2.1	Зохион байгуулагдсан хугацаа, байршил, оролцогчдын тоо гэх мэт ерөнхий мэдээлэл
2.2	Зохион байгуулагчдын мэдээлэл (үйлдвэрчний эвлэл, иргэний нийгэм, иргэд, улс төрчид гэх мэт)
2.3	Тэмцлийн арга хэлбэр (жагсаал, суулт, шаардлага хүргүүлсэн байдал)
2.4	Олон нийт, хэвлэл мэдээлэл, цагдаагийн байгууллага, шаардлага хүргүүлэгч талтай харилцсан байдал
2.5	Жагсаалын үеэр хүлээгдээгүй эрсдэл, эмх замбараагүй байдал үүссэн эсэх
2.6	Дэмжлэг (нийгэм, олон нийт, хэвлэл мэдээлэл, хуульчид, улс төрийн хүчин гэх мэт)
3. Жагсаалын дараах үр дүнтэй холбогдох мэдээлэл	
3.1	Зорилгодоо хүрсэн эсэх
3.2	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх
3.3	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх
3.4	Засаг, захиргааны байгууллагаас албадан тараах шийдвэр гарсан эсэх

Кэйс судалгааны үр дүнд үндэслэн гарах тайлан, зөвлөмж нь дээрх агуулгыг багтаасан дараах 4 дэд бүлгээр боловсруулагдсан.

1. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

2. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

3. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

4. Жагсаал, цуглааны туршлага сургамж, анхаарах зүйлс

Сонгосон жагсаал, цуглаан

Судалгааны багийн зүгээс Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан 10 жагсаал, цуглааныг сонгон кэйс судалгаа хийж гүйцэтгэнэ. Жагсаал цуглааныг сонгохдоо дараах ерөнхий 3-н шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн.

- 1. Жагсаал зохион байгуулагдсан хугацаа:** Судалгааны хүрээнд гарах үр дүн, дүгнэлт, зөвлөмжийн цаг үетэй нийцэх байдлыг нь харгалзан сүүлийн 15 жилийн хугацаанд хамаарах жагсаал, цуглааныг сонгосон.
- 2. Жагсаал зохион байгуулагдсан байршил:** Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны байршил, бусад статистик мэдээлэл болон цаашид ашиглагдах хэрэгцээ шаардлагыг харгалзан ихэвчлэн Улаанбаатар

хотод зохион байгуулагдсан жагсаал, цуглаануудыг сонгон мэдээлэл цуглуулав. Мөн хөдөө орон нутагт болон гадаад улс оронд оршин суугаа монголчуудын зохион байгуулсан жагсаал цуглааны төлөөлүүлэн тус бүр 1 кэйс судалгааг сонгон авсан.

- 3. Жагсаалын хамрах хүрээ/ оролцогчдын тоо:** Жагсаал, цуглааны хамрах хүрээ, хэмжээгээр нь ангилсан хууль эрх зүйн болон бусад баримт бичиг хараахан байхгүй тул судалгааны багийн зүгээс жагсагч, цуглагчдын тоог 50 ба түүнээс дээш, доош гэсэн ерөнхий үзүүлэлтээр ангилан аль аль төлөөллийн жагсаалаас тэнцвэртэй сонгож судлахыг зорилоо.

Хүснэгт 2. Кэйс судалгааны жагсаалт

№	Жагсаал, цуглааны нэрс	Хугацаа	Оролцогчдын тоо	Байршил
1	Долоодугаар сарын нэгний түйвээн	2008	Их	Улаанбаатар
2	"Гал үндэстэн холбоо", "Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн"-ийнхий жагсаал	2012-2013	Дунд	Улаанбаатар
3	"Эвлэлдэн нэгдэх -хөдөлмөрлөх эрхээ эдэлье" жагсаал	2016	Их	Улаанбаатар
4	Япон дахь Монголчуудын Шогукан хэвлэлийн компанийн гаднах жагсаал	2018	Бага	Гадаад
5	Эмч, эмнэлгийн ажилтнуудын цалингаа нэмүүлэхийг шаардсан ажил хаялт, суулт	2021	Их	Улаанбаатар
6	Ерөнхий сайд огцорсон цуглаан	2021	Их	Улаанбаатар
7	Nodouble standart, Nonaadam, Nowar сэдэвт жагсаал, цуглаан	2021-2022	Их	Улаанбаатар
8	Монголоо аваръя	2022	Бага	Улаанбаатар
9	Орон нутагт болсон жагсаал, цуглаан	2022	Их	Орон нутаг
10	"Монголдоо сайхан амьдаръя, ажлаа хий" жагсаал	2022	Их	Улаанбаатар

Мэдээлэл цуглуулсан арга

Кэйс судалгаа нь чанарын мэдээлэл цуглуулалтын аргад төвлөрсөн бөгөөд баримт бичгийн шинжилгээ, контент анализ, гүнзгийрүүлсэн ярилцлагын ³ аргуудаар мэдээлэл цуглуулав.

Чанарын буюу кэйс судалгааны үр дүнг системтэйгээр тэмдэглэх, дүн шинжилгээ хийх, тайлагнахад ашигладаг хамгийн үр дүнтэй буюу түгээмэл хэрэглэгддэг арга нь үр дүнгийн матриц хөтлөх юм.

Судалгааны багийн гишүүд мэдээлэл цуглуулалт (холбогдох материалын судалгаа, контент анализ, ярилцлага, дугуй

ширээний ярилцлага)-ын явцаа тэмдэглэх, үр дүнг нэгтгэхдээ дүнгийн матрицын аргыг ашигласан бөгөөд судлаач бүр сонирхож буй мэдээллийн агуулга, төрлүүдээрээ кодолж, шинжилгээ хийх боломжтой байв. Мөн ярилцлагын аргаар цуглуулсан мэдээллийг зориулалтын программ (NVIVO, Atlas TI)-д шивж оруулан, нэмэлт шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Кэйс судалгааны тайлангийн зарим хэсгүүдэд судалгаанд оролцогчдын өгсөн ярилцлагын мэдээллийг шигтгээ хэлбэрээр оруулсан болно.

Дүрс 2. Кэйс судалгааны жагсаалт



³ Богино хугацаанд олон тооны жагсаал, цуглааны мэдээлэл цуглуулах шаардлагатай байсан тул ихэвчлэн баримт бичиг болон контент анализ хийх замаар кэйс судалгааны тайланг гаргасан бөгөөд зөвхөн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн

зарим тохиолдолд цөөн тооны ярилцлага зохион байгуулсан.

МОНГОЛ АРДЫН

НЭГ. ДОЛООН САРЫН НЭГНИЙ ТҮЙВЭЭН (2008)

Зургийн эх сурвалж:
24TSAG.MN

Зургийн эх сурвалж:
24TSAG.MN

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2008 оны 7 сарын 1 – 2008 оны 7 дугаар сарын 2
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай, МАХН (тухайн үеийн нэршлээр)-ын байрын өмнө
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	Монгол Улсын Их Хурлын 5 дахь удаагийн сонгуулийн үр дүнг хүчингүй болгох, санал хураалтыг дахин зохион байгуулуулах.
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Эрх баригч нам (МАХН), Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Ж.Батзандан, О.Магнай, Б.Жаргалсайхан, Ц.Элбэгдорж Зохион байгуулалтгүй иргэд, олон нийт
6	Оролцсон хүний тоо	9,000 орчим хүн
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Байхгүй



**vip76.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.*

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Монгол Улсын Их Хурлын 5 дахь удаагийн сонгууль, түүний урьдчилсан үр дүн
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Үгүй, жагсаал зохион байгуулагчдын зүгээс тухайн өдрөө иргэд, олон нийтийг цуглаанд уриалсан.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Үгүй
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Урьдчилсан бэлтгэлгүй
5	Улирал, цаг агаарын байдал	Зуны улирал

2008.6.29-ны өдөр болсон Монгол улсын Их хурлын сонгуульд Улс төрийн 11 нам, 1 эвсэл түүний 311 гишүүн, 45 бие даан нэр дэвшигчид нийт 356 иргэн 76 суудлын төлөө өрсөлдсөн юм. Урьдчилсан үр дүнгээр Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) 41 суудал, Ардчилсан Нам 29, бусад этгээд 4 суудал эзлэхээр урьдчилсан дүн гарчээ. Улсын Их Хурлын сонгуулийн дүн дээр дурдсан байдлаар гарсан хэдий ч “сонгууль шударга явагдаагүй, санал хураалт болон санал тоололт луйвартай болсон, олон тооны иргэний үнэмлэх хуурамчаар үйлдэж санал өгүүлсэн, иргэний үнэмлэх дээрх хаягийн бүртгэлийг сольж, санал давхардуулж өгүүлснээс иргэдийн сонголт зөв гарсангүй” гэж үзсэн нам, улс төрийн хүчнүүд 7 сарын 1-ний үдээс өмнө Улаанбаатар хот, Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийж эхэлсэн байна⁴.

Энэ цуглаан дээр Ардчилсан Намын Ц.Элбэгдорж, Бүгд Найрамдах Намын Б.Жаргалсайхан, Иргэний Хөдөлгөөний Намын Ж.Батзандан, О.Магнай нар үг хэлж шударга бус сонгууль болсон тул арт түмнийг сонгуулийн үр дүнг эсэргүүцэхийг уриалж байсан байна. Ингээд Батзандан, Магнай

болон бусад улсуудаар удирдуулсан иргэд МАХН-ын төв байрны өмнө очиж эсэргүүцэл илэрхийлэхээр хөдөлжээ⁵.

Үймээн самуун гарах болсон учир шалтгааныг нам, улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, иргэд өөр өөрсдийнхөөрөө тайлбарласаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллээс үзвэл жагсаал, цуглаан тайван замаасаа хальж хүчирхийлэл, үймээн самуун болж хувирсны шалтгааныг зарим нам, эвсэл, улс төрийн хүчин зориуд зохион байгуулсан, ихээхэн хэмжээний мөнгө, хөрөнгө гаднаас орж ирсэн, чулуу, мод, шатах, дэлбэрэх зүйлсийг зориуд авч ирсэн, мөнгө тараасан, цагдаа, тагнуулын ажилтнууд өөрсдөө зориуд зохион байгуулсан, Монголын нийгэмд шударга бус бусармаг явдал газар авч, ард түмний бухимдал дээд цэгтээ тулж, энэ байдлаа хууль бус замаар бусдын эрхийг хөндөж илэрхийлсэн гэх зэргээр янз янзаар тайлбарласаар байна. Үймээн самууныг зохион байгуулсан гэгдэх хүмүүсийн хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй, нөхцөл байдал тодорхойгүй байгаа, дээр дурдсан учир шалтгааны аль нь үнэн, аль нь худал

⁴ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

⁵ [Долоодугаар сарын нэгний түйвээн — Википедиа нэвтэрхий толь \(wikipedia.org\)](#)

болохыг одоогоор үнэлж дүгнэх боломжгүй байна⁶.

Тухайн жагсаал, цуглааны хувьд урьдчилан бэлдсэн, бэлтгэл ажил хангасан талаарх

ямар ч мэдээлэлгүй бөгөөд жагсаал, цуглаан болох тухай зарлал, уриалга явагдаагүй, хууль хяналтын байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл хүссэн тухай баримт байдаггүй.

7 сарын 1-ний жагсаал, цуглааны бэлтгэл үе шатад үүссэн асуудал, дүгнэлт:

- 1. Урьдчилан бэлтгээгүй, зохион байгуулалтгүй жагсаал, цуглаан зохион байгуулсан:** Жагсаал, цуглааны зөвшөөрөл олгох гэсэн ойлголтыг хуулийн хүрээнд бүртгэх, бүртгүүлэх гэсэн томъёогоор сольсон боловч бүртгүүлээгүй бол албадан тараах эрх зүйн зохицуулалт хэвээр байгаа нь үнэн хэрэгтээ “зөвшөөрлийн тогтолцоо” үйлчилсээр байгааг харуулж байна. Иймд уг жагсаал, цуглаан нь урьдчилан бүртгүүлээгүй, гэнэтийн байдлаар зохион байгуулагдсан тул жагсаалд оролцогчдыг албадан тараах, аливаа хуулийн хариуцлага хүлээх үндэслэл болох эрсдэлтэй байна.
- 2. Жагсаал, цуглааны албан ёсны зохион байгуулагч буюу хариуцагч этгээд тодорхойгүй:** Хэдийгээр албан бус мэдээллийн эх сурвалж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр уг жагсаал, цуглааныг Ж.Батзандан, О.Магнай, Б.Жаргалсайхан, Ц.Элбэгдорж гэх зэрэг хүмүүсийг зохион байгуулсан гэсэн мэдээлэл түгээмэл тархсан байгаа ч одоо хүртэл жагсаал зохион

байгуулагчийн хувиар хуулийн хариуцлага болон бусад шийтгэл хүлээсэн нотлох баримт байдаггүй⁷.

Иймд уг жагсаал, цуглааны олон нийтийн эмх замбараагүй байдал, зохион байгуулалтгүй нийтийг хамарсан түйвээн гэх зэргээр нэрлэх, үзэх хандлагууд байна.

- 3. МАХН нь сонгуулийн үр дүн эцэслэгдээгүй, урьдчилсан үр дүнд үндэслэн мэдэгдэл гаргасан, баяр тэмдэглэсэн явдал:** 6 сарын 30-аас 7 сарын 1-нд шилжих шөнө сонгуулийн урьдчилсан дүн гарах үед МАХН-аас өөрийн намыг үнэмлэхүй ялалт байгуулсан талаар мэдэгдэл гаргаж, намын дэмжигчид мөн баяр тэмдэглэсэн баримт, нотолгоонууд олон мэдээллийн эх үүсвэр дээр үлджээ. Энэ бусад нам, эвслийн гишүүд, дэмжигчдийн уур бухимдлыг төрүүлж, жагсаал цуглаан зохион байгуулах сэдэл болсон гэж үзэх хандлагуудыг зарим судлаач, нийтлэлчид илэрхийлсэн байна.

⁶ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

⁷ [Ж.Батзандан нарт хууль яагаад үйлчилсэнгүй вэ? \(24tsag.mn\)](http://24tsag.mn)

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Тэмцлийн хамгийн хурцадмал хэлбэр, нийтийн эмх замбараагүй байдал, нийтийг хамарсан үймээн самуун
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Тийм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Онц байдал зарлах тухай” зарлиг гарсан.
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Сэтгэл хөөрөл маш өндөр, , уриалан дуудах, хатуу шаардлага тавьж, ЗГ-ыг буруутгасан
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Тийм. 5 хүний амь нас хохирсон. Хууль сахиулагчид болон иргэдийн хооронд ноцтой зөрчилдөөн үүссэн. Онц байдал зарлаж, цагдаагийн байгууллага тухайн жагсаал, цуглаанд гол оролцоотой байсан иргэдийг баривчилсан.
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Тухайн үед нийгмийн цахим сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд төдийлөн хөгжөөгүй байсан тул олон нийтийн зүгээс ямар хандлагатай байсан, дэмжлэг хэр байсан болохыг тодорхойлох боломжгүй байна. Жагсаалд 9000 орчим хүн оролцсон нь тухайн жагсаал, цуглаанд иргэд, олон нийтийн зүгээс оролцсон дэмжлэг байна гэж үзэж болно.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Тухайн жагсаал, цуглааныг хэн нэгэн санхүүжүүлсэн талаарх баримт нотолгоо байхгүй. Их хэмжээний мөнгө тараасан, гаднын санхүүжилтээр зохион байгуулагдсан, мод, чулуу, шатах материалыг зориуд авч ирсэн гэх мэт зардал, санхүүжилттэй холбоотой олон төрлийн таамаг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тархсан байдаг ч батлагдсан, эцэслэн шийдвэрлэгдсэн зүй байхгүй
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

Тухайн өдрийн 13.00 цагт Монголын хэвлэлийн хүрээлэнгийн хурлын танхимд Б.Жаргалсайхан, Ж.Батзандан, О.Магнай нар сонгуулийн үр дүнтэй холбоотой асуудлаар хэвлэлийн бага хурал зарласан бөгөөд түүний дараагаас Сүхбаатарын талбай, МАХН-байрны үүдэнд олон нийт цугларч, жагсаал, цуглаан үүссэн баримтууд байна⁸.

Хүмүүсийн жагсаал нь Сүхбаатарын талбайгаас МАХН-ын байр луу чиглэсэн. Үдээс хойш хүмүүс МАХН-ын байрны гадаа очиж үг хэлж, уулзах шаардлага тавьсан. Гэвч МАХН-аас албаны хүн гарч ирээгүй бөгөөд энэ үед цагдаа нар ирж намын байрыг хамгаалан дотогш нэвтрэх гэсэн хүмүүст саад хийж эхэлсэн. Хүмүүс цагдаа нартай зодолдож, чулуу шидэж, цагдаа

нар бороохой хэрэглэж байсан. Улмаар хүмүүс хүч түрэн МАХН-ын байр луу нэвтрэн орсон. Энэ үйл явдлыг Улаанбаатар хотод хэд хэдэн ТВ-ээр шууд дамжуулсан. Энэхүү үйл явдалд олон мянган иргэд ирж оролцсон⁹.

Амгалан байдлаар эхэлсэн жагсаал нь сүүлдээ хүчирхийлэл үймээн болж хувирсан. Хаанаас эхэлсэн нь тодорхой бус гал түймэр гарч, намын байр шатаж эхэлсэн. Тэд тус байрны доод давхарт байдаг дэлгүүрүүд болон бусад газруудыг эвдлэн сүйтгэж, эд зүйлсийг хулгайлан авч эхэлсэн байна. Цагдаа нар хүч нэмэгдүүлэн резинэн сумтай буу ашиглан жагсагчид руу буудаж эхэлсэн. Ерөнхийлөгч Н.Энхбаяр улс төрийн намуудын дарга нартай яаралтай уулзалт

⁸ [7 жилийн өмнөх 7 сарын 1 \(vip76.mn\)](http://vip76.mn)

⁹ [Долоодугаар сарын нэгний түйвээн — Википедиа нэвтэрхий толь \(wikipedia.org\)](https://en.wikipedia.org/wiki/2013_Mongolian_protests)

хийн, 24.00 цагаас онц байдал зарлах шийдвэр гаргасан. Онц байдал зарлаж буй талаар ТВ-ээр мэдээлэл хийсэн¹⁰. Онц байдал зарласантай холбогдуулан армийн цэргүүд Улаанбаатар хотод орж ирэн үүрэг гүйцэтгэсэн. 7 сарын 1-ээс 2-нд шилжих шөнө жагсагчид руу байлдааны зэвсэг хэрэглэсэн явдал гарсан бөгөөд 4 хүн буудуулж, 1 хүн түймэрт өртөж нас барсан байна.

Жагсагчид Монгол ардын хувьсгалт намын байрнаас гадна түүний хойно орших Соёлын төв өргөөний зарим хэсэг буюу Уран зургийн галерейг шатааж, Улсын филарманийн эд хөрөнгийг нь дээрэмдсэн, ойролцоо байсан иргэдийн машины 5-ыг нь шатааж, 20-ыг нь эвдэлж хэмхэлсэн. Олон нийтийн эмх замбараагүй байдлын улмаас 5 иргэн амь насаа алдаж, албан үүргээ гүйцэтгэж байсан онцгой байдлын албаны 4, цагдаа, дотоодын цэргийн 393 алба хаагч, түүнчлэн 401 иргэний бие эрхтэнд гэмтэл учирч, 155 иргэн, 118 аж ахуйн нэгжид 11.291.698.871 төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсан байна¹¹.

7 сарын 1-ний жагсаал, цуглааны үед үүссэн асуудал, дүгнэлт:

- 1. Жагсагчид, манлайлагчдын зүгээс хүчирхийлэл, эмх замбараагүй байдалд чиглэсэн үг, уриалга ашигласан:** Жагсаал, цуглааны үеэр “МАХН-ыг газартай нь тэгшилье”, “Намын байрыг нураая” гэх зэрэг олон нийтийг эмх замбараагүй, үймээн самуунд өдөөн хатгасан уриалга, үг лоозон ашигласан талаарх дүрс бичлэг, нотлох баримт байна. Цугласан олны сэтгэл зүй, тогтворгүй, хэт хөөрсөн сэтгэл зүйтэй жагсаал цуглааны үед олон нийтийг хууль бус, гэмт хэргийн шинж чанартай зүйлд уриалах нь бодит байдалд биеллээ олох өндөр эрсдэлтэй байна¹².

- 2. Шаардлага хүргүүлэгч тал буюу МАХН болон СЕХ жагсаал цуглаанд оролцогчидтой хэлцэл, зөвшилцөл үүсгэхийг хүсээгүй, шаардлагыг анхаарч үзээгүй байдал:** Жагсаал, цуглаанд оролцогчид МАХН, болон СЕХ-ны байрны гадна очиж, удирдлагуудыг нь өөрсөдтэй уулзах шаардлага тавьсан байна. Тухайн үед МАХН-ын дарга, МУ-ын Ерөнхий сайд байсан С.Баяр болон бусад удирдах албан тушаалтнуудаас жагсагчдын төлөөлөлтэй уулзалт хийгээгүй, тавьсан шаардлагатай холбоотой хэлцэл, зөвшилцөл үүсгэх талаар санаачилга гаргаагүй нь жагсаал, цуглааныг үймээний хэмжээнд хүргэхэд нөлөөлсөн гэж зарим судлаач, нийтлэлчид үзжээ.

- 3. Цагдаагийн байгууллагын олны хамарсан үймээн самууныг даамжруулахгүй, хохирол багатай таслах зогсоох арга барил, зохион байгуулалт дутсан:** Цагдаагийн байгууллага хэлэлцээр хийх, баривчлах, шалган нэвтрүүлэх гэх мэт бүлгүүдийг зохион байгуулж ажиллуулж чадаагүй байна. Жагсаал, цуглаан олныг хамарсан галдан шатаасан, дээрэм тонуул хийсэн үймээн самуун болгохгүйгээр, гарз хохирол бага, онц байдал зарлах хэмжээнд хүрэхгүйгээр таслан зогсоох, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүргээ цагдаагийн байгууллага хангалтгүй биелүүлсэн гэж зарим байгууллага, иргэд үзэж дүгнэж байгааг ч хүлээн зөвшөөрөх үндэстэй¹³.

- 4. Мэдээллийг олон нийтэд тэнцвэртэй, түргэн шуурхай хүргээгүй:** Онц байдлыг зарлахдаа Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад хэвлэл мэдээллийн бие даасан хэрэгслийн

¹⁰ [Долоодугаар сарын нэгний түйвээн — Википедиа нэвтэрхий толь \(wikipedia.org\)](#)

¹¹ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

¹² Монголын олон нийтийн эсэргүүцлийн социологийн шинжилгээ, Доктор Ч.Тамир, 2018 он

¹³ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

үйл ажиллагааг түр зогсоосон нь мэдээллийн тэнцвэргүй хомс байдлыг үүсгэж, бодит байдлыг бүрэн дүүрэн харуулаагүй мэдээллийг нийгэмд цацах нөхцөлийг бүрдүүлсэн. Онц байдал зарлагдсан талаарх мэдээллийг

нийтийн эмх замбараагүй байдалд оролцогчид болон бусад иргэдэд хангалттай хүргэх арга хэмжээ аваагүйгээс үүдэн гэм зэмгүй иргэд хилсээр баривчилгаанд өртөж хохироход хүргэсэн байна¹⁴.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Жагсаал цуглаан үндсэн зорилгодоо хүрээгүй. Хүний амь эрсэдсэн, онц байдал зарлах түвшинд хүрсэн тул асуудал намжсан. Тавигдсан шаардлага буюу сонгуулийн үр дүнг хүчингүй болгох, сонгуулийг дахин явуулах гэсэн үндсэн шаардлагууд биелэгдээгүй
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Эрх баригчид болон шаардлага хүргүүлсэн нам (МАХН)-ын удирдлагууд жагсаал зохион байгуулагчдын төлөөлөл болон олон нийттэй уулзалт, зөвшилцлийн үйл ажиллагаа огт хийгээгүй.
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Албадан тараах шаардлага бүхий цагдаагийн хүчний байгууллагын үйлдлүүд удаа дараа гарч байсан.
4	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Хүний эрхийг зөрчсөн олон тооны зөрчил гарсан. Зөрчлийн үр дагавар, ач холбогдол маш өндөр буюу амьд явах эрх зөрчигдсэн гэж үздэг.
5	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	450 гаран хүн сэжиглэгдэн шалгагдаж, 300 орчим хүн яллагдагчаар татагдан, 244 иргэнд шүүхээс ял оноосон.

Эмх замбараагүй байдлыг таслан зогсоохоор 2008.7.1-ний өдрийн 24 цагаас эхлэн 4 өдрийн хугацаатай зарласан Онц байдлын зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлигийг биелүүлэх явцад бүрэн биш тоогоор 20 –иод хүн шархдаж, 4 хүн галт суманд хороогдож, 1 хүн угаартаж нас барсан юм.¹⁵

“7 сарын 1-ний буюу Үймээн самууны хэрэг” хэмээн нэрлэгдсэн нэг гэмт хэрэгт 450 гаран хүн сэжиглэгдэн шалгагдаж 300 орчим хүн яллагдагчаар татагдан 270 орчим иргэнийг “2008 оны 6 сарын 29 ний

өдрийн УИХ-ын сонгуулийн дүнг эсэргүүцэж зарим нам, хөдөлгөөнөөс зохион байгуулсан жагсаал цуглаанд оролцож МАХН-ын төв байр, СТӨ-ний байр руу дайрч түйвээн үймүүлэх, эвдэн бусниулах, галдан шатаах эд хөрөнгө устгах, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг бий болгон” оролцсон гэх үндэслэлээр шүүхээс 6 сараас 5 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн¹⁶.

¹⁴ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

¹⁵ Долоон сарын нэг ба хүний эрхий зөрчил, Монголын төрийн бус байгууллагын форум, 2009

¹⁶ Долоон сарын нэг ба хүний эрхий зөрчил, Монголын төрийн бус байгууллагын форум, 2009

7 сарын 1-ний жагсаал, цуглааны дараа үүссэн асуудал, дүгнэлт:

Монгол Улсын Хүний эрхийн комиссоос гаргасан “Монгол Улс дахь Хүний эрх, эрч чөлөөний байдлын талаарх 2008 оны илтгэл”-д 7 дугаар сарын 1-ний үймээн самууны хэрэгт холбогдуулан дараах хүний эрхий зөрчлүүд илэрсэн гэж үзсэн байна. Үүнд:

1. Хүний амьд явах эрх ноцтой зөрчигдөж цагдаагийн ажилтнууд онц байдал тогтоосны дараа 4 хүнийг буудаж амь насыг нь хохироосон;
2. Мэдээлэл түгээх үйл ажиллагааг хязгаарлаж Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизүүдийн үйл ажиллагааг түр хааснаар үнэн бодит мэдээлэл иргэдэд хүрээгүй;
3. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөж онц байдлын үед хөл хорио тогтоосон нутаг дэвсгэрээс өөр газарт явж байсан

- иргэдийн эрх чөлөөнд халдаж албадан саатуулсан, баривчилсан;
4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу баривчлагдан саатуулагдсан хүмүүсийн гэр бүлийнхэн болон өмгөөлөгчдөд нь нэн даруй мэдэгдээгүй. 2008 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар 30 хүн гэр бүлийнхэнтэйгээ холбогдоогүй;
 5. Албадан саатуулагдсан, баривчлагдсан хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүдтэй хэрцгий харьцаж, зодож цохисон, хоол ундгүй, хүнд нөхцөлд бөөнөөр нь хорьсон;
 6. Баривчлагдсан, саатуулагдсан хүмүүст эрхийг нь танилцуулаагүй, баривчилсан үндэслэлийг хэлээгүй, өмгөөлөгчгүй байцаалт авсан, эрх зүйн туслалцаа авах эрхийг нь зөрчсөн;
 7. Цагдаа, хүчний байгууллага жагсаал цуглааныг онц байдал тогтоох хэмжээнд хүргэлгүйгээр таслан зогсоох боломж байсан боловч хүсээгүй, зориуд зохион байгуулсан;



Нийслэл дүүргүүдийн Шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдэж ял шийтгүүлсэн байдлыг дараах дүрсээр харуулав.

Ял шийтгүүлсэн 244 хүний 86.6 хувьд нь хорих ял, 8.9 хувьд нь баривчлах, 0.8 хувьд нь торгох ял оноож, 8 хүнд нь холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ¹⁷.

¹⁷ Монгол Улс дахь Хүний эрх, эрч чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2008

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
1		<p>Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох хуулийн зохицуулалтын мэдлэгтэй болох:</p> <ul style="list-style-type: none"> • Хаана, хэрхэн, ямар байдлаар бүртгүүлэх • Жагсаал, цуглаан зохион байгуулагчийн эрх үүрэг • Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээ авах гэх мэт 	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>
2	Жагсаал, цуглааны өмнөх, бэлтгэл шатад хамаарах	<p>Жагсаал, цуглаан зохион байгуулах талаар төлөвлөгөө, дүрэмтэй байх:</p> <ul style="list-style-type: none"> • Байршил, үргэлжлэх хугацаа гэх мэтийг тусгасан зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны зорилго, хүргүүлэх шаардлага, хүлээгдэж буй үр дүн зэргийг тодорхойлсон агуулгын төлөвлөгөө гаргах • Эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах тухай эрсдэлийн төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны үеэр зөвшөөрөгдөх болон хориглох зүйлсийн талаар жагсаалд оролцогчдод урьдчилан сануулах, мэдээлэл түгээх 	Жагсаал зохион байгуулагч
3		Жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөг урьдчилан олон нийтэд түгээн, ашиг сонирхлын хувьд нийцтэй бүлгийг урьж оролцуулдаг байх	Жагсаал зохион байгуулагч
4		Оролцохоор төлөвлөж буй жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөтэй сайтар танилцаж, оролцогч болох эсэх талаараа шийдвэр гаргах	Жагсаалд оролцогчид
5		Цагдаагийн байгууллагыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангах, түүнийг хэрэглэдэг арга барилд мэргэшүүлэх, сургах	Цагдаагийн байгууллага
6		Жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор олон хүн цугларсан газар очих бол ашиглах хэрэглэгдэхүүнээ зөв тодорхойлж, зэвсгийн чанартай хэрэгсэл болон шатах, дэлбэрэх зүйл авч очихгүй байх	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>
7	Жагсаал, цуглаан зохион байгуулагдаж буй үед хамаарах	Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчдын зүгээс жагсаал, цуглааны үеэр ашиглах үг хэллэг, уриа лоозон, бэлгэ тэмдэгтээ маш анхаарал, болгоомжтой хандаж байх. Олон нийтийг хууль бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өдөөн хатгахаас маш сэрэмжтэй байх	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>
8		Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээллийг тэнцвэртэй, түргэн шуурхай байдлаар олон нийтэд хүргэдэг байх. Хэт 1 талыг баримталсан эсвэл үнэнээс гуйвсан мэдээлэл түгээхээс зайлсхийх	

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
9		Улс төрчид, шийдвэр гарагчдын хувьд иргэдийн санал хүсэлтэд хүндэтгэлтэй хандаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд судлан үзэж хариу өгч, ойлголцдог болох. Жагсаал, цуглаанд оролцогчдын шаардлагуудад аль болох хүлээцтэй хандах, зөвшилцөх, хэлцэлд орох, тайван нөхцөл байдалд жагсаал үргэлжлэх боломжоор хангах	Төрийн албан хаагчид Улс төрч, шийдвэр гарагчид
10		Олныг хамарсан томоохон хэмжээний жагсаал цуглааны үеэр этгээдүүд өөрийн эрх ашгийн үүднээс санаатайгаар явуулга хийх, худал мэдээлэл тараах, жагсаал цуглааны өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хувиргах зэрэг эрсдэл байдаг тул өөрийн үзэл бодол, ашиг сонирхолд нийцтэй байдлыг цаг ямагт шалгаж, хэрсүү байх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
11	Жагсаалын дараах үед хамаарах	Жагсагч хувийн нууцын мэдээллээ хамгаалуулах, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөнд халдсан бол ХЭҮК-т гомдол гаргуулан шалгуулах эрх зэргийг мэддэг байх буюу эрх зүйн орчинд хамгаалуулах анхан шатны мэдэгдэхүүнийг олж авах	
12		Жагсаал, цуглаан хуулийн хүрээний хяналтаас гарсан, албадан тараах нөхцөл байдал үүссэн, онц байдал зарлах шаардлага гарсан үед төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлэх шийдвэрүүдийн талаар иргэд, олон нийт, жагсаалд оролцогчдод түргэн шуурхай мэдээлэл хүргэх, сануулах	Төрийн захиргааны байгууллага Цагдаагийн байгууллага



**ХОЁР. #NO ТОДОТГОЛТОЙ ЦУВРАЛ
ЖАГСААЛ (2021-2022)**

*Зургийн эх сурвалж:
dogo.mn*

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан болсон, дууссан огноо, байрлал	<ul style="list-style-type: none"> ✓ NoNaadam: 2021 оны 6-7 сар ✓ NoDoubleStandart: 2021 оны 09 сар ✓ NoWar: 2022 оны 02 сарын 25 дээрх жагсаалууд одоо хүртэл үргэлжилж буй
2	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Д. Монголхүү, Одбаяр, Ганхөлөг, Чинбат нарын 11 орчим залуучууд.
3	Жагсаал, цуглааны хэлбэр, төрөл, процесс, үе шат	Аяндаа үүссэн, тайван хэлбэрээр эхэлсэн, үе шаттай, зохион байгуулалттай
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Монгол улсын ЗГ, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, УИХ-ын дарга Г.Занданшатар
5	Хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 оны 6 сарын 25-нд гаргасан зөрчилдөө нийт иргэдээсээ уучлалт гуйж, эмгэнэл илэрхийлж хүндэтгэл үзүүлэх ✓ Жил бүрийн 6 сарын 25-ны өдрийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр болгон хуульчлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ✓ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2022 оны 7 сарын 10-ны өдрөөс өмнө нэн даруй хүчингүй болгох, ✓ Ковидын үеийн зээл тусламж, санхүүжилт, түүний зарцуулалтыг 2022 оны 7 сарын 10-ны өдрөөс өмнө олон нийтэд ил болгох, ✓ "NoDoubleStandard" иргэдийн хөдөлгөөнүүдийн залууст хилс хэрэг үүсгэн хэлмэгдүүлж буй үйл ажиллагаагаа таслан зогсоож өнгөрсөн хугацаанд учруулсан хохирлыг барагдуулах, ✓ Цагдаагийн ерөнхий газрын дарга Ж.Болдыг 2022 оны 7 сарын 10-аас өмнө ажлаас нь чөлөөлөх, <p>Хэлмэгсдийн музейг хууль бусаар буулгасан ч өнөөдрийг хүртэл тус музейг сэргээн байгуулаагүй. Иймд хэлмэгсдийн музейг сэргээн байгуулах ажил эхэлснийг мэдэгдэж байна. Хэлмэгсдийн музейг хуучнаар Д.Нацагдоржийн хөшөөний суурин дээр барьж, цэцэрлэг хүрээлэн болгон тохижуулах газрын асуудлыг нэн даруй шийдэх зэрэг шаардлага багтжээ.</p>

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаанд хамрагдсан хүний тоо, онцлог	✓ 1500 орчим
2	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Шар, цэнхэр тууз, хүүхдийн гутал, NO гэсэн улаан бичиг
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Сэтгэл хөөрөл, уриалан дуудах, хатуу шаардлага тавьж, ЗГ-ыг буруутгасан
4	Улирал, цаг агаарын байдал	Зуны улирал
5	Жагсаал, цуглаанд хамрагдсан хүний тоо, онцлог	1500 орчим
6	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Шар, цэнхэр тууз, хүүхдийн гутал, NO гэсэн улаан бичиг

NoNaadam

Ерөнхийлөгчийн сонгууль - 2021 оны 6 сарын 25-ны өдөр буюу хүндэт харуулууд амны хаалтаа бүрэн зүүлгүйгээр үлээвэр хөгжмийн зэмсэг тоглож байв. Хатуу хөл хорио тогтоосон үед төрийн албан хаагчдын халдвар тарах нөхцөлийг үл ажирсан байдал төрийн өндөр, дээд албан тушаалтнуудын хандлага иргэдийн эсэргүүцлийг төрүүлсэн. Мөн 100 жилийн ой тэмдэглэх нэрийдлээр 10 тэрбум төгрөгөөр зөвхөн эрх мэдэлтнүүд наадам зохион байгуулах зорилгоор наадмын хүрээ барьж байгуулав.

Ерөнхийлөгчийн сонгууль - 2021 оны 6 сарын 25-ны өдөр буюу хүндэт харуулууд амны хаалтаа бүрэн зүүлгүйгээр үлээвэр хөгжмийн зэмсэг тоглож байв. Хатуу хөл хорио тогтоосон үед төрийн албан хаагчдын халдвар тарах нөхцөлийг үл ажирсан байдал төрийн өндөр, дээд албан тушаалтнуудын хандлага иргэдийн эсэргүүцлийг төрүүлсэн. Мөн 100 жилийн ой тэмдэглэх нэрийдлээр 10 тэрбум төгрөгөөр зөвхөн эрх мэдэлтнүүд наадам зохион байгуулах зорилгоор наадмын

NoDoubleStandart

Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы үед олон мянган иргэдийн анхдагч

хүрээ барьж байгуулав. Ковид-19 цар тахлын хөл хорио, хязгаарлалтаас үүдэлтэй эдийн засгийн зогсонги байдал нь Монгол Улсын ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид, жижиг бизнес эрхлэгчдэд хүнд цохилт болсон.

Иймд иргэн М нарын залуучууд наадам зохион байгуулбал бүх иргэд наадам тэмдэглэх эрхтэй, хорио цээрээ цуцлах эсвэл улсаараа наадам тэмдэглэхгүй байх шаардлагатай гэж үзэн NoNaadam хөдөлгөөнийг эхлүүлжээ. Шаардлага нь наадам зохион байгуулах төсвөөр халдварыг бууруулах арга хэмжээнд зарцуулах тухай байв. Төр зохион байгуулалттайгаар иргэдийн амь насыг дэнчин тавьж, иргэдээ хүчирхийлэх ёсгүй гэсэн санааг илэрхийлэв.

Энэ үеэр иргэд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа талаар эрх баригч нарт сануулахын тулд хайрцагт хийсэн хүүхдийн гутал талбай дээр авчрахад СБД-ийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн алба хаагчид саатуулж, уг хүүхдийн гутлыг талбай руу оруулахыг хориглосон байдаг.

хэрэгцээг хорьж, хатуу хөл хорионд оруулсан. Энэ үед Монгол Улсын Засгийн

Газар (ЗГ) “Цахим Үндэстэн” арга хэмжээг зохион байгуулснаар хөл хорионы үр дүн үгүй болж, халдвар авсан иргэдийн тоо 10

2021 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Ковид-19 цар тахлын халдвар авсан тохиолдлын тоо улсын хэмжээнд 2796, нас баралтын тоо 9 буюу өмнөх өдрүүдтэй харьцуулахад 10 дахин өссөн үзүүлэлт байжээ. Энэ үед Засгийн газар Үндэсний соёл амралтын хүрээлэнд “Цахим үндэстэн” арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд 30,000 орчим хүн цугларчээ. Энэ нь давхар стандарт тогтоож буйг харуулсан гэж үзсэн тул NoNaadam хөдөлгөөн NodoubleStandart жагсаалаар үргэлжилсэн байна.

МУ-ын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хатуу хөл хорионы үеэр зохион байгуулсан “Цахим үндэстэн” арга хэмжээнд амны хаалтгүй иргэдэд хандаж индэр дээрээс биечлэн үг хэлэх үеийн бичлэг: <https://www.youtube.com/watch?v=LglsnNeMd3A>

дахин нэмэгдэж, нас барагсдын тоо огцом өссөн нь энгийн ард иргэдэд хүнд цохилт болсон.

NoWar

Украин улсад болж буй дайныг эсэргүүцэж иргэд 2022 оны 3 дугаар сарын 1-ны өдөр Чингисийн талбайд жагсаж эхэлсэн бөгөөд 3 сарын 26-ны өдрөөс Монгол Улс дахь ОХУ-ын Элчин сайдын яамны гадна 1990 оноос хойш анх удаа олон нийтийг хамарсан тайван жагсаал, цуглаан зохион байгуулав. Уг жагсаал, цуглаан нь 3 сарын 26-ны өдрөөс хойш 7 хоног бүрийн бямба гариг бүр зохион байгуулагддаг байв.

Украины дайны нөлөөгөөр монгол залуусаа аврах хүнлэг хандлага, шийдэл гаргахгүй байсан Гадаад Харилцааны Яам болон ЗГ-т хилийн цаана буудуулан нас барсан иргэдийн эрх чөлөөг хязгаарласан байдлыг эсэргүүцэж NoWar идэвхжиж, ЗГ-ын шийдвэрээс урьтаж гадаадад гацсан монголчууд болон хөдөлгөөн эхлүүлсэн залуусын санаачилга үр дүнд хүрсэн байна.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Эсрэг жагсаал, цуглаан байсан эсэх	Морь уяачид болон Эмч ажилчдын жагсаал зэрэгцээ зохион байгуулагдаж байсан ба энэ үеэр зохион байгуулалттай үймүүлэх, жагсаал зохион байгуулагчдыг сүрдүүлэх зэрэг эсрэг мөргөлдөөнүүд үүссэн.
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Заналхийлэх, айлган сүрдүүлэх, бүлэг этгээдүүд жагсаал зохион байгуулагчдын гэрийн ойролцоо эргэлдэж, хэл амаар доромжлох үзэгдлүүд үүссэн. Цагдаагийн байгууллагын алба хаагчид хүч хэрэглэн авч явсан.
3	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Хангалттай бэлтгэл байгаагүй. Үүссэн нөхцөл байдлын эсрэг эхний ээлжид сэтгэл хөдлөлөөр талбай дээр хэсэг бүлгээрээ зогсож эхлүүлсэн.
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Тийм
5	Олон нийтийн дэмжлэг	Олон нийтийн дэмжлэг хүчтэй байсан ба хилийн чанадад суух иргэд цахимаар нэгдэж, дэмжиж буйгаа илэрхийлж байв.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Цар тахлын улмаас амь үрэгдсэн иргэдийн дурсгалд зориулж зул өргөх ёслол үйлдэх үйлсэд хилийн чанад дахь монгол иргэд хандив цуглуулан илгээсэн
7	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Жагсаал, цуглааны үед УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хороо нээлттэй сонгогч зохион байгуулж, Монголхүү зэрэг хүмүүсийг урьсан. УИХ-ын хэд хэдэн гишүүд жагсаал, цуглааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл өргөн мэдүүлсэн.
8	Жагсагч нарын тавьсан шаардлага үр дүнд хүрсэн эсэх, биелүүлээгүй шаардлага юу болох	Нийт 7 шаардлага хүргүүлснээс нэг шаардлага буюу Наадам зохион байгуулахыг нэг жилээр хойшлуулсан шийдвэрийг засгийн газраас гаргасан.
9	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Албадан тараах шаардлага бүхий цагдаагийн хүчний байгууллагын үйлдлүүд удаа дараа гарч байсан.



*gogo.mn болон ikon.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

NoNaadam

NoNaadam хөдөлгөөний хүрээнд 7-8 шаардлага хүргүүлсэн бөгөөд нэг шаардлага биелсэн буюу хатуу хөл хориог сулруулах тухай шийдвэр гарчээ. Энэ хөдөлгөөн 7 хоног үргэлжилсэн байна.

NoNaadam-р эхэлсэн цуврал жагсаалын үр дүнд олон талын байр суурь, олон салбарын залуучуудын анхаарлыг татаж чадсан бөгөөд зарим салбарт ажилладаг ТББ-уудыг Лантуун дохио ТББ манлайлан хүүхдийн эрхийг зөрчиж, наадам зохион байгуулахаар хурдан морь унаач хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах акц өрнүүлж, ЗГ-ийг шүүхэд өгсөн. Үүний үр нөлөөгөөр хурдан морь унаач хүүхдүүдийн амь насыг даатгах үйлчилгээ үзүүлэгч даатгалын компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд хурдан морь унуулахыг нь зөвшөөрөхгүй, даатгал хийх үйл ажиллагааг хийхгүй гэсэн эсэргүүцлийг илэрхийлсэн. Энэхүү жагсаалын тухай Тэвчээр тасарлаа”, “Аялал жуулчлал амь тавилаа”, “Би амьдармаар байна”, “Амьдрал зогслоо”, “NoNaadam”, “Засгийн газар, УОК-оос гаргасан шийдвэрийг эсэргүүцэж байна”, “Фитнесээ нээ ажилламаар байна” гэсэн утга бүхий уриа, лоозон барьж, үзэл бодлоо илэрхийлсэн гэж Цагдаагийн байгууллага тэмдэглэжээ. Энэ жагсаалын үр дүнд 2021 оны наадмыг зохион байгуулахгүй байх шийдвэрийг ЗГ-аас гаргуулахад нөлөөлжээ.

NoDoubleStandart

NoDoubleStandart хөдөлгөөний үр дүнд хатуу хөл хорио цуцлагдсан үр дүнтэй ч энэ хөдөлгөөн өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Учир нь дээрх жагсаалыг зохион байгуулсан гэх Монгол Улсын иргэн 11 залуусыг мөрдөн байцаах үйл явцууд өрнөсөөр, зарим нь одоог хүртэл цахим гавтайгаа байгаа юм.

NoWar

Олон улсад монгол улсын залуучууд ч мөн адил дэлхийн энх тайвныг эрэлхийлж

байна гэсэн мессежийг бусад улс оронд түгээх зорилготой байсан. Энэ нь удаан хугацаанд хамгийн тууштай байдлаар жагсаж буй цуврал жагсаал болжээ. 2023 оны 12 сарын 23-ны өдрийн байдлаар олон байршлуудад нийт 89 удаагийн тайван жагсаал, цуглааныг зохион байгуулсан байна.

Энэхүү жагсаал цуглаан нь санхүүжилтийн хувьд багагүй хардалтыг үүсгээд байсан тул хилийн чанадад ажиллаж байгаа иргэдийн сайн дурын хандиваар авсан зул зэрэг хэрэгслүүд худалдан авсан тухай мэдээллээ ил тод мэдээлж явсан байна. Эдгээр жагсаал нь удаан хугацаанд тууштай, цэгцтэй мэдээлэл хүргэж, баримтжуулалтаа олон нийтэд хүргэж хамгийн том үр дүн бол иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг авч үлдэхийн төлөөх тэмцлүүд юм.

Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр хэсэгчлэн шилжиж, 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр цуцлах хүртэл хоёр жилийн хугацаанд гамшгаас хамгаалах зэргийг 4 удаа ахиулан, бүх нийтийн бэлэн байдал зарлаж, 79 хоног хатуу хөл хорио тогтоосон байна. Гадаад улсаас эх орондоо ирэх хүсэлтэй хүмүүсийг татан авах ажиллагааны оргил үед олон улсын зорчигч тээврийн нислэгийг зохион байгуулах нэг мөр заавар байгаагүй нь үйл ажиллагааг эрхлэн явуулсан төрийн албан тушаалтны хандлагаас хамаарч, газар бүрд харилцан адилгүй гүйцэтгэх, зарим тохиолдолд хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлжээ.

- Тооцоолоогүй сургамж нь жагсаалыг зохион байгуулсан залуучуудыг мөрдөн байцаах үедээ гэрчээр мэдүүлэг авах хүсэлтэй саатуулсан ч эрүүгийн хэрэгтэй болгож заримыг нь хорьж саатуулсан тохиолдол гарсан.

Шигтгээ 1. Жагсаалд оролцогчдын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

“Намайг ямар учиртай баривчилсан тухай мэдээлэл өгөлгүйгээр гэрч гэж байсан ч хэдхэн цагийн дараа сэжигтэн болж хувираад, эцэст нь ямар ч мэдээлэл өгөлгүйгээр 24 цаг барьж саатуулчаад тодорхой мэдүүлэг авалгүй сулласан”

NoWar жагсаалын зорилго биелсэн бөгөөд хоёр улсын аль ч талд ороогүй энх тайвныг эрэлхийлсэн залуус монгол улсад бий гэдгийг харуулж, цаад утгаараа дайны бүсэд буй монгол иргэдийн амь нас эрүүл мэндийн асуудалд санаа зовж засгийн газрын үүргийг эрчимжүүлэх байсан. Хилийн чанадад

суурьших монгол улсын иргэдийн анхаарлыг татаж, яаралтай хандив цуглуулан дайны бүсэд ойр эрсдэлтэй иргэдийг татаж авах төлөвлөгөөг зохион байгуулсан нь засгийн газраас түрүүлж хөдөлсөн гэж жагсаал зохион байгуулагчид дүгнэж байна.

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

Жагсагчдад зориулсан зөвлөмж

- Жагсаал цуглаан хийх үзэл бодлоо илэрхийлэхдээ үзэл бодлоо илэрхийлэхэд дэмжлэг болохуйц хэрэглэгдэхүүнүүдээ зөв тодорхойлж, зэвсгийн чанартай хэрэгсэл авч очихгүй байх тухай мэдээлэлтэй байж, өнгө сонголт, жагсаалын уур амьсгалыг нарийн мэдрэмжтэй ажиглаж, ямар нэгэн хэрэглэгдэхүүнийхээ оновчтой тайлбарыг нарийн тооцоолох;
- Жагсаал зохион байгуулж буй иргэд төрийн байгууллага, институтын үйл ажиллагааны чиг үүргийн тухай тодорхой ойлголттой байх. Тухайлбал жагсаалын үеэр ХЭҮК-оос ажиглалт хийж байсан комиссын ажилтны хувцастай энгийн албан хаагчид руу иргэд дайрч, хүч хэрэглэх оролдлого гарсан байна.
- Төртэй дайсагнах үзэл бодолтой сэтгэл хөдлөлд автахаас илүүтэй, тодорхой шаардлагыг тавьж, төрийн оновчтой бодлого шийдвэрт нөлөөлөх нь олон нийтийн эрх ашиг хийгээд хувь хүнийхээ ардчилсан нийгэмд амьдрах нөхцөлийг бүрдүүлж буй ач холбогдлоо зөв эрэмбэлэх;
- Жагсаал зохион байгуулагчид тухайн дүүргийн цагдаагийн байгууллагаас танилцуулсан үүрэг, зөвлөмжтэй танилцаж, эв нэгдэл тайван байдлыг эрхэмлэх;
- Органикаар үүссэн жагсаал цуглаан нь удирдлагаас гарах эрдэл учирч болзошгүй бөгөөд дээрх жагсаалыг дэмжиж бусад орон нутгаас залуучууд нэгдэж байгаагаа илэрхийлж аймгийн төвүүдийн талбайд жагсаж байсан тул тэдний нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахад анхаарал хандуулах;
- Орон сууц дунд бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зэрэг жагсаал цуглаан хийх боломжтой газар, цаг хугацааг тооцож төлөвлөх;
- Хууль сахиулагчдын зүгээс албадан эмнэлэгт хэвтүүлэх зэрэг үйлдэл гаргуулахаас буюу өөрийн амь нас эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц үйлдэл гаргахгүй байх;
- Жагсаал цуглааныг бүртгэсэн тухай хариуг авсан жагсагч нь албан бичгийн баталгаат тамга тэмдэг гарын үсэг зэргийг шалгах;
- Монгол улсын иргэдийг хооронд нь талцуулж, мөргөлдөөн үүсгэж жагсаал зохион байгуулах хүсэл эрмэлзлийг намжаах сонирхол эрх баригч, шийдвэр гаргагчдад байдаг тул зохион байгуулагчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарах
- Нэг удаагийн сэтгэл хөдлөлөөр бус тууштай, тайван замаар үг хэлэх үзэл бодлоо илэрхийлж, хүчирхийллийн бус аргаар хэв журам сахиулагчидтай

харилцан ойлголцох, хоёр талын шаардлагыг хүлээн авч, зөвөөр хариу үйлдэл үзүүлж байх.

- Иргэд өөрсдийн тавьж буй шаардлагыг тодорхой баримтжуулж байх хэрэгтэй ба ихэнх хэвлэл мэдээллийн өнцөг, мэдээ мэдээлэл шууд дамжуулалт устгагдаж үгүй болох эрсдэлтэй тул

өөрсдийн гэсэн баримт нотолгоо бүхий бичлэг мэдээллүүдийг цахим орчинд үлдээж байх, өөрсдөдөө хадгалж байх. Тооцоолоогүй зохион байгуулалттайгаар үймээн үүсгэх зорилготой иргэд нэгдэж байгаа эсэхээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй.

A photograph of a person's legs and feet wearing blue jeans and brown boots, holding a white banner with blue Mongolian text. The banner is partially obscured by a blue semi-transparent box containing the title. The background is dark and out of focus.

**ГУРАВ. ЕРӨНХИЙ САЙД ОГЦОРСОН
ЖАГСААЛ (2021)**

*Зургийн эх сурвалж:
tra.mn*

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2021 оны 01-р сарын 20-ны өдөр
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> - УОК-ын дарга Я.Содбаатар, ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан нарыг огцрох - УОК огцрох - УОК болон Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	<ul style="list-style-type: none"> - УОК-ын дарга Я.Содбаатар, ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан - УОК болон Засгийн газар
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Удирдан зохион байгуулсан хүн байхгүй



*tug.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Ковид-19-ийн үеийн улс орны нөхцөл байдал, Монгол улсын Засгийн газар болон Улсын Онцгой Комиссоос гаргасан шийдвэрүүдийн үр дүн
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Тийм. Нийгмийн сүлжээгээр жагсаал цуглааны талаар олон нийтийг уриалсан УОКЦОР хаштаг бүхий нийтлэлүүд гарч байсан.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Үгүй
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Урьдчилсан бэлтгэлгүй
5	Улирал, цаг агаарын байдал	Өвлийн улирал, Идэр хүйтэн есийн хүйтэн

Монгол улсад Корона вируст (Covid 19) халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлоос эхлэн Засгийн газраас халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн. Ерөнхий сайд огцорсон цуглаан болохоос өмнө Монгол Улсын Засгийн газраас хоёр удаа хатуу хөл хориог бүх нийтээр тогтоогоод байв. Эдгээр хатуу хол хориог 2020 оны 11-р сарын 11-нээс 12-р сарын 14 хүртэл болон 2020 оны 12-р сарын 23-наас 2021 оны 01-р сарын 01 хүртэлх хугацаанд тогтоосон¹⁸. Цар тахлын үеийн иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх буюу жагсаал, цуглаан хийх эрх чөлөө дараах хууль, журам, тогтоол, шийдвэрүүдээр зохицуулагдаж байлаа¹⁹. Үүнд:

- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль
- Ковидын эсрэг хууль
- Нийслэлийн засаг даргын захирамж 2020 оны А/930²⁰
- Улсын Онцгой Комиссын шийдвэр

Энэхүү цуглаан болохоос өмнө удаа дараалан Ковид 19-тэй холбоотой дээрх хөл хорио болон шийдвэрүүдийн улмаас сэтгэл зүй, эрүүл мэнд, хөрөнгө мөнгө, амь насаараа хохирч буй иргэдийн талаар мэдээлэл удаа дараа гарч, олон нийтийг цочроосоор байв. Жишээлбэл:

1. Гадаадаас эх орондоо халдваргүй ирээд “Энхсаран” сувилалд тусгаарлагдаж байхдаа эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчин нөхцөлд тусгаарлагдаж байгаад гарахынхаа яг өмнөхөн Ковид 19-ын голомттой газраас халдвар авснаа мэдсэн иргэний тухай.
2. Сэлэнгэ аймгаас ирсэн 10 настай охин 22-ын товчоонд 2 цаг гаруй хүлээж зогсон, ЭХЭМҮТ дээр ганцаар тусгаарлагдан хүргэгдээд нас барсныг ээж нь шинжилгээнийхээ хариуг авчхаад охинтойгоо очих гээд уулзах үедээ мэдсэн тухай.
3. УИХ-ын гишүүн Г.Амартүвшин Хөгжлийн банкны захирлаар ажиллаж байхдаа Г.Дамдинням, Х.Ганхуяг нарын хамаарал бүхий

¹⁸ ҮСХ, “ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлсэн цар тахлын (COVID-19) нөлөө” 2021 оны 3-р сарын тандалт судалгаа

¹⁹ Эмнести интернешнл болон ННФ, Ковид-19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа ба жагсаал, цуглаан. Хуульч: Р.Очирбал

²⁰ Мөн уг жагсаалаас хойш дараах захирамжууд гарсан. Нийслэлийн засаг даргын захирамж: 2021 оны А/25, А/246, А, 357 тоот захирамж

компанид 33 тэрбум төгрөгийн зээл гаргаж өгсөн тухай²¹

4. Архангай аймгаас ирсэн иргэн 22 товчоон дээр эмнэлгийн тусламж авч чадалгүй нас барсан тухай²²
5. Гадаадад гацсан иргэдийн асуудал болон Солонгост жагсаж өлсгөлөн зарлаж байсан иргэдээс 36 настай иргэн нас барсан гэх мэт.

2021 оны 1 дүгээр сарын 18-нд "Өргөө" амаржих газарт эхээс Коронавирусын халдвар илэрч, дөнгөж төрсөн эх, нярай хоёрыг халдвартай гэсэн шалтгаанаар өвлийн хүйтэнд ХӨСҮТ рүү шилжүүлэхдээ хүнлэг бусаар хандсан бичлэгийг Ийгл телевизийн шууд дамжуулалтын баг олон нийтэд дамжуулсан. Эмнэлгийн ажилтнууд эх нярайг шилжүүлэхдээ нимгэн халаад, тавчиктай, амыг нь дэрээр баглан шилжүүлж буйг харснаар "хүнлэг бус, ёс зүйгүй, хариуцлагагүй хандлага" гаргалаа хэмээн бухимдаж, Сүхбаатарын талбайд олон нийтийг хамарсан цуглаан үүсэв. Ийнхүү 2021 оны 01 сарын 20-нд Сүхбаатарын талбай дээр оргил үедээ 5000 хүнийг хамарсан аяндаа үүсэн цуглаан болсон.

Зорилго

Жагсагч, дэмжигчдийн тавьсан шаардлага, гол зорилго нь аажим аажмаар бүрэлдэн бий болж байлаа.

- 2021 оны 01-р сарын 20-ны өглөө жагсагч, дэмжигчид "Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, УОК-ын дарга Я.Содбаатар нарыг огцрох"-ыг шаардаж байсан.
- 2021 оны 01-р сарын 20-ны үд дунд жагсагч, дэмжигчид "УОК-ыг огцрох"-ыг шаардаж байсан бол
- Улмаар 2021 оны 01-р сарын 20-ны орой тэдний хүсэл зорилго хүчээ авч "УОК-ыг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох"-ыг шаардсан.

Шаардлага тавьсан байгууллага, хуулийн этгээд: Уг цуглаан нь албан ёсоор зохион

байгуулагдаагүй бөгөөд тус өдөр ард иргэд аажим аажмаар нэмэгдсээр байлаа.

Гол уриа: Төв талбай дээрх жагсагч, дэмжигчдийн барьсан самбар, амны хаалт дээрх бичиг, сошиал хаягууд дээрх гол уриа үг нь #УОКЦОР, #УОК огцор!!! гэсэн түлхүүр үгтэй байсан.

Тэмцлийн арга зам, зохион байгуулалт

Зохион байгуулалтын хэлбэр: Аяндаа өөрсдөө үүссэн буюу ямар нэгэн зохион байгуулж, удирдаж байсан хүн байгаагүй. Цэвэр иргэдийн өөрсдийн санаачилга байсан. Гэвч зарим эх сурвалжийн мэдээллээр улс төрийн хүчнүүдийн зохион байгуулалттай гэсэн албан бус мэдээлэл мөн явагдсан.

Органик нэгдэл эсэх: Цар тахлын үед төр засгийн шийдвэрүүдийн улмаас хохирч байсан иргэдийн сэтгэл сэрдхийлгэм мэдээллүүдээс үүдэн ард иргэдийн жагсах, цуглах нь цаг хугацааны асуудал болсон байсан. Мөн гадаад улсад байгаа иргэдийн цахим жагсаал үүссэн байсан. Энэ үед дөнгөж төрсөн эмэгтэйд хүнлэг бусаар хандаж буй мэдээлэл цацагдсан нь тэднийг цуглах сэдэл болсон төдийгүй зөвхөн үүгээр зогсохгүй олон шалтгаан байгаа талаар жагсагч, дэмжигчдийн ярилцлагаар гарч байсан. Цуглаан 1-р сарын 20-ны өглөө цөөн хүнээр эхэлж, оройн 18 цагийн үед албан бус тоогоор 5000 хүнийг хамарсан байв.

Жагсагч, дэмжигчдийн бэлтгэл: Жагсагч, дэмжигчид дунд олны анхаарлыг татахуйц дүр зургууд гарч байв. Жишээлбэл, өвлийн -40 хэмийн хүйтэнд жагсагч иргэн дотуур хувцаснаас бусад бүх хувцсаа тайлж суусан, жирэмсэн эмэгтэй хүйтэн цемент дээр хөл нүцгэн, халаадтай жагссан гэх мэт. Мөн тухайн үед хууль сахиулж ард иргэдийн аюулгүй тайван байдлыг хамгаалах үүрэг хүлээн цагдаагийн албан хаагч нүцгэн сууж буй иргэнийг "Ахын дүү хувцсаа өмсчих" хэмээн эелдгээр хандаж

²¹ [Г.Амартүвшин, Г.Дамдинням, Х.Ганхуяг нарын Хөгжлийн банкнаас гаргасан 33 тэрбум төгрөг ил боллоо \(zindaa.mn\)](http://zindaa.mn)

²² [Архангай аймгаас ирсэн иргэн 22-ын товчоон дээр эмнэлгийн тусламж авч чадалгүй нас баржээ | iSee.mn \(imedee.mn\)](http://imedee.mn)

байсан тухай социал сувгаар цацагдаж байсан нь ард түмэнд эерэг мэдээлэл болж байв.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Аяндаа үүссэн, тайван хэлбэрээр явагдсан, зохион байгуулалтгүй
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Үгүй. Идэр есийн хүйтэнд нүцгэн жагсаж айлган сүрдүүлэх байдал гарсан боловч, хүнд нөхцөл байдал үүсээгүй. Цагдаагийн байгууллагын алба хаагчид нөхцөл байдлыг тогтворжуулах арга хэмжээ авч байсан.
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Сэтгэл хөөрөл, уриалан дуудах, төр засгийн шийдвэрүүдийг буруутгасан
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Үгүй
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Олон нийт цуглааныг маш ихээр дэмжиж, цуглаан үр дүнд хүрэх хүртэл нэмэгдсээр байсан.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Санхүүжилт байгаагүй.
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	УОК-ын дарга Я.Содбаатар, ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан, УОК болон Засгийн газар

“Ерөнхий сайд огцорсон цуглаан” нь 2021 оны 01-р сарын 18-22-ныг хүртэл 5 хоногийн дотор болж өнгөрсөн бөгөөд энэхүү үйл явцын товч зураглалыг доорх дүрсээс үзнэ үү.



2021.01.18. /ДАВАА/ Коронавирусийн халдвар авсан нялх биетэй эх, хүүхдийг өвлийн хүйтэнд нимгэн хувцастай авч явж, тусгаарлав.

Нэгдүгээр амаржих газарт төрөөд нэг хонож байсан эхээс Коронавирус илэрч, анх удаа төрөх эмнэлэгт халдвар илэрсэн анхны тохиолдол байв. Эмч, мэргэжилтнүүд болон тус эмнэлэгт хэвтэж буй 270 гаруй эх, нярайг халдварын эрсдэлээс сэргийлэхийн тулд шинэ төрсөн нялх биетэй ээжийг ХӨСҮТ рүү шилжүүлэхдээ идэр есийн хүйтэнд гадуур хувцасгүй, гэрийн шаахайтай тээвэрлэсэн нь иргэдийн дургүйцлийг хүргэсэн. Уг бичлэгийг Eagle телевизийн сурвалжлах баг бодит нөхцөл байдал дээрээс нь шууд мэдээлсэн.

2021.01.19. /МЯГМАР/ УОК, ЭМЯ, ХӨСҮТ, Өргөө амаржих газрын эрх бүхий албан тушаалтнуудаас олон нийтэд хандан мэдэгдэл хийлээ.

Дөнгөж төрсөн эх, хүүхэдтэй хүнлэг бусаар харьцаж, хариуцлагагүй байдлаар шилжүүлсэн талаар холбогдох албан тушаалтнуудаас удаа дараа уучлал хүссэн мэдэгдэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдсаныг дор оруулав. Үүнд:

- УОК-ын дарга Я.Содбаатар: Ард иргэдээс уучлал хүсэн мэдэгдэл хийлээ.
- ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан: НЭМГ болон Нэгдүгээр төрөхийн даргыг ажлаас чөлөөлөхийг хотын даргаас хүсжээ.
- ХӨСҮТ-ийн ерөнхий захирал, Д.Нямхүү: Бид алдаа гаргасан, уучлал гуйж байна
- Өргөө амаржих газрын захирал, Г.Баясгалан: Яарч тэвдэн ажиллахдаа алдаа гаргасандаа уучлал гуйж байна.

2021.01.20. /ЛХАГВА/. УОК-ын тохиромжгүй шийдвэр, эх, үрийн эрхийг хамгаалсан иргэдийн цуглаан үүссэн.

Нийгмийн сүлжээнд бухимдлаа илэрхийлж байсан иргэдийн тэмцэл маргааш өглөө нь УОК, Эрүүл мэндийн сайдыг огцруулах цуглаан болон Төв талбайд хийсэн. Залуучууд нялх биетэй эх, үрийн

зөрчигдсөн эрхийг хамгаалахын тулд хэний ч захиалга, зохион байгуулалтгүйгээр тал талаас Сүхбаатарын талбайд цугларч, Засгийн газар, УОК-оос хариуцлага нэхсэн.

“Жагсагч, дэмжигчдийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага”-ын хувьд бүгдээрээ нэг зорилго, үзэл санаанд нэгдэж тэмцлээ илэрхийлсэн. Цуглааны үеэр олон нийтийг хамарсан үймээн самуун болоогүй. Харин ард иргэдийн итгэл үнэмшлээрээ цугласан тайван жагсаалыг улс төрийн зорилгоор ашиглах гэсэн үйлдлүүд энэ үеэр гарч ирсэн талаар албан бус мэдээллүүд явагдсан.

2021.01.20. /ЛХАГВА/ 19.00 цаг. Сайд нар огцрох мэдэгдэл хийв.

Төв талбайд тэмцэж буй иргэдэд хандан 19.00 цагт УОК-ын дарга Я.Содбаатар, ЭМ-ийн сайд Т.Мөнхсайхан нар хариуцлага хүлээж огцрох мэдэгдэл хийсэн. Уг мэдэгдэлд өөрсдийн огцрох өргөдлийг өгсөн талаар хэлсэн боловч өөрсдийн хүслээр шууд огцрох боломжгүй байдаг байна.

2021.01.21. /ПҮРЭВ/ Эрүүл мэндийн сайдаа өмгөөлөн салбарын ажилтнууд жагсаал хийсэн.

Пүрэв гарагийн өглөөний 08.00 цагаас эхлэн эрүүл мэндийн салбарынхан “Сайдаа үлдээ” хөдөлгөөн өрнүүлж, эмнэлгүүдээ төлөөлөн ирсэн эмч, мэргэжилтнүүд “мэргэжлийн сайдаа үлдээх” хүсэлтийг Ерөнхий сайдад хүргүүлсэн.

2021.01.21. /ПҮРЭВ/ Ерөнхий сайд танхимаараа огцрох мэдэгдэл хийлээ

2020 оны УИХ-ын сонгуулийн дараа Ерөнхий сайд У.Хүрэлсүх Засгийн газрын тэргүүнээр улиран сонгогдож, долоодугаар сарын 6-нд шинэ Засгийн газраа байгуулсан. У.Хүрэлсүхийн Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон асуудал эрхэлсэн нийт 17 гишүүнтэйгээр ажиллаж байсан юм.

Үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор Засгийн газрын ээлжит бус

хуралдаан зарлаж, энэ хуралдаанд Ерөнхий сайд У.Хүрэлсүх танхимаараа огцрох санал гаргасныг Засгийн газрын гишүүд санал нэгтэй дэмжсэн.

16.00 цаг. Ерөнхий сайд У.Хүрэлсүх огцрох болсноо ард иргэддээ дуулгаж, мэдэгдэл хийлээ. Нялх биетэй ээжийг ХӨСҮТ рүү тээвэрлэхэд алдаа гаргасан хариуцлагагүй эмч, мэргэжилтнүүдийн өмнөөс Ерөнхий сайд уучлалт хүсэж, ёс зүйн хариуцлага хүлээж огцрох шийдвэр гаргалаа гэв. Төрийн дунд, доод шатны албан хаагчид алдаа гаргавал ажилтан шийтгүүлээд, дарга нь үлддэг уламжлал өөрчлөгдөж, Ерөнхий сайд нь огцордог жишиг эндээс эхлэн тогтож байна хэмээгээд цаашид төрийн бүх шатны албан хаагчид ажилдаа хариуцлагатай хандахыг хатуу сануулав.

17.00 цаг. Ерөнхий сайдын энэ мэдэгдлээс хойш цагийн дараа буюу 17.00 цагт Ерөнхийлөгч Х.Баттулга ҮАБЗ-ийн шуурхай хуралдаан зарласан ч Ерөнхий сайд очсонгүй. Мөн үеэр УИХ-ын ТББХ хуралдаж, Ерөнхий сайдын өөрийн хүсэлтээр огцрох шийдвэрийг хэлэлцэн, гишүүдийн олонх дэмжлээ. Үргэлжлүүлэн УИХ-ын нэгдсэн чуулганаар уг асуудлыг хэлэлцэв.

2021.01.21-ний өдөр. Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх тухай албан бичгийг Ерөнхийлөгчид хүргүүллээ.

Үндсэн хуулийн 39-р зүйлийн 2-рт: Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл

олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заажээ.

2021.01.22 /БААСАН/ 32 дахь Ерөнхий сайдаар л.оюун-эрдэнийг нэр дэвшүүллээ.

2021.01.22. /Баасан/. Улс төрийн амьдралын шинэ өглөө эрх баригч намын хувьд 32 дахь Ерөнхий сайдыг тодруулах МАН-ын Удирдах зөвлөлийн хуралдаанаар эхэллээ. Намын цагаан байранд болсон уг хуралдаанаар дараагийн Ерөнхий сайдаар ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнийг тодруулж, УЗ болон МАН-ын Бага хурлын гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Санхүүжилт, дэмжлэг

Уг цуглаан нь иргэд аажмаар үүссэн тул ямар нэгэн санхүүжилт, дэмжлэг байгаагүй. Харин “Ерөнхий сайд огцрох мэдээлэл өгөх үедээ Ерөнхийлөгч Х.Баттулгыг уг цуглааныг санхүүжүүлээ”, зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр “АН зохион байгууллаа” гэх зэрэг мэдээллүүд явж байсан хэдий ч албан ёсны баримт нотолгоо гарч ирээгүй.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	“ЭМЯ-ийн сайд Т.Мөнхсайхан, УОК-ын дарга Я.Содбаатар” нарыг огцруулах шаардлага үр дүндээ хүрч огцрох өргөдлөө 2021 оны 1-р сарын 21-ны өдөр уламжилсан. “УОК болон ЗГ-ыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулах” зорилго 2021 оны 1-р сарын 22-нд МАН-ын ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-эрдэнэ ерөнхий сайдын үүргийг авч, У.Хүрэлсүх огцорсноор үр дүндээ хүрсэн.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Эрх баригчдаас жагсагч, дэмжигчдийн тавьсан зорилгын дагуу арга хэмжээ авсан.
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Үгүй.
4	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Үгүй.
5	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Үгүй.

Цуглаан болсноос хойш 1 хоногийн дотор буюу 2021 оны 01-р сарын 21-ны өдөр Ерөнхий сайд У.Хүрэлсүх огцрох мэдэгдэл хийж, 01-р сарын 22-нд Л.Оюун-эрдэнэд ажлаа хүлээлгэн өгсөн.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх жагсагч, дэмжигчдэд хандан хэлэхдээ:

- “Дөнгөж төрсөн эмэгтэйг ХӨСҮТ-рүү зөөхдөө хариуцлагагүй, хүнлэг бус хандсан нь Ерөнхий сайдын хувьд сэтгэлийг маань эмзэглүүлсэн үйл явдал боллоо. Ийм хариуцлагагүй байдал гаргасан нөхдийн өмнөөс тэр эмэгтэйн ар гэр, иргэдээсээ чин сэтгэлээсээ уучлал хүсч байна. Тиймээс Ерөнхий сайд, Засгийн газар хариуцлага хүлээх ёстой гэж бодож байна. Алдаа гарвал төр засаг үүрч чаддаг байх ёстой. Би үүнийг байнга сануулж ирсэн ч бид тэр эмэгтэйг элэг шимшрэм байдалтай авч явсанд дахин гүнээ хүлцэл өчиж байна. Энэ

алдаанаас болж хоёр сайд огцрох өргөдлөө өгсөн. Саяны болсон үйл явдлын талаар иргэд, залуучууд талбай дээр цуглаж, хариуцлагагүй байгаагаа илэрхийлж, жагсаал хийсэн. Энэ маш зөв зүйл байсан. Ерөнхий сайдаасаа хариуцлага нэхсэнийг би үүрч байна. Ёс зүйтэй төр, Ерөнхий сайд байх ёстой, алдаа гаргасан бол түүнийгээ үүрч чаддаг, хариуцлагыг хамтаараа үүрдэг гэсэн зарчмын дагуу хариуцлага үүрч, Ерөнхий сайд гэсэн эрхэм албан тушаалаас огцорч байгаагаа албан ёсоор мэдэгдэж байна” хэмээн мэдэгдэж, Засгийн газар огцорч байсан түүхтэй.

Жагсагч, дэмжигчдийн анхны зорилго болох “ЭМЯ-ийн сайд Т.Мөнхсайхан, УОК-ын дарга Я.Содбаатар” нарыг огцруулах шаардлага үр дүндээ хүрч хоёр сайд огцрох өргөдлөө 2021 оны 1-р сарын 21-ны өдөр уламжилсан. Удаах зорилго болох

“УОК-ыг огцруулах” болон “УОК болон ЗГ-ыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулах” зорилго 2021 оны 1-р сарын 22-нд МАН-ын ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-эрдэнэ ерөнхий сайдын үүргийг авч, У.Хүрэлсүх огцорсноор үр дүндээ хүрсэн.

Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Пүрэвсүрэн, Л.Галбаатар нарын бичсэнээр²³:

- Олон улсад “аяндаа үүссэн цуглаан” хэмээн нэрлэдэг ойлголт мөрдөгддөг бөгөөд хэн нэг хүний хэлсэн үг, бусдын хийсэн цуглаан, эсхүл тодорхой үйл явдалд хариу болгон зохион байгуулсан цуглааныг ийнхүү нэрлэдэг. Ийм цуглааны үед зохион байгуулагч огт байхгүй байж болно. Урьдчилан мэдэгдэл өгөх хуулийн хугацааг баримтлах боломжгүй байж ч болдог. Сүхбаатарын талбай дээрх халаадтай жагсаал мөн адил аяндаа үүссэн цуглааны шинжийг агуулж байна. Нөгөө талаас, хөл хорионы зэргийг сулруулсан үеийн цуглаан тул энэ цуглааныг хууль зөрчсөн гэж үзэхгүй.

Мөн албадан тараах нөхцөл үүсэхгүй байсан.

Цуглааны үеэр ямар нэгэн хүчирхийлэл, олныг хамарсан үймээн самуун гараагүй бөгөөд хууль зөрчсөн үйлдэл гаргалгүйгээр үр дүндээ хүрсэн гэдгээрээ онцлог юм.


Асуудал бэрхшээл, хүлээгдээгүй үр дагавар

Энэхүү цуглааны үр дагавар У.Хүрэлсүхийн Засгийн газрыг огцруулах болон хувирсан нь жагсагч, дэмжигчдийн шаардлага байгаагүй. Мөн энэ нь нийгмийн сүлжээн дэх бичвэр, сэтгэгдлүүдээс илэрч байлаа. Энэхүү үйл явдлаас хагас жилийн дараа Ерөнхий сайд асан У.Хүрэлсүх Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж ялсан. Ерөнхий сайдын ажлаа хийж чадаагүй гээд өөрийн хүсэлтээр огцорсон хүнээ Ерөнхийлөгчөөр сонгосон нь цуглааны үр дүн болон иргэдийн сонголт хооронд том асуултын тэмдэг үлдээсэн явдал болсон.

²³ Ikon.mn, [Аяндаа үүссэн цуглааныг тараах эрх бий юу?](#), 2021.01.20

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
1		Жагсаал цуглааны асуудлаа оновчтой тодорхойлж, бодитой үр дүнд хүрэх шаардлага тавих	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
2		Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох хуулийн зохицуулалтын мэдлэгтэй болох: <ul style="list-style-type: none"> Хаана, хэрхэн, ямар байдлаар бүртгүүлэх Жагсаал, цуглаан зохион байгуулагчийн эрх үүрэг Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээ авах гэх мэт 	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
3	Жагсаал, цуглааны өмнөх, бэлтгэл шатад хамаарах	Жагсаал, цуглаан зохион байгуулах талаар төлөвлөгөө, дүрэмтэй байх: <ul style="list-style-type: none"> Байршил, үргэлжлэх хугацаа гэх мэтийг тусгасан зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах Жагсаал, цуглааны зорилго, хүргүүлэх шаардлага, хүлээгдэж буй үр дүн зэргийг тодорхойлсон агуулгын төлөвлөгөө гаргах Жагсаал, цуглааны үеэр зөвшөөрөгдөх болон хориглох зүйлсийн талаар жагсаалд оролцогчдод урьдчилан сануулах, мэдээлэл түгээх 	Жагсаал зохион байгуулагч
3		Жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөг урьдчилан олон нийтэд түгээн, ашиг сонирхлын хувьд нийцтэй бүлгийг урьж оролцуулдаг байх	Жагсаал зохион байгуулагч
4		Оролцохоор төлөвлөж буй жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөтэй сайтар танилцаж, оролцогч болох эсэх талаараа шийдвэр гаргах	Жагсаалд оролцогчид
7	Жагсаал, цуглаан зохион байгуулагдаж буй үед хамаарах	Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчдын зүгээс жагсаал, цуглааны үеэр ашиглах үг хэллэг, уриа лоозон, бэлгэ тэмдэгтээ маш анхаарал, болгоомжтой хандаж байх. Олон нийтийг хууль бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өдөөн хатгахаас маш сэрэмжтэй байх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
10		Олныг хамарсан томоохон хэмжээний жагсаал цуглааны үеэр гуравдагч этгээдүүд өөрийн эрх ашгийн үүднээс санаатайгаар явуулга хийх, худал мэдээлэл тараах, жагсаал цуглааны зорилгыг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хувиргах зэрэг эрсдэл байдаг тул өөрийн үзэл бодол, ашиг сонирхолд нийцтэй байдлыг цаг ямагт шалгаж, хэрсүү байх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
11	Жагсаалын дараах үед хамаарах	Жагсаалын үр дүнг өөрсдийн эрх ашгийн төлөө хэн нэгэн буруу зорилгоор ашиглах, гуйвуулахаас сэргийлж, бодит үр дүндээ хүрч байгаа талаар хариуцлага тооцдог байх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид




ДӨРӨВ. “МОНГОЛОО АВАРЪЯ” НЭРТЭЙ ЖАГСААЛ (2022)

Зургийн эх сурвалж:
ikon.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан болсон, дууссан огноо, байрлал	✓ 2021 оны 10 сарын 15-2021 оны 10 сарын 31 Д.Сүхбаатарын талбай
2	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Дуучин, УИХ-ын гишүүн асан С.Жавхлан
3	Жагсаал, цуглааны хэлбэр, төрөл, процесс, үе шат	Хөдөлгөөн, суулт, Суултаас Өлсгөлөнд шилжив.
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, УИХ-ын дарга Г.Занданшатар болон ЗГ-т
5	Хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газраа хуралдуулж, улсдаа онц байдал тогтоож, эрх мэдэлтнүүд өөрсдөө дрон нисгэж, дижитал үндэстэн арга хэмжээгээр олон айлын хүүхдүүдийн амь насанд заналхийлэл учруулж алсан ажлууддаа тайлбар тавих ✓ Талбай дээр Ерөнхий сайдыг халз мэтгэлцээнд дуудаж буйгаа илэрхийлсэн ✓ ЗГ огцрохыг шаардсан.
6	Жагсаал, цуглаанд хамрагдсан хүний тоо, онцлог	Тодорхойгүй. 21 аймгаас Жавхлан зохион байгуулагчийг уриалж, дуудсан учраас хүрэлцэн ирсэн иргэд байв. Монголоо аваръя уриатай улс төрийн жагсаалыг өнгөрөгч 2016 онд хийж байсан бөгөөд энэхүү нэр томъёог ашигласнаараа онцлог байна. ЦЕГ-ын мэдээллээр өдөрт 40-50 хүн тогтмол цугласан байна.
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	"Монголоо Аваръя" уриатай



*ubn.mn болон dorgio.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

#	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Жагсаал зохион байгуулагч: Шаардлага тавьж байгаа ЗГ зэрэгт хандаж хэлж буй үеэрээ сэтгүүлчдэд хувийн хандлагаар уурлаж хандсан.Сэтгүүлчдийн асуултад хариулахдаа тэдэнтэй мэтгэлцэж буй мэтээр хандав.
2	Улирал, цаг агаарын байдал	Намрын улирал, дундаж температуртай.
3	Эсрэг жагсаал, цуглаан байсан эсэх	Байгаагүй
4	Хурцадмал байдал үүссэн эсэх	Өлсгөлөн зарлаж, өөрийн эрүүл мэндийн эсрэг үйлдэл гаргасан эрсдэл үүссэн
5	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Чөлөөт индэр ажиллуулах зэрэг хэрэгслийн бэлтгэл хангасан байсан

Иргэн С.Жавхлан нь Засгийн газрыг огцрохыг шаардаж, 2021 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Сүхбаатарын талбайд “Монголоо аваръя” нэртэй жагсаал, цуглаан зохион байгуулж, суулт хийж түүнийг дэмжиж олон иргэд цуглаж үзэл бодлоо илэрхийлсэн. С.Жавхланг суулт хийх явцад Отгонбаяр гэх иргэн “С. Жавхлан Хамаг Монгол нэртэй төсөл хэрэгжүүлж, 21 аймгаар тоглолт хийхээр төлөвлөж, уг төслөө хэрэгжүүлэхийн тулд Сангийн Сайдаас 4 тэрбум төгрөг өгөхийг шаардаж шантаажилж, 4 тэрбум төгрөг

өгөхгүй болохоор нь эсэргүүцэж жагсаал, цуглаан зохион байгуулсан” гэж мэдэгдсэн. Мөн үүний дараа Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан хэвлэл мэдээллийн байгууллагаар мэдээлэл өгөх үеэрээ “Гишүүн асан С.Жавхлан миний өрөөнд орж ирээд олон асуудлыг ярилцсан. Мөн “Хамаг Монгол төсөл”-өө 21 аймгаар хийхээр төлөвлөж байгаа, энэ төслийг санхүүжүүлэхийн тулд 4 тэрбум төгрөг шаардлагатай, тэрхүү мөнгийг улсын төсөвт суулгаж гаргаж өгөхийг шаардсан” гэж хэлсэн байна.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Үгүй
2	Олон нийтийн дэмжлэг	21 аймгийн иргэд зорьж ирсэн. Мөн дуучин, жүжигчин зэрэг урлагийн салбарын иргэд дэмжихээр цугласан. Дэмжиж буйгаа илэрхийлж байсан. Жагсаал цуглаан хийж, 20 жилийн ял авч байсан иргэн хүрэлцэн ирсэн байв. Монголын бөөгийн холбооноос дэмжигчид ирж, цөөнгүй удаа бөөлсөн.
3	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Тодорхойлох боломжгүй
4	Төр засаг, эрх баригчдын хандлага, шийдвэр	16 өдрийн турш тасралтгүй жагсаал зохион байгуулсан ч ЗГ-ын төлөөллөөс гарч ирж уулзалт хийгээгүй.
5	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Ямар нэгэн зөвшилцөлд хүрээгүй бөгөөд жагсагч иргэн С.Жавхлан эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлэгт хүргэгдэн зогссон. Тэрээр эргэн ирж жагсаалаа үргэлжлүүлэх тухай цахим хаягаараа дамжуулан бичиж байсан ч тус жагсаал үргэлжлээгүй.
6	Жагсагч нарын тавьсан шаардлага үр дүнд хүрсэн эсэх, биелүүлээгүй шаардлага юу болох	Үр дүнд хүрээгүй.
7	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Үгүй. Мэдүүлэг авахаар цагдаагийн байгууллагаас авч явахыг завдсан ч чадаагүй

Иргэн С.Жавхлан нь суулт хийх явцдаа өлсгөлөн зарлаж, улмаар 17, 18 хоног гадаа хүйтэнд суусны улмаас биеийн байдал нь муудаж эмнэлгийн байгууллагад хүргэгдсэн байна. Ийнхүү Жагсаал, цуглаан хийх үеэр ЗГ болон УИХ-ийн гишүүдээс нэг ч удаа С.Жавхлан болон түүнийг дэмжиж үзэл бодлоо илэрхийлж буй иргэдтэй уулзаагүй, шаардлага эсэргүүцлийг нь сонсоогүй байна.

Жагсагч иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд тулгарсан, зөрчигдсэн эрхийн зөрчлийн тохиолдлууд:

Уг 4 тэрбум төгрөгийн асуудлаар Цагдаагийн байгууллага иргэн С.Жавхлангаас тайлбар, мэдүүлэг авахаар дуудаж, суулт хийж буй Сүхбаатарын талбай дээр ирж С.Жавхланг хүчээр авч явахыг завдсан байна. Мөн суулт зарлаад буй С.Жавхлан болон түүнийг дэмжиж хамт үзэл бодлоо илэрхийлж буй иргэд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатарын талбай дээр майхан барих гэтэл цагдаагийн алба хаагчид талбай дээр майхан бариулахгүй, майхан барих хориотой гэж майхныг нь булааж авсан байна.

Шигтгээ 2. Жагсагчдын эрх зөрчигдсэн тохиолдлууд

С.Жавхлан 2021 оны 10 дугаар сарын 09-ны өдөр өөрийн цахим хаягаар цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж Улсын Их хурал, Засгийн газрыг тараах зорилгоор 10 дугаар сарын 15-ны өдөр "Монголоо Аваръя" гэх уриатай цуглааныг зохион байгуулж суулт хийх талаар 15:00 цагт "MPA.MN", "ZOGII.MN", "ZUV.MN" сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээлэл хийж 1 ширхэг эсгий гудас, 2 ширхэг эсгий дэвсгэр, 3 ширхэг лоозонтойгоор Жанжин Д.Сүхбаатарын хөшөөний урд хэсэгт "суулт" хийж эхэлсэн.

ЦЕГ-т тус суулттай холбоотой тэмдэглэлээс...

Мөн Цагдаагийн байгууллагаас тус жагсаалыг хууль бус, бүртгэлгүй цуглааны үйл явц идэвхжиж жагсаал, цуглаанд оролцогчдоос төрийн эрх бүхий байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулсан, нийгмийн хэв журмыг гажуудуулахад чиглэсэн хууль бус үйлдлээс үүдэн хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй байсан хэмээн дүгнэжээ.


4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

Эдгээрээс дүгнэхэд жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилт хангалттай түвшинд хэрэгжиж чадахгүй байх бөгөөд үзэл бодлоо илэрхийлсэн иргэн бие махбод, нэр төр, эрүүл мэндээрээ хохирч үлдэх цаашлаад хуулийн хариуцлага хүлээх явдал нэмэгдэх болжээ. Үүнээс болж иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх дуу хоолой хумигдах аюултай юм. Майхан барих эсэх асуудлаар маргаан үүссэнээс харахад иргэд, жагсагчид өөрсдийн жагсаалтай холбоотой эд хэрэгсэл зэргийн жагсаалтыг сайтар гаргаж, цагдаагийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай болж байна. Мөн жагсаал зохион байгуулагч С.Жавхлангийн хувьд 2010 оноос хойш олныг хамруулсан жагсаал, цуглаан хийж байсан олон удаагийн туршлагатай ч өмнөх сургамж, уур амьсгал зэрэгт туршлагатай хандах хэрэгтэй байсан гэж ажиглагдана. Жагсаал цуглаан хийж, ирээдүйд үг үзэл бодлоо илэрхийлэх иргэдийн, нийтийн эрх ашгийг тухай жагсаал цуглаан зохион байгуулагчид анхаарах асуудал чухал юм. Жагсана гэдэг төлбөртэй хөдөлмөр эрхлэлт болж буй мэт Ардчилсан нийгмийн хамгийн чухал үйл явцын талаарх үнэ цэнэ буурах эрсдэлтэй.

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

Жагсагчдад зориулсан зөвлөмж

- Хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудтай харилцах, өөрийн өгөх ёстой шаардлагад анхаарах, хэт их сэтгэл хөдлөлөөр мэдээлэл өгөхгүй байх;
- Өөрийн эрхийн төлөөх үйлдлийг бусдын эрхэд халдаж байгаа зүй бус үйлдлээр илэрхийлэхгүй байх;
- Засгийн газар, эрх баригчдад чиглэсэн шаардлагууд тодорхой байх, хамтын нэгдмэл ойлголттой байх;
- Өөрийн эхлүүлсэн суултын үндэслэл, шалтгаанаар эмх замбараатай чиглүүлэг хийх;
- ЗГ болон эрх баригчдад хандаж буй шаардлагын үр дүн болоод цаашдын төлөвлөгөөг боловсруулсан байх;
- Дээд доод танхим, Ерөнхийлөгчийн засаглалтай байх гэх мэт улс төрийн эмзэг сэдвийн талаарх үндэслэлтэй, судалгаатай баримттай зүйл санал болгох;
- Сэтгэл хөдлөлийн шинж чанартай хүчтэй бус, жагсаалын уур амьсгалын тогтвортой байдалд анхаарах;
- Нээлттэй микрофон ажиллуулж, бусад үймүүлэх сэдэлтэй хүмүүсийн яриаг нэгтгэж яриулах эсэхээ тооцоолох;
- Жагсаал зохион байгуулагч нь өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ тодорхой шаардлагынхаа хүрээнд хувь хүн рүү дайрсан, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх;
- Тайван замаар жагсаж байгаа жагсагч нь хүчирхийллийн аргыг бусдад үг болон үйлдлээрээ хориглох нь жагсаал, цуглааны үр дүнд сөргөөр нөлөөлнө;
- Хэт ерөнхий, биелэх магадлал хийсвэр шаардлагыг тавьж жагсахаас зайлсхийх;
- Зорилго тодорхойгүй байдал нь дэмжигч оролцогчдыг төөрөгдөлд оруулах, дэмжлэг буруу тийш эргэх нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх;



ТАВ. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДЫН СУУЛТ, ЖАГСААЛ (2021)

Зургийн эх сурвалж:
24tsag.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан болсон, дууссан огноо, байрлал	✓ 2021 оны 6 сарын 26- 2021 оны 7 сарын 7, Д.Сүхбаатарын талбайд
2	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Эрүүл мэндийн салбарын үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн Х.Ариунаа, дэд дарга Ч.Нарантуяа Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн үйлдвэрчний хорооны дарга Л.Энхсайхан, ХУД-ийн Эрүүл мэндийн төвийн үйлдвэрчний хорооны дарга Д.Соёлмаа, Гэмтэл согог сэргээн засах төвийн үйлдвэрчний хороон дарга С.Норжмаа, СХД-ийн эрүүл мэндийн төвийн үйлдвэрчний хорооны н.Цэвэлмаа, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлдвэрчний хорооны дарга н.Цогтбаатар нар
3	Жагсаал, цуглааны хэлбэр, төрөл, процесс, үе шат	ҮЭ-ийн Зохион байгуулалттай, эвлэлдэн нэгдэж, хөдөлмөрлөх эрхийн төлөө суултыг 10 гаруй хоног тасралтгүй зохион байгуулсан. Суултаар эхэлж тэмцлийн хурц хэлбэрт шилжиж ажил хаялт зарлах хүртэл явсан.
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Засгийн газар, ЭМЯ, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, УИХ-ын 76 гишүүн зэрэг шийдвэр гаргагчдад чиглэсэн



*news.mn, gogo.mn, itoim.mn болон zindaа.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> ✓ Эмч ажилчдын цалинг хоёр дахин нэмэх ✓ Цар тахлын үед эмч ажилчдад өгөх урамшууллыг улаан ногоон бүс гэж ангилахгүй бүгдэд тэгш олгох ✓ Эрүүл мэндийн ажилчдыг амь насны даатгалд хамруулах
2	Жагсаал, цуглаанд хамрагдсан хүний тоо, онцлог	Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц онцлог салбар учир нийслэл дүүргийн төв эмнэлгүүдийн ҮЭ-ийн холбооны дарга, төлөөллүүдийн бүрэлдэхүүнтэй 56 мянга орчим салбарын ажилчдыг төлөөлөн оролцсон бөгөөд тоо тодорхойгүй, Д.Сүхбаатарын талбайн 3/1 хэсгийг эзэлж байсан
3	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Эмч ажилчид сөхөрлөө, Туйлдаж байна, Үндсэн цалинг 2 дахин нэм зэрэг уриатай самбартай, ҮЭ-ийн цэнхэр хантаазаар жигдэрсэн оролцогчидтой
4	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Тайван замаар. Зарим оролцогчдын сэтгэл зүйн байдал сэтгэл хөдлөлтэйгөөр буюу өвчтөн эмчилж байгаад өөрсдөө сэхээнд орсон эмч, ажилчдын нөхцөл байдлыг илэрхийлж, шаардлагаа уйлж тайлбарлах тохиолдол байсан.
5	Улирал, цаг агаарын байдал	Ширүүн бороотой, халуун нартай өдрүүд ээлжилсэн зуны улирал

2021 оны 6 сарын 26 өдрөөс эхлэн 10 гаруй хоног үргэлжилсэн уг жагсаалаар Эмч ажилчдын цалинг 2 дахин нэмэгдүүлж, ачаалалтай ажиллаж байгаа эмч нарын өөрсдийнх нь эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн дутагдалтай байдлыг бодлогоор зохицуулах шаардлагыг ЗГ-т хүргүүлсэн. Голлох шаардлага нь цар тахлын хүнд нөхцөлд ажиллаж буй эмч ажилчдын

цалин урамшууллыг улаан, ногоон бүс гэж ялгавартай байдлаар олгохгүйгээр бүгдэд ижил тэгш хандахыг тайлбарлаж, Д.Сүхбаатарын талбайд суулт зарлаж, хэрэв цалин нэмэгдүүлэхгүй бол ажил хаялт зарлахаа илэрхийлэв. Ингэхдээ үйлдвэрчний эвлэлийн жагсаал цуглаан зохион байгуулах тодорхой арга зүйн хүрээнд зохион байгуулсан байна.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Эсрэг жагсаал, цуглаан байсан эсэх	Байгаагүй
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Үүсээгүй
3	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Нэгдсэн арга зүй болох ҮЭ-ийн дотоодын болон ОУ-ын арга зүй, техниктэй
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Санамсаргүй байдлаар дарамтад орсон. Засгийн газрын шийдвэрт хууртагдсан
5	Олон нийтийн дэмжлэг	Салбарын эмч, ажилтнууд ажлын байраа орхих боломжгүй тул байгаа байгаа газраасаа бодит байдлыг илэрхийлэхүйц зураг, цөхөрч, ядарч, ээлжгүй амралтгүй ажиллаж байгаа нөхцөл байдлаа харуулсан, цахимаар нэгдэж, дэмжиж буйгаа илэрхийлсэн
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Санхүүжилт байгаагүй.
7	Төр засаг, эрх баригчдын хандлага, шийдвэр	Аргацаасан буюу судалж байна гэсэн шийдэлгүй хариу үйлдэл үзүүлж байсан ба тайван суулт зохион байгуулагчдад хэрэг үүсгэн, шалгаж дарамталсан

Хөдөлмөрлөх эрхийн асуудлаа шийдүүлэх шаардлагыг ЗГ-т тавьж 10 гаруй хоног усан бороонд цохиулж, халуун наранд шарагдан суулт зарласан эмч, ажилчдын цуглаан төдийлөн үр дүнд хүрээгүй. Тухайн үедээ Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо Засгийн Газартай 3 асуудлаар тохиролцоонд хүрч, хэлцэл хийсэн боловч ЗГ үүргээ бодитоор биелүүлээгүй байна. Мөн цар тахал, онцгой нөхцөлд ажиллаж буй алба хаагчдын цалин урамшуулал гурав дахин нэмэгдэх ёстой гэх журам хэрэгжээгүй. Ковид19-ийн тухайн хуульд ажил үүргээ гүйцэтгэж байгаад халдвар авсан эмч, ажилчдад нөхөн олговор олгоно гэж заасан байдаг ч энэ мөн л хэрэгжээгүй байна. Тиймээс тэд 2021 оны 9

дүгээр сарын 01-ний өдрийн хурлаараа эмч, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх үүргээ биелүүлээгүй учраас дараагийн арга хэмжээнийхээ талаар ярилцсан. Гэтэл хуралд суусан иргэн С буюу тэдний өмгөөлөгч тус хурлын талаар Ерөнхий сайдад гомдол гаргаж, хуралд оролцогчдын нэрсийг хавсаргажээ. Ийнхүү үр дүнд нь суулт зарласан нэр бүхий Монголын эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн холбооны төлөөллүүд ТЕГ-т шалгуулав. Үндэслэл нь төрийн эрх мэдлийг хүчирхийллийн аргаар авахад бэлтгэсэн, зохион байгуулсан, оролцсон, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн гэх үндэслэлээр шалгажээ.

Жагсагч иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд тулгарсан, зөрчигдсөн эрхийн зөрчлийн тохиолдлууд:

Шигтгээ 3. Жагсагчдын эрх зөрчигдсөн тохиолдлууд

...“2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр МЭМАҮЭХ-ны хурлаас хэлэлцсэн асуудлын талаар С-ийн Засгийн газарт бичсэн гомдлын мөрөөр би ТЕГ-т гэрчээр байцаагдсан. Өмгөөлөгч гэж бодсон хүн ийм зүйл хийнэ гэж бодоогүй. Эрүүгийн хуулийн 19.2-т заасан, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах гэмт хэрэгт шалгагдсанаас хойш өнөөг хүртэл ямар нэг шийдвэр гараагүй байна. Монгол Улсын хилээр гарах хориг тавигдсан. Энэ хэргийн талаар нэг ч мэдээлэл хийж болохгүй гэсэн, миний фейсбүүкийг бас шалгаж байгаа. “Ажлаа хийж болохгүй, ажлаа хийвэл шоронд явуулна” гэж сүрдүүлдэг. “Ажлаа хийж болохгүй” гэдэг нь жагсаал, цуглаан зохион байгуулахыг хэлдэг гэж ойлгодог...”

Энэ талаар ТЕГ-т гэрчээр дуудагдсан иргэн (нэрийг нууцлав) 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ХЭҮК-т дараах мэдээллийг өгчээ.

Олон улсын эрүүл мэндийн байгууллагын 2005 онд батлагдсан дүрэм, Засгийн газрын 2017 оны тогтоолын дагуу цар тахлын үед олон улсын эрүүл мэндийн дүрмийн үндэсний зохицуулагч байгууллага болохынхоо хувьд хариу арга хэмжээг тодорхойлж, УОК шийдвэр гаргах, Шуурхай штаб байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллах ёстой байсан. Гэхдээ ингэж ажиллаж чадаагүй. Хөл хорио тогтоох зэрэгт УОК мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжөөс давсан арга хэмжээ авч байсан...

(ХЭҮК-оос хийсэн социологийн судалгаанд оролцсон эмч нартай хийсэн ярилцлагаас)

КОВИД-19 цар тахлын үед байгууллагуудын хамтын ажиллагаа, ялангуяа ЭМЯ, УОК хамтарч ажиллахдаа маш сул санагдаж байна. Эрүүл мэндийн газар нь эмнэлгүүдтэй, эмнэлгүүд нь өрхтэйгөө, онцгой байдал, цагдаа гээд байгууллагууд хамтарч ажиллах тал дээр муу байна...

...УОК нь шийдвэрээ доод тушаалын хүмүүстээ түрүүлж мэдээлэхгүй, шууд иргэдэд зарлагдгаас олон асуудал дээр хоорондоо ойлголцохгүй байдал үүсэж байсан. Ялангуяа хөл хориотой холбоотой асуудалд их алдаа гаргасан. Одоо эрх биш ойлгож байгаа байлгүй дээ...

...УОК-ын шийдвэр түс тас их хэцүү. Ард түмэндээ мэдээлж ойлгуулахгүйгээр шууд л шийдвэр гаргадаг...

(ХЭҮК-оос хийсэн социологийн судалгаанд оролцсон эмч нартай хийсэн ярилцлагаас)

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

Эмч, эмнэлгийн ажилчид суулт, тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлаад ч үр дүнд хүрдэггүй тул салбарын хүний нөөцийн асуудал тулгамдаж, эмч ажилтнууд салбараа солих, гадаад улсыг зорих эрсдэлүүд бий болдог. Нарийн эрсдэл бүхий үр дагавруудаа нээлттэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэх, зөвхөн ажил хаялт гэх мэт хэвшмэл үг хэллэгээр шаардлага тавьж байгаа нь сэтгүүлчид асуудалд нухацтай хандах боломжийг олгохгүй байна. Эрүүл мэндийн салбарт хүний нөөцийн хомсдолыг зөвхөн тодорхой нэг шалгуур заах, түр арга хэмжээ авсан төдийхнөөр

зохицуулах боломжгүй юм. Нөгөө талаар хүний нөөцийн хомсдол нийгмийн сэтгэл зүйд эмч ажилчдыг буруутгах хандлага бий болох нь түгээмэл тул аль болох энэхүү эрсдэлээ тооцоолон өөрсдийн тэмцлийг илэрхийлэх стратеги баримтлах нь илүү үр дүнтэй. Үзэл бодлоо илэрхийлэх, төрийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих, шүүмжлэх, оролцох идэвх эрс нэмэгдсэн. Иргэний оролцоо, шүүмж дуу хоолойг шууд бусаар намжаах, хязгаарлах, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, тайван хуран чуулах эрх чөлөөг ноцтой зөрчих тохиолдол гарч, үзэл бодлоо идэвхтэй илэрхийлдэг иргэнийг албадан саатуулах,

баривчлах, эрүү, зөрчлийн хэрэгт холбогдуулан шалгах зэргээр айдас түгшүүр төрүүлж байгааг ХЭҮК энэ удаагийн болон ээлжит илтгэлүүдээрээ анхааруулж ирлээ. Дээрх тайван суултын тохиолдолд эв нэгдэл хамгийн чухал байсан ба тууштай байдлаа авч үлдэх, тухайн суулт зарласнаас хагас жилийн дараа үргэлжлүүлэн, тууштай тэмцэнэ гэж байсан ч 2 жилийн дараа оролцогч талууд шантарсан нөхцөл байдалтай байгаа нь ажиглагдлаа. Тодруулбал эл суулт болсноос хойш зохион байгуулж, ахалж байсан хүмүүст тодорхой эрсдэлүүд учирч, ахалж байсан нэг төлөөлөл нь 2024 оны 1 сарын байдлаар хүнд осолд орж, сэтгэл зүйн хувьд хүн цохилттой байгаа тул өмнөх түүхийг сөхөж, бидний судалгааны Фокус бүлгийн ярилцлагад орохоос татгалзаж буйгаа, мөн ҮЭ-ийн ажлаа өгсөн тухайгаа мэдэгдэж байсан юм.

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс


Жагсагчдад зориулсан зөвлөмж

- Нэг өмгөөлөгчид бус өөрсдийн жагсаал цуглааны талаарх хөндлөнгийн ажиглалт хийх иргэдийг бэлтгэх, нэгээс илүү өмгөөлөгчтэй ажиллах;
- Жагсаал, цуглаан зохион байгуулахаар санаачилга гаргасан, удирдлага, гол зохион байгуулагчид нь байр сууриа нэгтгэж, ямар ч үед нэгдмэл байр суурь илэрхийлэх;
- Хараат бус олон нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх туршлагатай баг, ТББ-тай хамтрах;
- Жагсагч хувийн нууцын мэдээллээ хамгаалуулах, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөнд халдсан бол ХЭҮК-т гомдол гаргуулан шалгуулах эрх зэргийг мэддэг байх буюу эрх зүйн орчинд хамгаалуулах анхан шатны мэдэгдэхүүнийг олж авах;
- Хэвлэл мэдээлэлтэй харилцахдаа өөрсдийн бодит байдлын талаар мэдээллийг түлхүү мэдээлж, шаардлага тавихдаа шинэлэг үг хэллэг хэрэглэх;
- Жагсаал зохион байгуулах олон улсын түвшинд шинэлэг арга зүйн талаар судалгаатай ажиллаж, бүтээлч хэлбэрээр, цахим болон биет байдлыг хослуулан хамтын үзэл бодлоо илэрхийлэх;
- Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил, үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөлийг хангах, ажиллагчдын тухайлбал: эмч, эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдлыг хангах талаар журамлах;
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг улс төрийн нөлөөнөөс ангид, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах, холбогдох хууль тогтоомжид боловсролын салбарын төрийн захиргааны байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн томилж, чөлөөлөх талаар нарийвчлан зохицуулах;
- Төрийн үйлчилгээний албанд дутагдалтай орон тоо, хүний нөөцийг нөхөх, нэмэлтээр хэрэгжүүлэх түр арга хэмжээ болон дунд, урт хугацааны бодлогыг тодорхойлох;
- Эрүүл мэндийн салбар нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц онцлох салбар тул улсын төсөвтэй шууд хамааралтай. Тиймээс жагсаал, суулт зарлагчдын хувьд улсын төсөв хэлэлцэх үе шатуудад анхаарал хандуулан, үр ашиггүй хэмнэж болох зардлуудыг илрүүлэн, шаардлагаа өөрсдийн тодорхой үр дүнд уялдуулж, ЗГ-тай хэлэлцээр хийх;
- Шийдвэр гаргагчид бүгд эрүүл мэндийн салбарын нарын асуудлыг мэдэх боломжгүй тул өөрсдийн тулгамдаж буй асуудлыг зөв эрэмбэлж, гомдоллох гэхээс илүүтэй бүтээлч хамтын ажиллагааны хүрээнд хэлэлцээр хийх арга барилд талуудыг бэлтгэх;
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд сэргээх үр дүнтэй механизмыг бүрдүүлэх;

- Эмч, ажилчдын цалинг хэдэн хувь нэмэх үү гэдгийг тооцоо судалгаа, төсвийн чадамж, улсын мөнгө санхүүгийн байдал зэргээс хамаараад шийднэ гэх тайлбарыг олон жил тайвшруулах замаар тайлбар тавьсаар ирсэн ЗГ-ын тооцоо судалгааг өрсөн өөрсдөө салбарын түвшинд хийж судлаад оновчтой шаардлага тавих;
- Эмч ажилтнууд ажил хаялт зарлана гэсэн ч иргэдийн өмнө хүлээсэн

тангаргаа ухамсарлан, ажлын бус цагаар үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх цагийг гаргаж жагсаал цуглаанд нэгдэж буй талаараа олон нийтэд зарлаж, иргэдийн дэмжлэгийг хүсэх сайн туршлагыг бий болгох;

- Үйл явц, санхүүжилт, стратеги, бүтэц, зохион байгуулалт зэргийг баримтжуулахад гол анхаарлаа хандуулах



ЗУРГАА. "МОНГОЛДОО САЙХАН АМЬДАРЪЯ" ЖАГСААЛ (2022)

Зургийн эх сурвалж:
news.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2022 оны 04 сарын 07 – 2022 оны 04 сарын 09
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай Хан-Уул дүүрэг, Маршалын гүүр Цахим орчинд – Гадаадад болон орон нутагт ажиллаж амьдарч буй иргэд цахимаар оролцсон
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	Жагсагчдын төлөөллийн засгийн газарт хүргүүлсэн шаардлагууд: <ul style="list-style-type: none"> ✓ Авлига, албан тушаалын хуулийн 22.1 дүгээр заалтыг шинэчлэх ✓ Үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн бодлогыг иргэдэд тэгш хүртээмжтэй хуваарилах ✓ Бизнес эрхлэгчдийг дэмжих, Хөгжлийн банкны асуудлыг шийдэх²⁴ ✓ Олон улсны төлбөр тооцооны системийг нэвтрүүлэх ✓ Дарга нарын хангамжийг зогсоох ✓ Үнийн өсөлтөд арга хэмжээ авах ✓ Татварын тухай хуульд өөрчлөлт оруулах
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ, Засгийн газар
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Зохион байгуулалтгүй иргэд, олон нийт
6	Оролцсон хүний тоо	10,000-15,000 орчим хүн /давхардсан тоогоор/
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	“Монголдоо сайхан амьдаръя”, “Ажлаа хий”



*Ubn.mn, Ikon.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

²⁴ Монгол Улсын хөгжилд өндөр хувь нэмэр оруулах төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тусгай чиг үүрэгтэйгээр 2011 онд “Хөгжлийн банкныг” байгуулж байв. Гэвч төрийн дээд албан тушаалтнууд энэхүү банкнаас зээл аван, эргүүлэн төлөөгүй юм.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Цар тахлын нөлөөллөөс үүдсэн эдийн засгийн хохирол, Үнийн өсөлт, амьжиргааны доройтол, цэцэрлэгийн сугалаа, Засгийн газар ажлаа зохих ёсоор хийхгүй байгаа байдал
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Тийм, Жагсаал үүссэн өдөр иргэд, олон нийт цахим сүлжээгээр мэдээлэл аван аажмаар нэмэгдэж ирсэн. Мөн Улаанбаатар хотод төдийгүй орон нутаг болон гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэд, олон нийт цахимаар “Монголдоо сайхан амьдаръя” хөдөлгөөнд нэгдсэн.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Үгүй
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Хангалттай бэлтгэл байгаагүй. Үүссэн нөхцөл байдалд бухимдсан жагсагч, дэмжигчид аажим аажмаар нэмэгдэж байсан.
5	Улирал, цаг агаарын байдал	Хаврын улирал

Суурь нөхцөл байдал

Цар тахлын нөлөөллөөс үүдсэн эдийн засгийн хохирол, үнийн өсөлтийн асуудал дэлхийн дахинд нүүрлэж байсан асуудал төдийгүй манай улсад ч мөн адил нүүрлэж байв. Монгол улсын хувьд хэрэглээний үнийн индекс 2021 оны 4 сард 5.2% байсан бол жагсаал болсон он буюу 2022 оны 4 сард 15.8%²⁵ болж өмнөх оноос 10 гаруй хувиар ихэссэн байна. Энэ нь орлогын хэмжээ бага байдаг манай улсын хувьд эмзэг нөхцөл байдал үүссэнийг харуулах нэг үзүүлэлт юм.

Энэхүү жагсаал үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлийн нэг нь цахим орчин дахь иргэд олон нийтийн идэвхжил юм. Жагсаал бүрэлдэн бий болохоос өмнөх өдрүүдэд хэвлэл мэдээллийн байгууллага “үнийн өсөлт”, “иргэд хоолгүй, хоосон хонож байгаа”, “бараа бүтээгдэхүүний худалдан авах чадвар эрс буурсан” гэх мэт мэдээлэл цахим орчинд хагас сая гаруй

хандалтыг авсан ба “иргэд үнэхээр туйлдаж буйгаа” илэрхийлсэн юм.

Харин 2022 оны 3 сарын 31-ны УИХ-ын чуулганы нэгдсэн хурлын үеэр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны дарга Х. Болорчулуун “ХАА-н салбар чадан ядан ажиллаж монголоо тэжээж байгаа. Дэлхий дээр өнөөдөр ийм хямдхан мах идэж байгаа, талх 100 төгрөг, гурил кг нь 100 төгрөг газар гэж байхгүй шүү гэдгийг би баталгаатай 100 хувь хэлнэ”²⁶ гэв. Уг орой иргэн О. О нь Сүхбаатарын талбайд үнийн өсөлт, өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн талаар “Дэлхийд байхгүй талхны үнэ биш, дэлхийд байхгүй цалин, татварын систем”²⁷ гэх нэртэй бичлэг хийж Х. Болорчулууны хэлсэн үгэнд дургүйцлээ илэрхийлэн олон нийтийн сүлжээнд байршуулжээ. Иргэн О. О нь тухайн бичлэгээрээ дамжуулан 4 сарын 4-ны өдрөөс эхлэн төв талбайд суулт хийхээ зарлаж, залуучуудыг уриалсан нь хагас сая

²⁵ [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)

²⁶ [Л.Болорчулуун: Дэлхий дээр манайх шиг хямдхан мах, гурил идэж байгаа улс байхгүй шүү \(zuv.mn\)](#)

²⁷ [О.Отгонтөгс: Дэлхийд байхгүй талхны үнэ биш дэлхийд байхгүй цалин, татварын систем, 76 малтай Монгол улс !! | Ву Зөв.мн | Facebook](#)

гаруй хүнд хүрсэн байна. Энэ мэтчилэн иргэд үнийн өсөлт, улс төр, хууль эрх зүйн шударга бус байдал, бүх нийтийн эрх хөндөгдсөн асуудлаар цахим орчинд үзэл бодлоо хүчтэй илэрхийлж эхэлжээ.

Жагсаал, цуглаан үүсэхэд хамгийн түрүүнд **бүтцийн эв таарах буюу хамтын зан төлөв** бүрэлдэх ёстой бөгөөд түүнд хүрэх бүтэцлэг хүчин зүйл байдаг.²⁸ Иймд цахим орчинд иргэд, олон нийт эвлэлдэн нэгдэж **онлайн идэвхжил** бий болсноор **нийгмийн хөдөлгөөний хамтын зан төлөв** бүрэлдэн бий болох үндэс болжээ.²⁹

Улмаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ огцом нэмэгдэж, ард иргэдийн амьдрал өдрөөс өдөрт дордож, цалин хөлсний худалдан авах чадвар буурч буйг эсэргүүцэж, иргэд тэр дундаа залуус Монгол Улсын Засгийн газрыг ажлаа хийхийг шаардаж 2022 оны 4 дүгээр сарын 7-ны 10:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийж эхэлсэн байна.

Тэмцлийн арга зам, зохион байгуулалт

Тухайн жагсаал, цуглааны хувьд урьдчилан бэлдсэн, бэлтгэл ажил байхгүй байсан бөгөөд аяндаа үүссэн, тайван замаар санаа зовж буй зүйлсээ цаасан дээр бичин гарч ирсэн юм. Мөн уг жагсаалыг холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл аваагүй байна.³⁰

Гол уриа: Төв талбай дээрх жагсагч, дэмжигчдийн барьсан самбар, социал хаягууд дээрх гол уриа үг нь **#Эх орондоо сайхан амьдармаар байна, #Үнийн өсөлтийг зогсоо, #Ажлаа хий, #Хүнсээ авч хүчрэхгүй 21-р зуун, #Тэвчээр тасарлаа!!!** Гэх мэт уриа, лоозонтой байжээ.

Зохион байгуулалтын хэлбэр: Аяндаа өөрсдөө үүссэн буюу ямар нэгэн зохион байгуулж, удирдаж байсан хүн байгаагүй. Цэвэр иргэдийн өөрсдийн санаачилга байсан. Гэвч зарим эх сурвалжийн мэдээллээр сүүлийн өдрүүдэд нь улс төрийн зохион байгуулалттай болж байна гэсэн албан бус мэдээлэл гарсан.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Аяндаа үүссэн, тайван хэлбэрээр явагдсан, зохион байгуулалтгүй Цахим сүлжээнд жагсаж чадаагүй, жагсах боломжгүй дэмжигчид нэгдсэн
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Жагсаалын эхний өдрийн дараагаар жагсагчдыг албадан тараах үед жагсагч залуучууд болон цагдаа нарын хооронд зөрчил үүсэв. Улмаар цагдаа нар хүч хэрэглэхдээ газар унаган чирч, дээрээс нь дэвсэлж буй зураг бичлэгүүд цахим сүлжээгээр тархсан.
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Сэтгэл хөөрөл, уриалан дуудах, нийгмийн үүсээд буй нөхцөл байдалд ихээхэн бухимдсан
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Тийм. Цагдаагийн албан хаагч болон иргэдийн хооронд зөрчилдөөн үүссэн. Тухайлбал, 69 иргэнийг баривчилж, саатуулсан нь жагсаал, цуглааныг намжаах, хүч хэрэглэн тараах явдал гэж ХЭҮК-оос дүгнэжээ. Саатуулагдсан жагсагчдын ар гэрийнхэнд нь мэдээлээгүй асуудлууд түгээмэл тавигдсан. Мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжийг хязгаарласан.

²⁸ Социологи, Смелзер Нейл, 2017 он

²⁹ Сүлжээний онол хийгээд Дижитал социологи, О. Мөнхбат, 2019

³⁰ Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга Н. Лхагвасайханаас ирүүлсэн 2023 оны 12 сарын 22-ны өдрийн 02/59 дугаартай албан бичиг

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Олон нийт цуглааныг маш ихээр дэмжиж, цуглаан үр дүнд хүрэх хүртэл нэмэгдсээр байсан. Үүгээр зогсохгүй орон нутаг болон гадаадад ажиллаж, амьдарч буй иргэд уриа лоозон барин зургаа авхуулан цахим орчинд дэмжиж буйгаа илэрхийлэн нэгдсэн.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Санхүүжилт байгаагүй
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

Монголд үүсээд буй үнийн хөөргөдөл, тэгш бус хүртээмж, эрх баригчдын бодлого, шийдвэрийг эсэргүүцсэн "Монголдоо сайхан амьдаръя" тайван жагсаал нь

Сүхбаатарын талбайд 4 сарын 7,8,9-нд гурван өдөр үргэлжиллээ. Энэхүү тайван жагсаалын үйл явцыг товч зураглан доор харуулав.



"Монголдоо сайхан амьдаръя" жагсаал, цуглааны үед үүссэн асуудал, дүгнэлт:

1. Бүтцийн хурцадмал байдал үүссэн нь: Жагсаал, цуглааны үеэр буюу 2022 оны 04 сарын 07-08-нд шилжих шөнө жагсагч залуучууд болон цагдаа нарын хооронд зөрчил үүсэж, жагсаалыг албадан тараахдаа цагдаа нар хүч хэрэглэн жагсагч залуучуудыг чирч унагаан дээрээс нь дэвсэлж буй зураг, бичлэгүүд 04 сарын 08-ны өглөө цахим сүлжээгээр тархсан байсан. Энэ нь олон нийтийн сүлжээгээр маш олон хүнд хүрсэн бөгөөд цагдаа болон ард иргэд хоорондын итгэлцэл эвдрэхэд

хүрсэн байна. Үүнээс болон иргэд олон нийтийн дургүйцлийг хүргэж нөгөө талаараа бүтцийн хурцадмал байдал³¹ бий болж байв.

2. Идэвхжүүлэх буюу хурдасгагч хүчин зүйл: Жагсаалыг албадан тараасны маргааш буюу 4 сарын 8-нд жагсаал эхэлсэн эхний өдрөөс хоёр дахин илүү жагсагчид Сүхбаатарын талбай дээр цугларчээ. Үүнд илүү өргөн цар хүрээтэй нөлөөлсөн хүчин зүйл нь цагдаа нарын жагсагч залуучуудыг хүчээр бариад зогсохгүй, жагсагчдын эсрэг ашиглах, хүчээр таслан зогсоохоор ус цацдаг машин болон

³¹ Социологи, Смелзер Нейл, 2017 он

сургуультай нохой бэлдсэн гэх мэдээ, зураг бичлэг 4 сарын 7-ны шөнөөс эхэн цахим орчинд тархсан нь хүчтэй нөлөө үзүүлж улмаар **идэвхжүүлэх буюу хурдасгагч хүчин зүйл** болж чадсан байна.

3. **Нэгдсэн үзэл, итгэл үнэмшил бүрдсэн нь:** Жагсаалд биеэр оролцож байсан болон цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж дэмжиж байсан хүмүүсийн дунд төр ард иргэдийнхээ эсрэг хүч хэрэглэж байна, цагдаа нар жагсагчдад дайсагнан хандаж байна гэсэн нэгдсэн үзэл, итгэл үнэмшил бүрдсэн байна. Энэ нь жагсаал идэвхтэй өрнөсөн хоёр дахь

өдөр цахим орчин дахь идэвхжил, Сүхбаатарын талбайд цугласан жагсагчдын барьсан “Залуучуудыг сулла”, “Хайрлаж мэдэхгүй дэвсэж л мэднэ”, “Монголын төр ард түмнийхээ эсрэг хэрхэвч хүч хэрэглэж болохгүй” зэрэг уриа лоозонгоос харагдаж байна. Мөн онлайн орчинд хөдөө орон нутгаас залуус нэгдэж буйгаа илэрхийлэн орон нутгийнхаа төв талбайд цугласан зураг, бичлэгийг цахим сүлжээнд тавьж байсан нь **онлайн идэвхжилийн** нэгэн жишээ болсон.



**Ubn.mn, Ikon.mn сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.*

“Монголдоо сайхан амьдаръя” жагсаалын үйл явцаас харвал нийгмийн хөдөлгөөн үүсэж бий болох, үргэлжлэх үйл явц бүр хоорондоо уялдаа холбоотой өрнөж, нэг нь нөгөөгөөсөө хамаарч буй юм. Нөгөө талаар нийгмийн хөдөлгөөн үүсэж бий

болох, үргэлжлэх үйл явц нь цахим орчинд хэн нэгний зохион байгуулалтгүйгээр бүтэцлэгдэж, ижилсэж нэгдсэн итгэл үнэмшил тархаж, идэвхжиж болдог гэдгийг харж болохоор байна.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Жагсаал цуглаан үндсэн зорилгодоо хүрсэн. Жагсагчдын 15 зүйл бүхий шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэсэн.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд Х. Нямбаатар, Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ зэрэг эрх баригчдын төлөөлөл жагсагч олон нийттэй уулзаж, зөвшилцлийн үйл ажиллагаа хийгдсэн.
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Албадан тараах шаардлага бүхий цагдаагийн хүчний байгууллагын үйлдэл гарч байсан.
4	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Хүний эрхийг зөрчсөн зөрчил гарсан. 69 иргэнийг албадан саатуулсан, 9 цагдаагийн албан хаагч бэртсэн асуудал үүссэн.
5	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Цуглааныг албадан тарааж, 69 иргэнийг албадан саатуулсан нь үндэслэлгүй, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна.

Жагсагчдын тавьсан шаардлагын дагуу Засгийн газар ээлжит бусаар хуралдаж, гаргасан шийдвэрээ 4 сарын 8-нд танилцуулав.

- Нэгдүгээрт, үнийн өсөлт хомсдолоос урьдчилан сэргийлэх хуулийг УИХ-аар 4 сарын 15-ны дотор амжуулж хэлэлцүүлэн эцэслэн батлуулахаар болсон ба хуулийн төслийг УИХ-д Засгийн газраас яаралтай байдлаар өргөн барьсан байна.
- Хоёрдугаарт, авлига, албан тушаалын хэрэгт яллагдагчаар татагдсан этгээдийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдэхгүй байх, авлигын хэргийн ялын бодлогыг чангатгасан хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар тогтов.
- Гуравдугаарт, Хөгжлийн банкны зээлийн асуудлыг шударгаар шалгаж, буруутай этгээдүүдийг илрүүлэх, хэргийг эцэслэн шийдвэрлэх талаар Засгийн газраас шалтгаалах бүх арга хэмжээг авч ажиллахаа амлав.
- Дөрөвдүгээрт, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөнгөлөлттэй зээлийн

хүртээмж, сонгон шалгаруулалтыг ил тод болгохоо мэдэгдэв.

- Тавдугаарт, Нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ, олон улсын төлбөр тооцоо, сонгуулийн хар машин, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй бүрэн эрхтэй холбоотой асуудлыг Засгийн газар дангаар шийдвэрлэх боломжгүй тул удалгүй Улсын Их Хурлын удирдлага, холбогдох Байнгын хороонд Засгийн газраас хүргүүлж хариу өгөхөөр болсон байна.

Засгийн газар жагсагчдын тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулан хамтран ажиллахыг 4 сарын 9-ны өдөр шийдвэрлэсэн. Ажлын хэсэгт эрх баригч, шийдвэр гаргагчид болон жагсагч иргэдийн төлөөлөл багтжээ. Энэхүү ажлын хэсэг нь ээлжит бус хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллав.

“Монголдоо сайхан амьдаръя” жагсаал, цуглааны дараа үүссэн асуудал, дүгнэлт:

Монгол Улсын Хүний эрхийн комиссоос гаргасан “Монгол Улс дахь Хүний эрх, эрч чөлөөний байдлын талаарх 2022 оны

илтгэл”-д энэхүү жагсаал, цуглааны хэрэгт холбогдуулан дараах хүний эрхийн зөрчлүүд илэрсэн гэж үзсэн байна. Үүнд:

1. “Монголдоо сайхан амьдаръя” жагсаалыг албадан тарааж, 69 иргэнийг албадан саатуулсан нь үндэслэлгүй, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна.
2. Саатуулагдсан жагсагчдын ар гэрийнхэнд нь мэдээлээгүй асуудлууд түгээмэл тавигдсан.
3. ХЭҮК-оос иргэдээс өгсөн мэдээлэл, гэрэл зураг, цахим орчинд нийтэлсэн гэрэл зураг, дүрс бичлэгээс иргэдийг баривчлах явцдаа цагдаагийн алба хаагчид зүй бус харьцаж, хүч хэрэглэсэн, хүний бие махбодод халдсан үйлдэл гаргажээ.
4. Баривчлагдсан, саатуулагдсан хүмүүст эрхийг нь танилцуулаагүй, баривчилсан үндэслэлийг хэлээгүй, өмгөөлөгчгүй байцаалт авсан, эрх зүйн туслалцаа авах эрхийг нь зөрчсөн;
5. Жагсаал, цуглаанд оролцсон хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэхийг хууль бусаар хязгаарлах, хуульч, өмгөөлөгчдийн биед нь халдах тохиолдолд гарсан байна.³²

Хүний эрхийн зөрчлөөс гадна сүлжээ сарниулагч тавьсан байж болзошгүй асуудал үүссэн байна. Сүлжээг хаасан бол хүний мэдэх эрхийг зөрчиж байгаа хэлбэр хэдий ч баримтаар тогтоогдоогүй учир ХЭҮК дүгнэлт гаргах боломжгүйгээ мэдэгдсэн юм.³³

Мөн түүнчлэн эрх баригч, шийдвэр гаргагч нар мэдээлэл хийхээр гарч ирэх үед жагсаалын бүтэц өөрчлөгдөж, гарч ирсэн хүн рүү ус, ундааны сав, талх гэх мэт олон төрлийн зүйл шидэх үйлдэл гарсан. Энэ үед жагсагч нэг эмэгтэйн толгой хагарсан тохиолдол гарчээ.

Жагсаал, цуглааныг албадан тарааж, 69 иргэнийг албадан саатуулсан нь үндэслэлгүй, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна. Гэхдээ 69 иргэн дунд насанд хүрээгүй хүүхэд, жагсаалд оролцоогүй хажуугаар нь өнгөрч байсан иргэд, согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүс гэх мэт олон төрлийн хүмүүс байсныг “Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн алба”-аас мэдээлжээ.


³² Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, ХЭҮК, 2022

³³ [ХЭҮК: Цагдаа нар жагсагчдын эрхэнд халдсан | News.MN](#)

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
1		<p>Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох хуулийн зохицуулалтын мэдлэгтэй болох:</p> <ul style="list-style-type: none"> • Хаана, хэрхэн, ямар байдлаар бүртгүүлэх • Жагсаал, цуглаан зохион байгуулагчийн эрх үүрэг • Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээ авах гэх мэт 	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>
2	Жагсаал, цуглааны өмнөх, бэлтгэл шатад хамаарах	<p>Жагсаал, цуглаан зохион байгуулах талаар төлөвлөгөө, дүрэмтэй байх:</p> <ul style="list-style-type: none"> • Байршил, үргэлжлэх хугацаа гэх мэтийг тусгасан зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны зорилго, хүргүүлэх шаардлага, хүлээгдэж буй үр дүн зэргийг тодорхойлсон агуулгын төлөвлөгөө гаргах • Эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах тухай эрсдэлийн төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны үеэр зөвшөөрөгдөх болон хориглох зүйлсийн талаар жагсаалд оролцогчдод урьдчилан сануулах, мэдээлэл түгээх 	Жагсаал зохион байгуулагч
3		Жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөг урьдчилан олон нийтэд түгээн, ашиг сонирхлын хувьд нийцтэй бүлгийг урьж оролцуулдаг байх	Жагсаал зохион байгуулагч
4		Оролцохоор төлөвлөж буй жагсаал, цуглааны талаарх мэдээлэл, төлөвлөгөөтэй сайтар танилцаж, оролцогч болох эсэх талаараа шийдвэр гаргах	Жагсаалд оролцогчид
5		Цагдаагийн байгууллагыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангах, түүнийг хэрэглэдэг арга барилд мэргэшүүлэх, сургах	Цагдаагийн байгууллага
6		Жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор олон хүн цугларсан газар очих бол ашиглах хэрэглэгдэхүүнээ зөв тодорхойлж, зэвсгийн чанартай хэрэгсэл болон шатах, дэлбэрэх зүйл авч очихгүй байх	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>
7	Жагсаал, цуглаан зохион байгуулагдаж буй үед хамаарах	Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчдын зүгээс жагсаал, цуглааны үеэр ашиглах үг хэллэг, уриа лоозон, бэлгэ тэмдэгтээ маш анхаарал, болгоомжтой хандаж байх. Олон нийтийг хууль бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өдөөн хатгахаас маш сэрэмжтэй байх	<p>Жагсаал зохион байгуулагч</p> <p>Жагсаалд оролцогчид</p>

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
8		Тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх гэж буй бол согтууруулах ундааны төрөл, зүйлийг хэрэглэхгүй байх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
9		Насанд хүрээгүй хүүхэд жагсаал цуглаанд оролцохгүй байх.	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
10		Хэрэв насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийн хараа хяналтгүйгээр жасаал цуглаанд оролцож буйг мэдсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлэх	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
11		Хэрэв согтууруулах ундааны төрөл, зүйлийг хэрэглэсэн хүн жагсаалд оролцож буйг мэдэх эсвэл оролцох хүсэлт тавивал оролцуулахгүй байх болон цагдаад нэн даруй мэдэгдэх хэрэгтэй.	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
12		Жагсаал цуглааны үеэр хууль бус үйлдэл болон гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өдөөн хатгах болон оролцохгүй байх.	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
13		Олон нийтийн сүлжээ, цахим орчинд тухайн жагсаалын талаарх уриа, зорилго, хүргүүлж буй шаардлага зэрэг жагсаалын үндсэн агуулга алдагдсан, гуйвсан мэдээлэл нь энэхүү орчинд түгээгдэх, бусдыг турхирах боломжтой учраас худал ташаа мэдээлэлд авталгүй, найдвартай мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл авах	Жагсаал зохион байгуулагч Жагсаалд оролцогчид
14	Жагсаалын дараах үед хамаарах	Жагсагч хувийн нууцын мэдээллээ хамгаалуулах, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөнд халдсан бол ХЭҮК-т гомдол гаргуулан шалгуулах эрх зэргийг мэддэг байх буюу эрх зүйн орчинд хамгаалуулах анхан шатны мэдэгдэхүүнийг олж авах	
15		Жагсаал, цуглаан хуулийн хүрээний хяналтаас гарсан, албадан тараах нөхцөл байдал үүссэн, онц байдал зарлах шаардлага гарсан үед төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлэх шийдвэрүүдийн талаар иргэд, олон нийт, жагсаалд оролцогчдод түргэн шуурхай мэдээлэл хүргэх, сануулах	Төрийн захиргааны байгууллага Цагдаагийн байгууллага




**ДОЛОО. "ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ -
ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХЭЭ ЭДЭЛЬЕ"
ЖАГСААЛ (2016)**

**НИЙГМИЙН ТҮНГЭЛЭЛ
ҮЛ ОЙШООХОО**

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2016 оны 05 дугаар сарын 02
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Чингисийн талбай
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> - 2015-2016 оны “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын гурван талт хэлэлцээр”-ийн Иргэдийн орлого, амьжиргаатай холбоотой заалтыг хэрэгжүүлэх - Хэлэлцээрт тусгасан цалин нэмнэ гэснийг 2016 оны 05 сарын 15-ны чуулганаар яаралтай хэлэлцэж, бодит шийдвэр гаргах - Улсын төсвийн хөрөнгөөр гэрээлэн ажил гүйцэтгэсэн компаниудын санхүүжилтийг олгох
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Эрх барих дээд байгууллага болох Засгийн газар, УИХ, Нийслэлийн Засаг дарга
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Монголын ҮЭ холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар, Дэд Ерөнхийлөгч С.Эрдэнэбат нарын тэргүүтэй Нийслэлийн 9 дүүргийн мэргэжил, үйлдвэрлэлийн 14-н ҮЭ-ийн холбооны гишүүд
6	Оролцсон хүний тоо	Жагсаалд 10 гаруй байгууллагын 5,000 гаруй ажилчид цугласан байна.
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	<p>“Эвлэлдэн нэгдэх-Хөдөлмөрлөх эрхээ эдэлье” уриатай тайз бүхий ананос, өнгө өнгийн ҮЭ-ийн туг далбаа, шар өнгийн хүзүүндээ туузтай, шар фонтой уриа лоозон.</p> <ul style="list-style-type: none"> - Ажилгүйдэл – Ядуурал - Шүүгчийн цалин 5 сая – Эмчийн цалин 500 мянган төгрөг - Хөдөлмөрийн хуулийн шинэчлэл дордох ёсгүй, - Үнийн өсөлтийн амыг тат <p>Гол уриа: Шаардаж байна!</p>



*<https://www.mpa.mn> сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрийн хүрээнд тусгагдсан цалин, хөлс нэмэгдүүлэх заалтууд хэрэгжээгүй, иргэдийн орлого, нийгмийн амьжиргаатай холбоотой эерэг өөрчлөлт гараагүй гэж жагсаал, цуглаан зохион байгуулагчдын зүгээс үзсэн.
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Уг жагсаал, цуглааныг зохион байгуулах тухай Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны цахим хуудсаар 7 хоногийн өмнөөс зарлал мэдээллийг түгээж, хэвлэлийн хурал зохион байгуулж, олон нийтийг уриалсан байна ³⁴ .
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Тийм,
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Бэлтгэл ажлыг маш сайн хангасан. Тайз зассан, микрофон өсгөгч ажиллуулсан, хэвлэмэл материал, уриа лоозон ихээр ашигласан
5	Улирал, цаг агаарын байдал	Зуны улирал, дулаахан

Хөдөлмөрийн тухай хуулийн 138 дугаар зүйлийг үндэслэн 1999 онд Засгийн газар, ажил олгогч, ажилтны эрх ашиг, сонирхлыг төлөөлөн хамгаалах, тэнцүү тооны төлөөлөл бүхий (тал тус бүрээс 6 гишүүн, нийт 18 төлөөлөлтэй) Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хороог Засгийн газрын дэргэд байгуулж ажиллуулдаг. Энэ хугацаанд 2000 оноос эхлэн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрийг 2 жилд 1 удаа буюу нийт 7 удаа байгуулж, хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар, Монголын үйлдвэрчний эвлэл, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулж ирсэн байв³⁵.

2014 онд буюу хоёр жилийн өмнө ам.долларын ханш 1680 төгрөг байхад олгогдож байсан цалин хөлс нэмэгдүүлэх талаарх шаардлагыг тавьж байжээ. Гэтэл 2016 оны 5 сар гэхэд ам.долларын ханш 2030 төгрөгт хүрсэн энэ үед цалин хөлс нэмэгдээгүй хэвээр байгаа тул 2015-2016

оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын гурван талт хэлэлцээрт тусгагдсан иргэдийн орлого, нийгмийн амьжиргаатай холбоотой заалтууд хэрэгжээгүй байна. Тиймээс тус заалтыг хэрэгжүүлэхийг ЗГ болон УИХ-аас шаардаж, албан байдлаар хүсэлт, шаардлагаа хүргүүлсэн боловч хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг ханах ажил эхлээгүй тул 14 хоногийн дотор уг асуудлаар бодитой шийдвэр гаргахыг шаардаж, МҮЭХ-ноос жагсаал, цуглаан зохион байгуулжээ.

Мөн 2014 оны 11-р сарын дундуур Шинэчлэлийн Засгийн газар огцорч, Эдийн засгийн хөгжлийн яам татан буугдаж, "Гудамж" төсөл хаана харьяалагдах нь тодорхойгүй болж, өөрийн хөрөнгөөрөө барилга, зам засварын ажил гүйцэтгэсэн компаниудын санхүүжилтийг хэрхэн шийдэх нь тодорхойгүй болжээ. Энэ ажлын хүрээнд үндэсний 22 компани гудамж, уулзвар, замын засвар, шинэчлэлтийн ажлыг хийж

³⁴ [Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо - "ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ -ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХЭЭ ЭДЭЛБЭ" жагсаал Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд 2016 оны 5 сарын 2 өдрийн 14:00 цагт болно. Facebook](#)

³⁵ [Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талтын тухай \(mlsp.gov.mn\)](#)

гүйцэтгэсэн ч санхүүжилтээ аваагүй байна. МУ-ын ЗГ-аас 2015 оны намар Монгол Улсын төсөвт тодотгол хийж, хувийн компаниудын ажлын санхүүжилтийг тусгажээ. Гэвч 2016 оны жагсаалыг хийх хүртэл тухайн санхүүжилтийг олгоогүй байв³⁶. Иймд “Гудамж төсөл”-ийн хүрээнд ажил гүйцэтгэсэн замын салбарт ажилладаг байгууллагын төлөөлөл уг жагсаалд өргөн бүрэлдэхүүнтэй оролцсон байна.

Уг жагсаал, цуглаан нь урьдчилсан бэлтгэл ажлыг маш сайн хангасан, өндөр зохион байгуулалттай гүйцэтгэсэн жагсаал, цуглааны жишээ юм. Холбогдох байгууллагад жагсаал зохион байгуулах талаараа бүртгүүлж, зөвшөөрөл авсан, олон нийтэд жагсаал цуглаан болох тухай мэдээллийг хүргэсэн, жагсаал, цуглаанд оролцогчдын нэгдмэл байр сууриа илэрхийлж буй байдал зэрэг нь бэлтгэл ажил өндөр түвшинд хангагдсан болохыг илэрхийлж байна.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Зохион байгуулалттай, тайван алхалт, бичгээр үйлдсэн шаардлага хүргүүлсэн
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Үгүй
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Салбар салбарын ҮЭ-ийн хороод өөр өөрсдийн амьдралын чанарт сэтгэл хангалуун бус байгаатай, тэмцэх сэдэлтэй
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Үгүй
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Замын инженер, улсын төсвийн хөрөнгөөр гэрээлэн ажил хийсэн компанийн төлөөллүүд, ТҮК, ЭМ-н салбарын ажилтан, багш, НД-н хэлтэс гэх мэт салбар бүрийн төлөөлөл иргэд, төрийн албан хаагч, ажлын байраа тогтвортой авч үлдэх хүсэлтэй энгийн иргэд зэрэг олон талын төлөөлөл дэмжиж хүрэлцэн ирсэн
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Санхүүжилт тодорхойгүй. ҮЭ-ийн нэгдсэн зохион байгуулалтын зардал, гишүүнчлэлийн татварын эх үүсвэр байх магадлалтай
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

Жагсаал, цуглаанд оролцогчид тухайн өдрийн 14 цагт Чингисийн талбайд цуглаж эхэлсэн бөгөөд байгууллага, Үйлдвэрчний эвлэлийн салбаруудын төлөөллүүд бүлгийн зохион байгуулалтаар цугласан нь энэхүү жагсаал, цуглааны онцлог тал байв.

Тус жагсаалд Нийслэл төдийгүй, Төв аймгийн ҮЭ-ийн холбоо, Багануур дүүрэг, Налайх, Багахангайн ҮЭ-ийн холбоо зэрэг орон нутгийн ҮЭ-ийн холбоодын төлөөлөл ирж оролцлоо³⁷.

³⁶ [Компаниуд “Гудамж”-наас санхүүжилтээ аваагүй байна \(shuud.mn\)](http://shuud.mn)

³⁷ [Компаниуд “Гудамж”-наас санхүүжилтээ аваагүй байна \(shuud.mn\)](http://shuud.mn)

Жагсаалд оролцогч эмч нарын төлөөллийн ярилцлагаас...

Эмч нар 3 сая хүртэлх цалин авч байж, одоо хийж байгаа ажилтайгаа дүйцэхүйц хөдөлмөрийн хөлс болно. Хууль, Шүүхийн байгууллагын ажилчдын цалинг нэмж болоод байхад эмч нарынх яагаад орхигдоод байгааг ойлгохгүй байна. Зөвхөн эрх баригчид өөрсдийгөө хамгаалуулах гэж тэдний цалинг нэмж байна уу, хүн ардын төлөө ажилладаг бид тэдэнд хамаагүй юу гэсэн асуудал дэвшүүлж жагсаж байна.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийн тэргүүлсэн Шинэчлэлийн Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн яам бондын хөрөнгөөр “Гудамж” төсөл хэрэгжүүлж, нийслэл төдийгүй орон нутгийн олон зам, гарц, явган хүний замыг шинэчлэн барьж бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлсэн билээ. Энэ ажлын хүрээнд үндэсний 22 компани

гудамж, уулзвар, замын засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн ч өнөөг хүртэл санхүүжилтээ аваагүй байна. Мөн нийслэлд зам барьсан компаниуд ч санхүүжилтээ авч чадаагүй аж. Энэхүү асуудлаар нийт 30-аад компанийн төлөөлөл цугларчээ.

Ажлын хөлсөө ЗГ-аас шаардсан Компанийн удирдлагын ярилцлагаас...

Эмч нар 3 сая хүртэлх цалин авч байж, одоо хийж байгаа ажилтайгаа дүйцэхүйц хөдөлмөрийн хөлс болно. Хууль, Шүүхийн байгууллагын ажилчдын цалинг нэмж болоод байхад эмч нарынх яагаад орхигдоод байгааг ойлгохгүй байна. Зөвхөн эрх баригчид өөрсдийгөө хамгаалуулах гэж тэдний цалинг нэмж байна уу, хүн ардын төлөө ажилладаг бид тэдэнд хамаагүй юу гэсэн асуудал дэвшүүлж жагсаж байна.

2014 онд авах ёстой санхүүжилт 2016 он хүртэл олгоогүй тасарсан. “Гудамж” төслийн хүрээнд нийт 26 уулзвар нээсэн, 22 компани үлдэгдэл санхүүжилтээ авч чадаагүй өдийг хүрчихлээ. Бид нийт 7.5 тэрбум төгрөгийг ЗГ-аас авах ёстой, бид нар бүтээн байгуулалт хийсэн, зүгээр суугаагүй ажилласан цалингаа авахаар шүүхээр явсаар байна...

Түүнчлэн “Иргэд ажилласан хэр нь ядуураад буй нь төр, засаг иргэнээ гэсэн тогтвортой бодлого баримтлахгүй байгаатай холбоотой” хэмээн МҮЭХ-ны дэд ерөнхийлөгч С.Эрдэнэбат хэллээ. Ингээд хийсэн ажлынхаа хөлсийг авах хүсэлтэй болон одоогийн цалингаа нэмэгдүүлэх, ажлын байраа тогтвортой байлгах зорилготой цугларсан 10 гаруй байгууллагын 5000 орчим ажилчин “Шаардаж байна... Шаардаж байна... Шаардаж байна” хэмээн дуу нэгтэйгээр

чанга дуугаар орилж, Төрийн ордныг нар зөв нэг удаа тойрч жагсаалаа дуусгав³⁸.

Уг жагсаал, цуглаан нь маш олон тооны оролцогчидтой боловч тайван замаар үзэл бодлоо илэрхийлсэн, хурцадмал байдал үүсэх нөхцөл бүрдээгүй, олон нийтийн дэмжлэг сайтай, оролцогчдод ямар нэгэн байдлаар дарамт шахалт илрээгүй үзэл бодлоо жагсаал, цуглааны замаар маш үр дүнтэй бөгөөд сөрөг үр дагаваргүй илэрхийлсэн жагсаалын нэг болсон байна.

³⁸ ФОТО: “Эвлэлдэн нэгдэх- Хөдөлмөрлөх эрхээ эдэлье” жагсаал боллоо (eagle.mn)

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Жагсаал, цуглааны дараа буюу тухайн жилдээ шаардлага биелсэн шаардлага байхгүй.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Зөвшилцөл он дамжиж, жил бүр гурван талт хамтын хэлэлцээрийг шинэчлэн баталсаар байна
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Үгүй
4	Төр засаг, эрх баригчдын хандлага, шийдвэр	Гурван талт хэлэлцээрийн хүрээнд шаардлагыг шат дамжлагатай биелүүлнэ гэсэн мэдэгдэл гаргасан
5	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Үгүй
6	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Үгүй

Тодорхой үр дүнд хүрээгүй ч эрх баригчдад ажил эрхлэгчдийн цалин хөлсөө нэмүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарах ёстойг олон нийтэд мэдээлж чадсан. Тухайн үеийн нөхцөл байдлыг илэрхийлэхэд эвлэлдэн нэгдэх зарчмаар ойлгуулахыг эрмэлзсэн байна. Жагсаал зохион байгуулагчдын эрхэд тулгарсан, зөрчигдсэн зүйл байхгүй.

Жил бүрийн гурван талт хэлэлцээрийн талаарх жагсаал богино хугацаанд үр дүнд хүрч, шийдвэрлэгддэггүй аргацаах хандлагатай явж ирсэн нь иргэд, хөдөлмөр эрхлэгчдийн дунд уг хэлэлцээр, түүний мөрөөр хийгдэх ажилд итгэх итгэлийг багасгажээ. Мөн Монгол Улсад хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх зорилгоор хамтын хэлэлцээ хийдэг ч эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан хамтын хэлэлцээг зогсоох зэрэг сорилтуудтай тулгардаг байна. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны мэдээлснээр ажилчид үйлдвэрчний эвлэл байгуулах болон элсэн ороход бэрхшээлтэй асуудлуудтай тулгардаг ба зарим ажил олгогчид үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг

сулруулахын тулд ажилчдаа ажлын цагаар (хууль ёсны эрхийг үл харгалзан) уг үйл ажиллагаанд оролцохыг хориглох, оролцсоны төлөө ажлаас халах, үйлдвэрчний эвлэлд алба хашдагаас болж нууц далд хэлбэрээр цалин хасах эсвэл Хамтын хэлэлцээ байгуулахаас татгалцах зэрэг үйлдэл гардаг аж.

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

ҮЭ-ийн холбооноос жил тутмын 5 дугаар сарын 1-ны өдрийн олон улсын үйлдвэрчний эвлэлүүдийн хөдөлмөр эрхлэх хүрээнд тулгамдсан асуудлыг ЗГ болон ажил олгогчдод хүргэж, эв санааны нэгдлээ илэрхийлдэг байна. Энэ байнгын үйл ажиллагааг тохиолдуулан зохион байгуулж буй суулт, жагсаал цуглааныг нь сүүлийн жилүүдэд жагсаал хийх мэдэгдэл хүргэсэн ч тухайн хүсэлт гаргасан өдөр нь өөр үйл ажиллагаа төлөвлөгдсөн гэсэн нэг л хариулыг өгдөг болсон байна. ҮЭ-нь хэт зохион байгуулалтад орж, улс төрийн шинжтэй жагсаал цуглаан хийх эрсдэлтэй гэж эрх баригчдад харагдсан байх

магадлалтай. Энэ нь эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран чуулах зарчмын хүрээнд зохион байгуулалт өндөртэй бүтэц болох ҮЭ-ийн үйл ажиллагааны хувьд анхаарах асуудал болж байна.

Жагсагч иргэд эрхээ бүрэн, үр дүнтэй эдлэхэд зөвлөмж болгох зүйлс, шийдэл, санал болгох зүйлийн жагсаалт:

- Асуудлуудаа ерөнхий бус гурван талт хэлэлцээрийн цалин хөлс нэмэгдүүлэх талаарх шаардлагаа тодорхой тооцоололтой тавих;
- Зөвхөн инфляци болон валютын ханш гэсэн тогтсон нэр томъёоноос татгалзах;
- Жагсаал, цуглаан оролцогч олон талын бүлгүүдийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байх;
- ҮЭ-ийн зүгээс салбар, салбараар тусгаарлаж жагсаал хийх шаардлагатай

- буюу хэт ерөнхий олон салбарын асуудлыг нэг дор цуглуулахгүй байх;
- Олон улсын болон дотоодын өөрсдийн хэрэгцээнд ашиглах гарын авлага, зарчим, дүрмийн мэдээллийг оролцогч талууддаа мэдээлэх;
 - Жагсаал цуглаан болсны дараах авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон тухайн жагсаал үр дүнд хүрсэн эсэх асуудлаа олон нийтэд тогтмол мэдээлэх;
 - Оролцогч талуудаас жагсаал цуглааны үеэр үйл явдалтай холбоотой мэдээ, мэдээллийг өгөх эрх бүхий хүнээ томилж, оролцогчидтойгоо тохиролцох;
 - Тухайн жагсаалд оролцогч талуудын төлөөлөл ҮЭ-ийн холбоонуудтай хамтран ЗГ зэрэгт тавих шаардлага, ойлголтоо нэгтгэж бэлтгэсэн байх;
 - Оролцогчид нэгтгэсэн шаардлагаас өөр асуудалд хэлбийж орж байгаа эсэхэд хяналттай байж, болгоомжлох;


НАЙМ. ШОГУКАН ХЭВЛЭЛИЙН КОМПАНИЙН ГАДНАХ ЖАГСААЛ (2018)



Зургийн эх сурвалж:
itoim.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2018 оны 02 сарын 27
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Япон улсын Чойда дүүрэг дэх “Шогакүкан” гэх Хүүхдийн “Корокоро” сэтгүүлийг эрхлэн гаргадаг хэвлэлийн компанийн гадна
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Корокоро сэтгүүлийн 3 дугаар сарын бүх дугаарыг худалдаалж буй ойролцоогоор 680 гаруй дэлгүүрээс эгүүлэн татах - Чингис хааны зургийг доромжилсон хэвлэлийн компанийг уучлалт гуйхыг шаардав - Их Хааны минь сүнсийг тайван байлгаж хоёр орны найрсаг харилцааг битгий сэвтүүл гэж хариуцлага нэхэв - Дан ганц уучлалт гуйгаад зогсохгүй, Монгол бахархал болсон өвүүдээ дархлаа тогтоохыг хүсчээ
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Сэтгүүлийг эрхлэн гаргагч Редакцид хандсан
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Япон улсад суугаа Монгол болон Өвөрмонголчуудын төлөөлөл (Жагсаал зохион байгуулагч Гандөш)
6	Оролцсон хүний тоо	130 гаруй иргэд хамрагдсан Монгол болон Өвөрмонголчууд нэгдэж эсэргүүцлээ илэрхийлсэн нь онцлог
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Үндэсний босоо бичгээр бичсэн шаардах үг хэллэг, Чингис хааны хөрөг зураг бүхий эд хэрэгслүүд, япон ханзаар бичсэн шаардах бичиг бүхий пайз



February 23, 2018

Mr. Toshihide Nishijima
Chairman of the Board of Directors
Shogakukan in Japan

Dear Mr. Nishijima,

On behalf of BROOKLYN INK Inc., we extend our sincerest apologies for the use of inappropriate expressions containing "Genghis Khan" in the comic "Horsehair" (Korokoro) in the March issue of our monthly magazine "Gentle Giant". We recognize that the expressions regarding the founder of the Mongol Empire were disrespectful and offensive to the people of Mongolia and all who love and respect the Great Khan.

We are grateful that this issue was brought to our attention and humbly ask your forgiveness. In the future, we will further our knowledge of the history and culture of your country and make our utmost efforts to prevent the recurrence of such improper expressions.

Thank you for your patience and understanding.

Yours sincerely,

Yasuhiro Sugita
Director/Board Member
Creative Department
BROOKLYN INK Inc.

Makoto Waki
Editor-in-Chief
Creative Group Editorial Department



*itoim.mn болон ub.life сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Чингис хааны духан дээр ёс бус зураг зурж хэвлэлтэд гаргасан
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Монголчууд редакц руу нь хандан бусад улсын түүх соёлд хүндэтгэлтэй хандахыг хүсэж, худалдаанаас татахыг шаардсан ч хэвлэлийн компани зах зээлээс татаж аваагүй.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Тийм
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Тийм
5	Улирал, цаг агаарын байдал	Дулаан, хаврын улирал

Японы манга буюу комиксыг 1950-аад оноос Японд Осүма Тэзүка манга дүр төрхийг анх гаргаж байсан. КороКоро комиксыг 1977 оны 5-р сарын 15-нд Шогакукан хэвлэлийн газраас гаргаж эхэлсэн. Шогакукан хэвлэлийн газар нь Дораемон, Покемон зэрэг дэлхий даяар алдартай мангануудыг гаргадаг. КороКоро комикс 2017 оны 4-р сарын байдлаар 400 сая хувь борлогдсон нь дэлхий даяар хамгийн их борлуулалттай комикс/манга сэтгүүлүүдийн нэг болсон.³⁹ Японы комикс нас, хүйс, нийгмийн давхаргын онцлогт зориулсан төрөл бүрийн сэдэвтэй, маш баялаг сонголттойгоор хийгддэг. Иймд Японы комикс нь амьдрал болон хувь хүний дотоод ертөнцөд илүү ойр агуулгатай, энгийн хэр нь сэтгэл хөдлөлийг сайн харуулсан илэрхийлэлтэй дүрслэлээрээ бусад орны комиксоос ялгардаг. Японы метро болон гудамжинд хаа сайгүй л манга/комикс уншсан хүмүүс байдаг.⁴⁰ Одоо цагт комикс дэлхийн зугаа цэнгэлийн 3 том салбарын нэг нь болсон. Ном хэвлэл, animation – хүүхэлдэйн кино, кино урлаг, видео тоглоом, хүүхдийн тоглоом, ахуйн бараа гээд бүх л энтертайнмент бизнес салбарыг хамарч байна.

Бага дунд сургуулийн хүүхдүүдэд зориулан гаргадаг “Корокоро” комиксын 2018 оны 2-р сарын 25-ны дугаарт “Чингис хааны духан дээр ёс бус зураг” зурж хэвлэлтэд гаргасан нь ар, өвөр Монголчуудын дургүйцлийг ихээхэн хүргэсэн. Чингис хаан бол 1206 онд Монгол аймгуудыг нэгтгэж Их Монгол Улс буюу Монголын Эзэнт Гүрнийг байгуулсан, Монголын болон дэлхийн түүхэн дэх гарамгай цэргийн удирдагчдын нэг юм. Их Монгол Улсыг байгуулсны дараа тэрээр амьдралынхаа явцад Ази, Европын ихэнх нутаг дэвсгэрийг эзэлсэн бөгөөд харин түүний үр хүүхдүүд үүнийг нь үргэлжлүүлж, тухайн үед соёл иргэншилт хүн төрөлхтөнд нээгдээд байсан дэлхийн хуурай газрыг бараг бүхэлд нь эзэлсэн түүхтэй. Комикст “Чингис хаан”-ы “Чин”-г нь авч Чин Чин буюу эр бэлэг эрхтэн гэж бичээд хааны духан дээр нь эрхтэн зурсан байсан. Монголчууд редакц руу нь хандан бусад улсын түүх соёлд хүндэтгэлтэй хандахыг хүсэж, худалдаанаас татахыг шаардаж утас цохисон ч хэвлэлийн компани зах зээлээс татаж аваагүй байна. Ийнхүү бухимдсан монголчууд тус сэтгүүлийг гаргадаг “Шогакукан” хэвлэлийн компанийн гадна 2018 оны 2 сарын 26-ны өдөр цуглаж эсэргүүцлээ илэрхийлсэн.

³⁹ コロコロ×スカイツリーのコラボビジュアル公開、カフェメニューも明らかに。AnimeAnime.jp (in Japanese). May 4,

⁴⁰ [Комикс — Википедиа нэвтэрхий толь \(wikipedia.org\)](https://en.wikipedia.org/wiki/Comics)

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Аяндаа үүссэн, тайван хэлбэрээр явагдсан, зохион байгуулалтгүй
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Үгүй
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Эмзэглэсэн байдалтай
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Үгүй
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Өвөрмонголчуудын дэмжлэг хүчтэй байсан ба бусад хилийн чанадад суух иргэд цахимаар нэгдэж, дэмжиж буйгаа илэрхийлж байв.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Санхүүжилт байгаагүй
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

2018 оны 02-р сарын 25-нд Японы "Корокоро" нэртэй комикс сэтгүүл худалдаанд гарсан. Тус сэтгүүл дээр "Чингис" хааны хөргийг доромжилсон утга агуулгаар зурж хэвлэлтэд гаргасан нь монгол иргэдийн дургүйцлийг хүргэсэн. Тиймээс Монгол иргэд Чингис хааныг доромжилсон тус сэтгүүлийн редакц руу залгаж сэтгүүлээ хэвлэхийг зогсоох, худалдаанаас татахыг шаарджээ.

Монгол Улс, Япон Улс нь 1972 оны 2 дугаар сарын 24-нд хоёр улсын хооронд дипломат харилцаа, 1974 оны 9 дүгээр сарын 23-нд Соёлын харилцаа тогтоох тухай хэлэлцээр, 1998 оноос Иж бүрэн түншлэлийн харилцаа, 2010 оноос Стратегийн түншлэлийн харилцаатай болсон.⁴¹ Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яамнаас "Хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэхээр ажиллаж буй энэ үед Монгол Улсын түүх, соёлыг үл

хүндэтгэсэн ёс суртахуунгүй нийтлэгджээ. Тус зураг дан ганц Монголчуудыг доромжлоод зогсохгүй, бага насны хүүхдүүдэд садар самуун сурталчлахыг хориглон Япон улсын хууль тогтоомжийг зөрчиж байна. Иймд Японы Гадаад хэргийн яамд эсэргүүцлээ илэрхийлэхийн сацуу, асуудлыг шийдвэрлэх зохих арга хэмжээг авахыг хүсэж байна" хэмээн мэдэгдэл хүргүүлсэн. Уг асуудалд Шогакукан компаниас уучлалт гуйсан хариу мэдэгдэл хүргүүлсэн ч Монголчууд манга-г борлуулалтаас эргүүлэн татаж, залруулга хийх ёстой гэж үзсэн. Тиймээс хоёрдугаар сарын 26-ны 13.00-15.00 цагт Токио хотын Чиода дүүргийн Хитоцубаши гудамжны Шогакукан барилгын өмнө эсэргүүцлийн цуглааныг зохион байгуулжээ⁴².

Тус сэтгүүлийн гуравдугаар сарын дугаарыг Японы ойролцоогоор 680 номын

⁴¹ [Япон Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан төсөл | Япон ба Монгол Улс: Архивын баримтаар дамжуулан хүргэх бидний түүх \(archives.go.jp\)](#)

⁴² [Чингис хааныг доромжилсныг эсэргүүцэж Токио дахь монголчууд цуглана \(newspress.mn\)](#)

дэлгүүр, томоохон сүлжээ дэлгүүр худалдаанаас татсан байна. "Тус компани өөрсдийн ашиг орлогын төлөө монгол үндэстнийг гутааж болохгүй" гээд зөвхөн

уучлалт гуйгаад зогсохгүй сэтгүүлээ татан авахыг шийдвэр гаргаснаар энэхүү жагсаал үр дүндээ хүрсэн.⁴³

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Жагсаал цуглаан үндсэн зорилгодоо хүрсэн.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Мэдэгдэл хүргэсэн даруй Японы талаас уучлалт гуйсан бөгөөд "Корокоро" сэтгүүлийн эрхлэн гаргагч Япон улсад суугаа Элчин сайд Д. Батжаргалд бараалхаж уучлалт гуйсан байна
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Үгүй
4	Төр засаг, эрх баригчдын хандлага, шийдвэр	Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яам албан ёсны эсэргүүцэл илэрхийлж, Япон улсын Гадаад хэргийн яаманд мэдэгдэл хүргүүлсэн
5	Жагсагч нарын тавьсан шаардлага үр дүнд хүрсэн эсэх, биелүүлээгүй шаардлага юу болох	Дээрх шаардлагууд бүгд биелсэн бөгөөд дараа дараагийн удаа ийм төрлийн сэдэвт анхааралтай хандаж, Монгол бахархал болсон өвүүддээ дархлаа тогтоох асуудал цаг хугацаагаар хэмжих боломжгүй тул ажиглалтын байдалтай
6	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Үгүй
7	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Үгүй

Япон улсад ажиллаж амьдрах монгол улсын иргэд энэ асуудалд соргоогоор хандаж, өөрсдийн эмзэг сэтгэл хөдлөлийг зөвөөр илэрхийлж, яаралтай эхний ээлжид хэвлэгдсэн сэтгүүлийг бүх дэлгүүрээс татаж, хурааж авахыг шаардсан нь үр дүнд хүрсэн. Уг жагсаалд монголчууд болоод Монгол улсаас Япон улсад суугаа бүрэн эрхт элчин сайдын газар хамтарч ажилласан нь сайн туршлага байв. Харин анхаарах зүйл нь Их эзэн Чингис хаан болоод тусгаар улсын түүх, өв соёлын талаар маш эмзэг тусах үйл явцад Өвөр Монголчууд илүү идэвх санаачилгатай байсан бөгөөд тухайн жагсаалд ар

монголчуудын оролцоо 10 доторх хүн байсан нь анхаарах зүйл байжээ. Нөгөөтээгүүр, Монгол дахь хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг жагсаалтай холбоотой видео, лайв, нийтлэл тун хангалтгүй байгаагаас харахад Засгийн газар хоорондын тохиролцоотой холбоотойгоор мэдээллийг цахим орчинд түгээхээс болгоомжилсон байж болзошгүй.

Гадаад орны түүх соёлыг доромжилсон, шоглосон асуудлыг улс бүрд янз бүрээр шийдвэрлэдэг. Хамгийн түгээмэл нь мөнгөн торгууль бөгөөд зарим улсад 1-5 хүртэлх жилийн хорих ял оноодог байна.

⁴³ Жагсагчдын голлох шаардлагаас

Энгийн жишээ гэвэл Грек улсын эрүүгийн хуулийн 155 ,188 дугаар заалтад, “Грек улсын төрийн далбаа, дуулал, түүхэн өвийг сүйтгэх, ёс бусаар ашиглавал 2 хүртэл жилийн хорих ял онооно. Мөн Грек улсын иргэн ямарваа гаднын улсын өвд тус байдлаар хандсан тохиолдолд мөнгөн торгууль төлөх ба 6 сар хүртэлх хорих ялаар шийтгэнэ” хэмээн тодорхой заасан байдаг. Харин Испани улсын эрүүгийн

хуульд Хааны гэр бүлийнхний хэн нэгний тухай сөрөг мэдээлэл тараасан тохиолдолд хэргийн шинжээс шалтгаалж, 3-6 жилийн хорих ял шийтгэдэг аж. Хэдийгээр сэтгүүлийг худалдаанаас эргүүлэн татуулсан ч бусад улс орнуудын жишгээс арай сул хариуцлагыг ногдуулсан байна. Олон улсын төвшинд бид Чингис хаанаа доромжлуулсан хэмээн НҮБ-ын Соёлын зөвлөлд ч хандах боломжтой байсан.

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
1	Жагсаал, цуглааны өмнөх, бэлтгэл шатад хамаарах	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох хуулийн зохицуулалтын мэдлэгтэй болох: <ul style="list-style-type: none"> • Хаана, хэрхэн, ямар байдлаар бүртгүүлэх • Жагсаал, цуглаан зохион байгуулагчийн эрх үүрэг • Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед ямар арга хэмжээ авах гэх мэт 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид
2		Жагсаал, цуглаан зохион байгуулах талаар төлөвлөгөө, дүрэмтэй байх: <ul style="list-style-type: none"> • Байршил, үргэлжлэх хугацаа гэх мэтийг тусгасан зохион байгуулалтын төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны зорилго, хүргүүлэх шаардлага, хүлээгдэж буй үр дүн зэргийг тодорхойлсон агуулгын төлөвлөгөө гаргах • Эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах тухай эрсдэлийн төлөвлөгөө гаргах • Жагсаал, цуглааны үеэр зөвшөөрөгдөх болон хориглох зүйлсийн талаар жагсаалд оролцогчдод урьдчилан сануулах, мэдээлэл түгээх 	Жагсаал зохион байгуулагчид
3		<ul style="list-style-type: none"> • Харилцан ойлголцох, мэдээлэл солилцох урсгалаа сайжруулах: Жагсаал цуглаан хийхээсээ өмнө хэвлэлийн газарт комиксоо татахыг шаардаж хэлсэн ч албан бичгээр мэдэгдлээ хүргүүлэх, тус улсад суугаа Элчин сайдын яамтай хамтрах арга хэмжээг авах 	Жагсаал зохион байгуулагчид
4		<ul style="list-style-type: none"> • Олон нийтэд мэдээлэл хүргүүлэх, идэвхжүүлэх арга хэмжээ хангалттай авах: Жагсаал цуглаанд өвөр Монголчууд ихээр цугларсан бол, ар Монголчууд маш цөөхөн байсан. 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид

№	Хамаарах үе шат	Зөвлөмжүүд	Хамааралтай талууд
5		<ul style="list-style-type: none"> Энэ төрлийн эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллаж асуудлыг гүнзгий түвшинд тайлбарлах; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид, Элчин сайдын яамд
6		<ul style="list-style-type: none"> Улсын тусгаар тогтнол, өв соёлын эсрэг үйлдсэн энэ мэт гэмт хэрэгт улс орнууд хариуцлага тооцдог журмын дагуу ЗГ-аас хариуцлага тавьдаг байх 	Төр хүчний байгууллагынхан, Элчин сайдын яамд
7		<ul style="list-style-type: none"> Шаардлагын хариу болон ямар нэгэн шийдвэрийн талаар боломжит нарийн хугацааг албан шаардлагадаа тусгах; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид
8	Жагсаал, цуглаан зохион байгуулагдаж буй үед хамаарах	<ul style="list-style-type: none"> Засгийн газар хоорондын хамтын шийдвэр ямар байдлаар гарсан зэрэг улсын түүх соёлын эмзэг сэдвийн тухай ойлголтыг дэлгэрүүлэх урт хугацааны контентоор дамжуулах, шийдэл санал болгох; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид
9		<ul style="list-style-type: none"> Гадаад улсад байгаа иргэдийн мэдээлэл солилцох арга зам хомс байх тохиолдолд нийгмийн асуудалд тухайн улсынхаа элчин сайдын яаманд яаралтай хандаж, мэдээлэл авч харилцаж хэвших; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид
10	Жагсаалын дараах үед хамаарах	<ul style="list-style-type: none"> Үйл явцын талаарх мэдээллийг жагсагчид хувийн цахим хуудастаа болон архивлан авч үлдэх; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид
11		<ul style="list-style-type: none"> Шаардлагын үр дүнд ямар шийдвэр гарсан талаарх өмнөх ба дараах сайн, муу үр дагаврын талаарх мэдээллийг түгээх; 	Жагсаал зохион байгуулагч, оролцогчид



ЕС. ОРОН НУТАГТ БОЛСОН ЖАГСААЛ (2022)

Зургийн эх сурвалж:
zindaa.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2020 оны 01 дүгээр сарын 14
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Дорнод аймгийн Матад, Халх гол сум, Улаанбаатар хот
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн хариуцлагын гэрээ хийх шүүхийн шийдвэрийг биелүүлэх - Усны төлбөр - Монгол ажилчдыг авч ажиллуулах - Бараа, ажил үйлчилгээний тендерт монголчуудыг хамруулах
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Монгол Улсын ЗГ болон Ашигт малтмал газрын тосны газар, түүний удирдлагууд, Петро Чайна Тачин тамсаг ХХК
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	Дорнод аймгийн Матад, Халх гол сумын иргэд, тэдний хүсэлтээр "Машинтай жагсагчид" хөдөлгөөнийхөн
6	Оролцсон хүний тоо	Жагсаал, цуглаанд оролцогчдын тоо тодорхойгүй. Жагсаал хэдий орон нутагт өрнөсөн боловч улс хоорондын хэлэлцээр гэрээтэй холбоотой асуудал бөгөөд эргээд үзүүлэх хохирол нь сумын иргэдэд ноцтой нөлөөлөх байснаараа онцлог.
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Монгол улсын туг далбаа бүхий хэрэгсэл, МУ-ын хууль тогтоомжийг дагаж мөрд гэх мэт хулдаасан хэвлэл дээрх үгс



*<https://www.24tsag.mn/> сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	“Петрочайна Дачин Тамсаг” компани нь орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах талаар шүүхийн шийдвэр гарсан ч тухайн компани шүүхийн шийдвэр биелүүлээгүйтэй холбогдсон жагсаал, цуглаан байна.
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Жагсаал, цуглаан болохтой холбоотой мэдээлэл маш урт хугацаанд мэдээлэл цацагдсан ба олон нийтийг жагсаал, цуглаанд уриалсан, үзэл бодлоо илэрхийлэхийг шаардсан бичлэг, live-ууд сошиал хуудсаар цацагдаж байсан байна.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Үгүй
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Халх гол сумын ЗД Х.Хүрэл-Эрдэнэ, Матад сумын ЗД Ө.Цэвээнсүрэн нарын багийн мэдээлэл, судалгаа, ажлын хэсгийн шалгалтын дүгнэлт зэргийн баримтуудтай
5	Улирал, цаг агаарын байдал	Өвлийн улирал

Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны тухай хуульд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нийгмийн хариуцлагын гэрээг орон нутагтай байгуулах ёстой бөгөөд “Петрочайна Дачин Тамсаг” компани нь уг гэрээг байгуулахгүй явсаар иржээ. Тиймээс Дорнод аймгийн иргэд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулахыг шаардаж, 2019 оны 1 сарын 3-нд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах шүүхийн шийдвэр гарсан байна. Гэвч жил гаруй хугацаа өнгөрөхөд гэрээ байгуулаагүй учраас Дорнод аймгийн иргэд болон “Машинтай жагсагчид” хөдөлгөөнийхөн хамтран жагсаал зохион байгуулжээ.

Ийнхүү орон нутгийн иргэд болон ТББ-ын шаардлагаар Дорнод аймгийн Засаг Дарга М.Бадамсүрэн нь захирамж гарган, тус аймгийн Байгаль орчны газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулж, Мэргэжлийн хяналт, цагдаа нарын ажлын хэсгийн хүрээнд тухайн Петрочайна ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй 19,20,22 дугаар талбай дээр хяналт шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Шалгалтын хүрээнд дараах зөрчлүүд гарсан. Үүнд:

1. 2020 оны байгаль орчны үнэлгээ хангалтгүй,
2. 2021 онд ус ашиглах гэрээ байгуулаагүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулаагүй учраас тухайн жилдээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлууд хийгдээгүй,
3. Хоёр жил тутамд хийгдэх ёстой байгаль орчны аудитыг хийлгээгүйн улмаас гүний ус бохирдох эрсдэл үүссэн,
4. Хур хог хаягдал бий болж байгаль орчны эсрэг гэмт хэрэг үйлдэж, МУ-ын хууль тогтоомжуудыг мөрдөөгүй,
5. Түүнчлэн 2018 онд багтаан ашиглалтад оруулах байсан 21 дүгээр талбайгаас Баян хошуу боомт хүртэлх 58,5 км хатуу хучилттай авто замыг дуусгаагүй. Олон салаа замын нөхөн сэргээлт хийгээгүй,
6. Сүүлийн хоёр жилийн хугацаанд хог хаягдлын менежментийн асуудлыг шийдвэрлэх талаар ажил хийгээгүй зэрэг асуудлууд хяналт, шалгалтын явцад илэрч орон нутгийн иргэд болон бусад олон нийтийг жагсах, цуглаан зохион байгуулах үндэслэл болжээ.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Зохион байгуулалттай, тайван замаар өрнөсөн.
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Үгүй
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Олон жил амьдрах орчны бохирдол ихтэй, бүтээн байгуулалт хийгддэггүй, цэнгэг усаа оочирлож авдаг, орон нутгийн иргэд дундаа нэг худагтай гэх мэт шалтгаанаар иргэдийн бухимдал их байсан
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Машинтай жагсагчид ямар нэгэн шалтгаанаар цаашид жагсаал, цуглаанд оролцохгүй болсноо илэрхийлэхэд дарамт, шахалтад өртсөн гэх нийгмийн хардлага байсан. Ямар нэгэн баримт нотолгоо байхгүй
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Олон нийтийн дэмжлэг өндөр хэмжээнд байсан. Дорнод аймгийн нийт гурван сумын иргэд болон аймгийн удирдлагууд, хуульч өмгөөлөгчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд гээд өргөн бүрэлдэхүүнтэй дэмжлэг үзүүлэх бүлгүүд байв
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	“Машинтай жагсагчид” хөдөлгөөний хувьд иргэдийн өгсөн хандив, тусламжийн мөнгөөр жагсаалын үйл ажиллагаанд хэрэгтэй хулдаасан хэвлэл, шатахуун зэрэг шаардлагатай зүйлсэд зарцуулсан гэдэг ба түүнийгээ ил тод мэдээлдэг
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

“Машинтай жагсагчид” хөдөлгөөнийхний хувьд жагсаал цуглаан хийж байсан туршлагатай төдийгүй өмнөх жагсаалууд нь тодорхой үр дүнгүүдийг гаргаж байсан. Эдгээр туршлагатай бүрэлдэхүүнтэй хамтарч хүч нэгтгэн ажиллах сонирхолтой байсан ч тухай үед “машинтай жагсагчид” нь жагсаал хийх бичгээ татаж авч, замын дундаас буцсан нь тухайн орон нутгийн иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэсэн.

Харин орон нутгийн удирдлагуудын оролцооны хувьд иргэдийн санал хүсэлтийн дагуу тэдэнтэй хамтарч ажиллаж, жагсаал цуглааныг хуулийн дагуу бүртгэн, зөвшөөрөл олгож, шаардлагатай судалгааны ажил хийж, олон нийтэд мэдээлэл өгснөөрөө уг жагсаал, цуглааныг

үр дүнтэй болоход тодорхой үр нөлөө үзүүлсэн сайн туршлага байсан.

Тодорхой хэмжээний акц өрнүүлэх чадамжтай эв санааны нэгдэл болж ажилладаг хэсэг бүлэгт хандсан нь зөв шийдэл байсан. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, нээлттэй мэдээллээ хуваалцаж ажилласан нь том давуу тал. Гэсэн хэдий ч энэ хамтын ажиллагааг нь дүгнэхэд төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал энэхүү жагсаалын эцсийн үр дүнгээ үзэлгүй машинтай жагсагчид хөдөлгөөнийхөн жагсаалаа зогсоох шийдвэрт хүрсэн нь улс төрийн оролцоо байсан уу гэсэн асуултад хүрч байна.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж, өмнөх хийгдэж байсан аймгийн удирдлагуудтай тохиролцсон санамж бичгийн хүрээнд байгалийн нөхөн сэргээх, монгол ажилчдыг авч ажиллуулах, бараа машин худалдан авалт, үйлчилгээнд орон нутгийн иргэдийн авч ажиллуулах, усны төлбөр торгуулаа төлөх зэрэг шаардлагуудаас нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахаар талууд ширээнд суусан. Петрочайна ХХК-д 1 тэрбум төгрөгийн торгууль оногдуулсан. 21 дүгээр талбайн стандартын хүнд даацын авто зам тавигдаагүй.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ, эрх баригчдын хандлага, шийдвэр	<ul style="list-style-type: none"> • Дорнод аймгийн удирдлага, ИТХ болон нийт Дорнодчууд “Петрочайна дачин тамсаг” компанийн үйл ажиллагаа зогсоох, Мэнэнгийн талаа улсын тусгай хамгаалалтад авах тухай санаачилга гаргаад байгаа аж. Гэсэн ч “Петрочайна дачин тамсаг” компани нь уул уурхай, газрын тосны салбарын их хэмжээний татвар төлөгч байгууллагуудын нэг учраас Монгол Улсын төсөв тасарна гэх шалтгаанаар дээд шатны байгууллагууд саналыг хүлээн авдаггүй байна • 2018 оны дөрөвдүгээр сард л гэхэд “Петрочайна дачин тамсаг” компанийг гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр үйл ажиллагааг нь 19 хоног зогсоосон боловч улсын төсөв тасарна гэх шалтгаанаар Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг удирдах байгууллагуудаас шүүмжлэл ирүүлсэн тохиолдол бий. Иймд томоохон компаниудтай холбоотой шийдвэрүүд аймгийн удирдлагын хэмжээнээс хэтэрсэн гэдгийг иргэд, албан тушаалтнууд дуу нэгтэйгээр хэлдэг
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Үгүй
4	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Үгүй
5	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Үгүй

2020 оны 01 сарын 14-өөс эхлэн Газрын тосны тухай хуулийн 11.2.17-д заасны дагуу Петрочайна дачин тамсаг ХХК – Матад, Халхгол сумтай газрын тосны үр өгөөжийг орон нутагт нь үлдээх нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах асуудлаар 3 талт уулзалт, хэлэлцээр хийсэн нь хамгийн том үр дүн. Мөн 2018, 2019 оны гэрээнүүдийг нөхөж байгуулах асуудлаар сумдын удирдлага, иргэд, нутгийн хуульч өмгөөлөгч, Ашигт малтмал, Газрын Тосны Газрынхан, олборлогч компанийнхантай уулзалт хэлэлцээр хийжээ.

2018, 2019 оны гэрээний төлбөрт сум тус бүрд 500 сая төгрөг, нийт 1 тэрбум төгрөг, 2020 оноос эхлэн сум тус бүрд жил болгон

450 мянган ам.доллар буюу өнөөдрийн ханшаар 1 тэрбум 235 сая төгрөг олгож байх ерөнхий тохиролцоонд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл энэ онд Матад, Халхгол сум тус бүр 1 тэрбум 735 сая орчим төгрөг, хөрөнгө оруулалтыг нийгмийн хариуцлагын гэрээгээр авах юм. Мөн гэрээнд орон нутгийн аж ахуйн нэгж, бизнесийг дэмжиж ажиллах, сумдын иргэдийг ажлын байраар хангах талаар тодорхой зохицуулалт тусгаж оруулахаар ярилцсан. Гэрээний заалт, зарим нөхцөл шаардлагыг тодорхой болгох ажлын хэсгүүд саналаа нэгтгэснээр Петрочайна дачин тамсгийн ерөнхийлөгчийг 1-р сарын 20-нд орон нутагт ирүүлж гэрээг эцэслэж, гарын үсэг зурахаар тохиролцсон байна.

Дорнод аймгийн иргэн Б.Ган-Чөдөрийн ярилцлагаас...

Өнөөдөр хуран цуглаад энэ асуудлыг ярьж байгаад баяртай байна. 19, 21 дүгээр талбайд хууль бус асуудал маш их байдаг. Тэнд бэлгийн дарамтад орсон, хоёр гурван иргэн хуруугаа тастууллаа гэх мэтээр ярьж байна. Асуудлыг ярихаар цагдаа нар нь баримт нэхдэг. Өнөөдөр гадаадын иргэн гэхээрээ л хуулийг гууль болгож байна. Засгийн газрын гэрээ нь их нууцлагдмал гэрээ байдаг. Ер нь энд энд компани ажиллалаа гээд Халх гол хөгжөөгүй, цаашидаа хөгжихгүй гэдгийг бид ойлголоо. Өнөөдөр Мэнэнгийн талд цагаан зээр үгүй боллоо. Иргэд үүнийг мэдэж байгаа ч Матадын иргэд хаана, хэнд хандахаа мэдэхээ больчихсон нөхцөл байдалтай байна...

Дорнод аймгийн иргэн "Халх гол Дорнын сав газраа хамгаалах" ТББ-ын тэргүүн Б.Ганцогтын ярилцлагаас...

Дэлхийд хосгүй тал нутаг сүйдсэн, олон сая зээр бэлчдэг байсан газар зээр үгүй болсон. Дорнодын талаар газрын тосны машинууд зайгүй давхилдаж ирсэн учраас 2009 оноос байгаль орчны талаар асуудлыг хөндөж эхэлсэн юм. Хууль биелүүлэх Газрын тосны газар, Ашигт малтмалын газруудад санал өгсөн боловч өнөөдрийг хүртэл хууль зөрчигдсөн хэвээр байгаа. 2018 онд "Петрочайна Дачин Тамсаг" компанийг шүүхэд өгсөн. Шүүхээс газрын тосны хуулиараа сумын удирдлагатай гэрээгээ хийх ёстой гэсэн шийдвэр гаргасан. Гэсэн хэдий ч биелүүлэхгүй байгаа...

Дорнод аймгийн Матад сумын засаг дарга Э.Төмөрбаатар...

Газрын тосны тухай хуулийн 11,2,17 зүйлд гэрээ байгуулж, орон нутгийн байгаль орчныг хамгаалах ёстой. Хамгийн наад захын энэ заалтыг ч" Петрочайна Дачин Тамсаг" хангадаггүй. Заавал энэ газрыг ажиллуулах ёстой юм уу. Болдог бол олборлолт явуулмааргүй байна. Одоо бид Мэнэнгийн талаа улсын тусгай хамгаалалтад авах ажлыг эхлүүлэх ёстой юм байна. Мэнэнгийн талыг улсын тусгай хамгаалалтад авч өгөхийг хүсэж байна...

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

ЗГ-аас гаргаж буй шийдвэрүүд нь иргэдийг тайвшруулах, хугацаа хожиход чиглэсэн богино хугацааны гал унтраах төдий шийдвэр байгаа эсэхийг цаашид анхаарах. Энэхүү жагсаал, цуглааны үр дүнд бий болсон уулзалт, хамтын ойлголцлын санамж бичиг, нийгмийн хариуцлагын гэрээ хийх талаарх шаардлагыг биелүүлэх мэт боловч дахин өөр төрлийн үр дүнгүй гэрээ хийх эсэхэд анхаарах. Мөн жагсагч иргэд эрхээ бүрэн эдлэхтэй холбоотой дараах санал зөвлөмжүүд байна. Үүнд:

- Орон нутгийн удирдлагууд иргэдийн санал хүсэлтийн дагуу тэдэнтэй хамтарч ажилладаг байх, хууль эрх зүйн орчны талаарх мэдээлэлтэй байж, иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээлэл өгөх, зөв чиглэлд хөтлөх
- Байгаль орчны үнэлгээ түүний аргачлалтай холбоотой судалгаа мэдээллээ олон нийтэд нийтлэх
- Тогтолцооны шинжтэй өөрчлөлтийг хийх санал зорилготой эхэлсэн жагсаал цуглаан тул энэхүү зорилгын төлөө урт хугацаанд тууштай ажиллах



АРАВ.

АРАВ. ГАЛ ҮНДЭСТЭН ХОЛБООНЫ ЖАГСААЛ (2012-2013)

Зургийн эх сурвалж:
zindaа.mn

1. Жагсаалын талаарх ерөнхий мэдээлэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал зохион байгуулагдсан хугацаа	2013 оны 9 дүгээр сарын 13
2	Жагсаал зохион байгуулагдсан байршил	Улаанбаатар хот, Чингисийн талбай, Засгийн газрын ордон
3	Жагсаалын зорилго/хүргүүлсэн шаардлага	<ul style="list-style-type: none"> “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журам”-ыг хэрэгжилтийг хангуулах, уг хуульд өөрчлөлт оруулахыг хориглох Энэ хуулийн дагуу гол мөрний эх, ай сав, ойн нөөц бүхий газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт хийж буй компаниудын үйл ажиллагааг зогсоох
4	Ямар байгууллага, этгээдэд чиглэсэн болох	Монгол Улсын засгийн газар, холбогдох уул уурхайн байгууллагууд
5	Тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчдын мэдээлэл	“Гал үндэстэн” холбоо, Онги гол хөдөлгөөний тэргүүн
6	Оролцсон хүний тоо	“Гал үндэстэн” холбооноос санаачилж, нэр бүхий 11 төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон ⁴⁴ .
7	Жагсаал, цуглааны гол уриа, бэлэг тэмдэг	Тодорхой бэлэг тэмдэг байхгүй, холбооны туг, далбаа ашигласан. Монгол орны газрын зураг, түүн дээр тэмдэглэгээ хийсэн хэвлэмэл материалуудыг төрийн ордны хашаанд өлгөсөн байв. Гал үндэстэн холбоо нь эсэргүүцэл илэрхийлэхдээ нум сум, буу, зэвсгийн төрлийн зүйлс ашигласан байдаг.



*<https://www.mnb.mn> сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

⁴⁴ <https://www.mnb.mn> сайтад нийтлэгдсэн зургуудыг ашигласан болно.

2. Жагсаал, цуглааны суурь нөхцөл, бэлтгэл

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зохион байгуулагдах суурь нөхцөл, шалтгаан	Урт нэртэй гэгдэх “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн журамд зарим өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэн уг жагсаал, цуглааны үндсэн шалтгаан байв.
2	Жагсаал, цуглааны талаарх мэдээллийг урьдчилан олон нийтэд түгээж, мэдэгдсэн эсэх	Үгүй. Уг асуудлаар өмнө нь эсэргүүцлээ илэрхийлж байсан иргэний хөдөлгөөнийхөн өөрсдөө жагсаал, цуглаан зохион байгуулж эхэлсэн.
3	Холбогдох байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсан эсэх	Үгүй
4	Жагсаал, цуглааны зохион байгуулалт, бэлтгэлтэй байдал	Тийм. Жагсаал, цуглаан зохион байгуулагчид болон оролцогчид зэвсгийн чанартай зүйлсийг биедээ авч явсан, самбар, мэдээллийн чанартай хэвлэмэл материалуудыг урьдчилан бэлтгэсэн байсан нь уг жагсаал, цуглааныг урьдчилан бэлтгэл хангаж, зохион байгуулсан гэх үндэслэлтэй байна
5	Улирал, цаг агаарын байдал	Намрын улирал, дулаан цаг агаартай

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” буюу урт нэртэй хууль 2009 онд батлагдсан.

Гол мөрний урсац, эх булаг, ойн нөөцийг алт болон бусад ашигт малтмал олборлогчдын гараар сүйтгүүлэхээс хамгаалж чадсанаараа энэ хууль онцгой ач холбогдолтой. Энэ хуулийн дагуу гол мөрний эх, ай сав, ойн нөөц бүхий газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт хийж буй компаниудын үйл ажиллагааг зогсоох үүрэг Засгийн газарт оногдсон. Гэвч Засгийн газар уул уурхайн компаниудад найр тавин тэдний ажлыг хууль батлагдсанаас хойш бүтэн 2 жил гаруй хугацаанд зогсоож чадаагүй байлаа. Өөрөөр хэлбэл хуулийг үл тоосон, хуулиа хэрэгжүүлэх санаачилга гаргаагүй шалтгаанаас үүдэн Засгийн газартай иргэний байгууллагууд сөргөлдөхөд хүргэж байв. “Гал үндэстэн” холбооныхон

2012 оны хавраас хойш тэмцлийн хэд хэдэн хэлбэр сонгосны нэг нь Сүхбаатарын талбайд эсэргүүцлийн суулт, жагсаал цуглаан зохион байгуулахаас гадна Түнхэл зэрэг газарт хууль бусаар алт олборлож байсан гадаад, дотоодын компанийн техник хэрэгсэл рүү буудах хүртэл арга хэрэглэж байв. Мөн төрийн ордны цонх руу таван удаа нум сумаар харваж байлаа. Мөн Засгийн газрыг шүүхэд өгч, гурван шатны шүүхээр дамжин хэлэлцэгдсээр саяхан Дээд шүүх шийдвэрээ гаргалаа. Энэ шийдвэр нь тэмцэгчдийн талд буюу “Гал үндэстэн” холбооны тавьсан хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн нөхцөлтэй байв. Өөрөөр хэлбэл Засгийн газрыг “Урт” нэртэй хуулиа хэрэгжүүлж ажиллаач гэсэн шаардлага тавьсан байна⁴⁵.

Эцэст нь 2013.09.16 өдрийн УИХ-ын чуулганы нээлтээр урт нэртэй хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөснийг эсэргүүцэн тухайн өдөр “Гал үндэстэн холбоо” болон бусад иргэний

⁴⁵ “Гал үндэстэн”-үүд анхны томоохон ялагчаар тодорлоо (zindaa.mn)

хөдөлгөөнийхөн жагсаал, цуглаан зохион байгуулсан байна⁴⁶.

Уг жагсаал цуглааныг урьдчилан бэлтгэлтэй байсан гэж үзэж болох ч олон нийтэд мэдээлэл хүргэхийг зорилго

болгоогүй, оролцогч багатайгаар зохион байгуулагчдын хүрээнд тэмцлийн хурц хэлбэр ашиглахыг зорьсон гэж судлаач, нийтлэлчид үзэж байна⁴⁷.

3. Жагсаал, цуглааны үйл явц, зохион байгуулалт

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Тэмцлийн арга зам, зохион байгуулалт	Тэмцлийн хамгийн хурцадмал хэлбэр, зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис ашигласан, нийтийн эмх замбараагүй байдал үүсгэсэн
2	Хурцадмал байдал үүссэн эсэх	Тийм. Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт онц байдал зарлагдсан.
3	Зохион байгуулагч болон олон нийтийн сэтгэл зүйн байдал, чиг хандлага	Сэтгэл хөөрөл маш өндөр, ЗГ-ын ордонд буу, зэвсэг, тэсрэх бөмбөгтэй нэвтрэхийг завдсан, буугаар буудсан үйл явдал гарсан.
4	Жагсагч иргэд хүчирхийлэл, дарамт, заналхийлэлд өртсөн эсэх	Хууль сахиулагчид болон жагсагчдын хооронд ноцтой зөрчилдөөн үүссэн. Онц байдал зарлаж, цагдаагийн байгууллага тухайн жагсаал, цуглаанд гол оролцоотой байсан иргэдийг баривчилсан.
5	Олон нийтийн хандлага, дэмжлэг	Зэвсгийн чанартай зүйлс ашигласан, төрийн ордонд буу дугаргасан, тэсэрч, дэлбэрэх бодис ашигласан тул олон нийтийн зүгээс төдийлөн дэмжээгүй. Эсэргүүцлийн агуулга, шаардлагыг зөв гэж үзсэн ч илэрхийлсэн арга хэлбэр нь ноцтой байсан тул олон нийт хуваагдмал байр суурьтай хандаж байв.
6	Санхүүжилт, зардлаа шийдвэрлэсэн байдал	Тухайн жагсаал, цуглаан нь тодорхой холбоод, иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс зохион байгуулсан, иргэд олон нийт оролцоо бага байсан. Зохион байгуулсан холбоо, байгууллагуудын зүгээс санхүүжилттэй.
7	Тухайн үед давхацсан эсвэл эсрэг агуулгатай жагсаал, цуглаан байсан эсэх	Үгүй

УИХ-ын ээлжит бус чуулганы нээлтийн үеэр эсэргүүцэл илэрхийлж “Гал үндэстэн” холбооныхон галт зэвсэг авч төрийн ордны хойд цэцэрлэгт орсон байна. Эсэргүүцэл илэрхийлэгчид 09:30 цагийн үед төрийн ордны хаалганы орчимд буун дуу гаргасан байна. Жагсаал зохион байгуулагч нарын мэдүүлэгтээ “Ард иргэдийн бухимдал зэвсэгт тэмцэл дээрээ тулсан гэдгийг харуулахын тулд буу үүрч, бөмбөг барьж төрийн ордны гадаа жагсаал зохион байгуулахыг зорьсон.

Төрийн ордны хамгаалагч нар тэднийг барьж, саатуулах явцад санамсаргүй сум алдсан” гэжээ⁴⁸.

Төрийн тусгай хамгаалалтын бүсэд галт зэвсэгтэй нэвтэрсэн Ц.Мөнхбаяр, Н.Болдбаатар нарын 3 хүнийг ТЕГ, цагдаагийн байгууллагын ажилтнууд баривчлан саатуулсан бөгөөд тухайн хүмүүсийн биед үзлэг хийх явцад ангийн

⁴⁶ ["Гал үндэстэн"-ийнхэн олныг түгшээв \(unuudur.mn\)](http://unuudur.mn)

⁴⁷ ["Гал үндэстэн"-ийнхэн олныг түгшээв \(unuudur.mn\)](http://unuudur.mn)

⁴⁸ ["Гал үндэстнийхэн санаандгүйгээр буудсан" \(24tsag.mn\)](http://24tsag.mn)

зориулалттай карбин буу 2 ширхэг, олон тооны сум, 9 гар бөмбөг илэрсэн байна⁴⁹.

Өдөр 14:30 цагийн үед дотоод гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн томоохон компаниуд байрладаг “Централ тауэр”-т гар бөмбөг байршуулсан мэдээлэл ирж, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт онцгой байдал зарласан байна. Нийслэлийн онцгой байдлын газрын дэд дарга тухайн үед хийсэн мэдэгдэлдээ “Централ тауэр”-ийн хогийн савнаас гар аргаар хийсэн бололтой тэсрэх бодис

олдсон. Холбогдох албаны ажилтнууд шуурхай ажиллаж, аюулгүй болгосон гэсэн байна⁵⁰.

Уг жагсаал нь төрийн тусгай хамгаалалтын бүсэд галт зэвсэг ашигласан, олон нийтийн газар тэсрэх бөмбөг байршуулж ард иргэдийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, шаардлага тавьсан төрийн албан хаагчдын шаардлага биелүүлээгүй, халдахыг завдсан гэх мэт гэмт хэргийн зөрчилтэй зохион байгуулагдсан нь сөрөг үр дагаврыг дагуулсан.

4. Жагсаал цуглааны үр дүн, үр дагавар

№	Агуулгын хүрээ	Ерөнхий мэдээлэл
1	Жагсаал, цуглаан зорилгодоо хүрсэн эсэх Шаардлагууд биелсэн эсэх	Урт нэртэй хуульд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг эсэргүүцсэн шаардлага нь биелсэн. Гэвч тухайн жагсаал, цуглаан болсноос 2 жилийн дараа буюу 2015 онд уг хуульд өөрчлөлт орсон.
2	Эрх баригч, шийдвэр гаргагч зөвшилцөлд орсон эсэх, авсан арга хэмжээ	Жагсаал, цуглаан зохион байгуулагчид болон засгийн газар хооронд тухайн үед зөвшилцөлд орсон зүйл байхгүй. Онц байдал зарлах нөхцөл үүссэн, гэмт хэргийн зөрчлүүд илэрсэн тул жагсаал зохион байгуулагчид баривчлагдаад дууссан
3	Жагсаал, цуглааныг албадан тараасан эсэх	Тийм.
4	Хүний эрхийн зөрчил үүссэн эсэх	Жагсаал, цуглааныг зохион байгуулагчид болон энэхүү жагсаал, цуглааны үзэл санааг дэмжигчдийн зүгээс хүний эрхийн зөрчил үүссэн гэж үздэг.
5	Цагдаагийн байгууллагад дуудагдсан, шалгагдсан, мэдүүлэг өгсөн, баривчлагдсан, шүүхээс ял үүрсэн тохиолдол гарсан эсэх	Жагсаал, цуглаан зохион байгуулагч 11 хүн баривчлагдаж, тэднээс 5 хүнд ял оноож, 2 хүнийг нь гэм буруугүйд тооцон цагаатгасан байна.

Хэдийгээр тухайн өдрийн жагсаал цуглааны явцад ямар нэгэн хүний амь нас, эрүүл мэндэд үүссэн хохирол байгаагүй ч Нийслэлийн прокурорын газраас Ц.Мөнхбаяр нарт,

- Эрүүгийн хуулийн 177.2 буюу зандалчлах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргахаас татгалзуулахад шууд буюу шууд бус нөлөөлөх зорилгоор олон нийтэд

айдас төрүүлэхэд чиглэсэн нийтэд аюултай хүч хэрэглэсэн буюу хэрэглэхээр заналхийлсэн,

- 149.3 буюу бусдын эд хөрөнгийг бүлэглэн авахаар далайлган сүрдүүлсэн,
- 185.2 буюу галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэсэн, хадгалсан гэх үндэслэлүүдээр яллах дүгнэлт үйлдсэн байна⁵¹.

⁴⁹ "Гал үндэстэн"-ийнхэн олныг түгшээв (unuudur.mn)

⁵⁰ "Гал үндэстэн" холбооны есөн хүнийг баривчлав | News.MN

⁵¹ Ц.Мөнхбаяр нарын шүүх хурал үргэлжилж байна | News.MN

Тухайн хэрэгтэй холбогдуулан баривчлагдсан этгээдүүдийг 4 сар орчим хугацаанд шалгаж, нэр бүхий 4 хүнд 21,6 жилийн ял, нэр бүхий 1 хүнд 2 жилийн ял оноосон байна⁵². Үүнээс дахин 3 сарын дараа хяналтын шатны шүүх хурал хуралдаж “Гал үндэстэн” холбооны тэргүүн Ц.Мөнхбаярт 7 жил, Г.Болдбаатарт 6,1 жил, Д.Төмөрбаатарт 10,6 жил, Ж.Ганболдод 1 жилийн хорих ял, М.Мөнхболдод 1 жилийн хорих ял тус тус оноосон⁵³.

Уг ялын тогтоолд шүүгдэгчид, тэдний ар гэрийнхэн, иргэний нийгмийн байгууллагууд, дэмжигчдийн зүгээс санал нийлэхгүй байгаагаа илэрхийлж, давж заалдах шатны шүүхүүдээр орсон ч анхан шатны шүүхийн шийдвэр хэвээр үлдсэн

5. Сургамж, туршлага анхаарах зүйлс

- Жагсаал, цуглааны зөвшөөрөл олгох гэсэн ойлголтыг хуулийн хүрээнд бүртгэх, бүртгүүлэх гэсэн томъёогоор сольсон боловч бүртгүүлээгүй бол албадан тараах эрх зүйн зохицуулалт хэвээр байгаа нь үнэн хэрэгтээ “зөвшөөрлийн тогтолцоо” үйлчилсээр байгааг харуулж байна. Иймд уг жагсаал, цуглаан нь урьдчилан бүртгүүлээгүй, гэнэтийн байдлаар зохион байгуулагдсан тул жагсаалд оролцогчдыг албадан тараах, аливаа хуулийн хариуцлага хүлээх үндэслэл болох эрсдэлтэй байна.
- Жагсаал цуглаан хийх үзэл бодлоо илэрхийлэхдээ үзэл бодлоо илэрхийлэхэд дэмжлэг болохуйц хэрэглэгдэхүүнүүдээ зөв тодорхойлж, зэвсгийн чанартай хэрэгсэл авч очихгүй байх.
- Нэг удаагийн сэтгэл хөдлөлөөр бус тууштай, тайван замаар үг хэлэх үзэл бодлоо илэрхийлж, хүчирхийллийн бус аргаар хэв журам сахиулагчидтай харилцан ойлголцох, хоёр талын

байна. Тэдэнд үйлдсэн ялын дүгнэлттэй санал нийлэхгүй, хэт хүндэдсэн шийтгэл оноосон гэж үзэж байгаа зарим хуульч, нийтлэлчид ч одоог хүртэл байр сууриа илэрхийлсээр байна.

Криминологийн шинжлэх ухааны онол ёсоор аливаа гэмт хэрэг үндсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. 1-т, хэрэг үйлдэгч буюу гэмт хэрэгтэн, 2-т, гэмт үйлдэл, 3-т, хохирогч. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн аль нэг нь л байхгүй бол үйл явдлыг гэмт хэрэг гэж үзэхгүй байх шүүхийн практик бий. Хэрвээ “Гал үндэстэн” холбооныхон “зандалчлах” гэмт хэрэг хийсэн юм бол хэн зандалчуулсан буюу хохирогч юм бэ?⁵⁴...

шаардлагыг хүлээн авч, зөвөөр хариу үйлдэл үзүүлж байх.

- Жагсаал зохион байгуулагчид тухайн дүүргийн цагдаагийн байгууллагаас танилцуулсан үүрэг, зөвлөмжтэй танилцаж, эв нэгдэл тайван байдлыг эрхэмлэх;
- Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчдын зүгээс жагсаал, цуглааны үеэр ашиглах үг хэллэг, уриа лоозон, бэлгэ тэмдэгтээ маш анхаарал, болгоомжтой хандаж байх. Олон нийтийг хууль бус, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өдөөн хатгахаас маш сэрэмжтэй байх
- Жагсаал, цуглаан хуулийн хүрээний хяналтаас гарсан, албадан тараах нөхцөл байдал үүссэн, онц байдал зарлах шаардлага гарсан үед төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлэх шийдвэрүүдийн талаар иргэд, олон нийт, жагсаалд оролцогчдод түргэн шуурхай мэдээлэл хүргэх, сануулах

⁵² [Ц.Мөнхбаяр нарын зургаан хүнд 21 жилийн ял оноосныг зарим иргэд эсэргүүцэж байна \(24tsag.mn\)](http://www.24tsag.mn)

⁵³ [Ц.Мөнхбаяр нарын ялыг буурууллаа \(gogo.mn\)](http://gogo.mn)

⁵⁴ [“Гал үндэстэн”-д оноосон ял | www.baabar.mn | Шилдэг нийтлэлчдийн клуб](http://www.baabar.mn)

Ерөнхий дүгнэлт

Дээрх 10 жагсаал, цуглааны кэйс судалгааны үр дүнд үндэслэн судалгааны багийн зүгээс жагсаал, цуглааны гол 3 үе шатад хамаарах дараах ерөнхий дүгнэлтийг танилцуулж байна.

Жагсаал, цуглааны бэлтгэл үе шат: Зохион байгуулагдсан жагсаал, цуглаануудын тал нь урьдчилан төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажлыг хангаагүйгээр зохион байгуулсан байна. Жагсаал, цуглаан зохион байгуулагдах талаар холбогдох байгууллагад бүртгүүлээгүй, олон нийтэд мэдээлэл хүргээгүй, цаг үеийн нөхцөл байдлаа сайтар судлаагүй жагсаал, цуглаан зохион байгуулагдсанаас үүдэж олон төрлийн асуудал болон эрсдэлтэй нөхцөл үүсэх шалтгаан болжээ. Тухайлбал, зохион байгуулагч болон оролцогчид хуулийн хариуцлагад татагдах, эрүүл мэнд, аюулгүй байдлынхаа хувьд эрсдэлд өртөх, дэвшүүлсэн асуудал нь олон нийтийн анхааралд өртөхгүй өнгөрөх зэрэг эрсдэлүүд нь жагсаал, цуглааны бэлтгэлээ сайтар хангаагүйгээс үүдэж бий болж байна.

Жагсаал, цуглаан зохион байгуулагдах үе шат: Зохион байгуулагдсан жагсаал, цуглааны ихэнх нь тайван замаар зохион байгуулагдсан бөгөөд жагсаал, цуглааны үеэр үймээн самуун гараагүй, хурцадмал байдал үүсээгүй тохиолдолд уг жагсаал, цуглаан нь үндсэн зорилгодоо хүрч, шаардлагын хариугаа эергээр авахад чухал нөлөөтэй байна. Харин зохион байгуулагдаж буй үедээ үймээн самууны хэлбэрт шилжиж, эмх замбараагүй байдал үүсгэсэн 4 жагсаал, цуглааны хувьд цагдаа, хүчний байгууллагаар албадан тараагдах, олон нийтийн дэмжлэгийг алдах, зохион байгуулагч, оролцогчид дарамт, шахалтад өртөх гэх мэт олон эрсдэлтэй тулгарсан байна. Иймд жагсаал, цуглаан зохион байгуулагдах үед гол удирдах хүмүүс болон оролцогчид сэтгэл хөдлөлөө сайтар

хянаж, үг үйл хөдлөлдөө анхааралтай хандаж зохион байгуулалтыг сайтар хангах нь чухал байна.

Жагсаал, цуглааны дараах үе шат: Зохион байгуулагдсан жагсаал, цуглаануудын талд нь ямар нэгэн байдлаар хүний эрхийн зөрчлүүд үүсэж, холбогдох хууль, хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн байна. Хүний эрхийн зөрчил үүссэн нөхцөл байдалд нэг талаас жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчдын хариуцлагагүй байдал, хүний эрх, хууль, эрх зүйн холбогдолтой мэдлэг, мэдээлэлгүй байдал нөлөөлжээ. Үүний зэрэгцээ одоогийн хууль эрх зүйн зохицуулалтад шинэчлэл хийх, цагдаа, хууль хүчний байгууллагын зохион байгуулалт буюу хэлэлцээр хийх, баривчлах, мөрдөн шалгах ур чадваруудад хүний эрхийн мэдрэмжтэй арга барил эзэмшүүлэх асуудал зайлшгүй сөхөгдөн гарч ирж байна.